



ХОТ БАЙГУУЛАЛТ,  
БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН  
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2025 он

## АГУУЛГА

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.....	2
ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	2
ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2-3
ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	3-7
4.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.....	3-4
4.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.....	4-5
4.3.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	5-6
4.4.Салбарын хөгжлийн үзүүлэлт.....	6-7
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	7-9
5.1.Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.....	7-8
5.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.....	8-9
ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	9-11
6.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.....	9
6.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ.....	9-10
6.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.....	10-11
ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	11-20
7.1. Нэгдсэн дүгнэлт.....	11-20
7.2. Нэгдсэн санал, зөвлөмж.....	20
НАЙМ.ХАВСРАЛТУУД.....	21-128
8.1. Салбарын хөгжлийн үзүүлэлт биелэлт.....	21-31
8.2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт .....	31-37
8.3.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан .....	37-101
8.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.....	101-128

# ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2025.02.21

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал дүгнэлт өгч ажиллалаа.

## ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь Монгол Улсын 2024 оны 07-р сарын 10-ны өдөр баталсан “Засгийн газрын бүтцийн тухай хууль, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2024 оны 08-р сарын 28-ны 51 дүгээр тогтоолын дагуу яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн баталж дараах 8 тэргүүлэх чиглэл:

1. Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр
2. Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр
3. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын чиглэлээр
4. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр
5. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр
6. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр;
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр
8. Салбарын хяналтын чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцон ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, салбарын хөгжлийн 2024 оны үзүүлэлт, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны гүйцэтгэлийн бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 9 үзүүлэлтээр дүгнэв.

Шударга байдлын түвшний үнэлгээг Авлигатай тэмцэх газрын 2024 оны тайлангийн үнэлгээгээр тооцсон.

Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас гаргана.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2024 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад яамны ерөнхий үнэлгээ 91.0 буюу 4.5 оноотой байна.

### 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ДУНДАЖ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	98.5	0.6	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	60.9		
	3. Монгол Улсын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	91.3		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлт	93.6		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.2	0.2	4.5 /0.9/
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	97.6		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	80.9		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ:		91.1%	1.0	

## ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны жилийн эцсийн байдлаар байршуулсан яамны үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын Их хурал болон Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, тэмдэглэлийн нийт 308 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналтад авсан 308 заалтын 279 нь “үр дүн гарсан” буюу 100%, 15 заалт “хэрэгжих шатанд” буюу 70%-ийн хэрэгжилттэй, хугацаа болоогүй 14 заалт, нийт хэрэгжилтийн дундаж 98,5 хувьтай үнэлэгдэв.

### Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн

Бүгд		Шийдвэрийн төрлөөр										
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	166	8	17	9	2	4	1	47	71	71	3	
Заалтын тоо	308	21	42	13	3	6	1	64	137	137	17	
Үнэлгээ	Биелсэн /100%/	279	19	37	12	3	5	1	63	122	122	13
	Хэрэгжих шатанд /70%/	15	1	2	-	-	1	-	1	6	6	4
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	14	1	3	-	-	-	-	-	9	9	-
Үнэлгээ /хувь/	98,5	98,5	98,4	100	100	95	95	100	98,5	98,59	92,9	

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn).

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэлэл гаргуулж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/1849 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [/www.unelgee.gov.mn/](http://www.unelgee.gov.mn)-д баталгаажуулсан.

#### 4.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8-р сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүргийн хүрээнд 46 зорилтын хэрэгжилтийг 2024 онд хангуулж ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин 2024 оны жилийн байдлаар 60.9 хувьтай, “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэв. Үүнд: 100 хувьтай хэрэгжсэн 4, 90 хувьтай хэрэгжсэн 3, 70 хувьтай хэрэгжсэн 11, 50 хувьтай хэрэгжсэн 6, 30 хувьтай хэрэгжсэн 9, хугацаа болоогүй /ХБ/ 13 зорилт бүхий ажлууд байна.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний явцын үнэлгээ;

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулбал:

Хүснэгт 1

Үзүүлэлт	Үүнээс	ХБ
----------	--------	----

№		Зорилт	100%	90%	70%	50%	30%	0%		дундаж үнэлгээ /%/
1	ЗГҮАХХАХТ-ийн арга хэмжээ	46	4	3	11	6	9	0	13	<b>60.9</b>

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Хүснэгт-1.1

№1	Хөтөлбөрийн зорилтууд							
	Дугаар	хувь	Дугаар	хувь	Дугаар	хувь	Дугаар	хувь
1	1.1.1.1	100	2.1.1.24	70	3.3.3.3	ХБ	4.2.2.2	30
2	1.1.1.2	ХБ	2.1.1.35	ХБ	3.3.3.19	ХБ	4.2.3.9	30
3	1.1.3.2	ХБ	2.4.1.1	50	3.3.3.38	ХБ	4.2.4.3	50
4	1.1.3.3	100	2.4.1.2	30	3.4.3.4	70		
5	1.1.3.4	70	2.4.1.3	ХБ	3.4.3.5	ХБ		
6	1.1.3.7	30	2.4.1.4	70	3.4.3.7	70		
7	1.1.4.1	50	2.4.1.5	30	3.4.3.10	50		
8	1.2.1.2	100	2.4.1.6	30				
9	1.2.2.2	100	2.4.1.7	50				
10	1.3.1.1	70	2.4.1.8	70				
11	1.3.1.2	90	2.4.2.1	50				
12	1.4.1.5	70	2.4.2.2	30				
13	1.4.1.8	70	2.4.2.3	ХБ				
14	1.4.2.6	ХБ	2.4.2.4	70				
15			2.4.2.5	90				
16			2.4.2.8	90				
17			2.4.3.1	30				
18			2.4.3.2	30				
19			2.4.3.3	ХБ				
20			2.4.3.4	70				
21			2.4.3.5	ХБ				
22			2.4.3.6	ХБ				

Тайланг 2025 оны 01-р сарын 24-ны өдөр [monitoring@ags.gov.mn](mailto:monitoring@ags.gov.mn) хүргүүлсэн.

#### 4.3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 8 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.25 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 8 арга хэмжээнээс хэрэгжилт 100 хувьтай 3 арга хэмжээ, 90 хувьтай 4 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт /хувь/
1	2.3.2.17. БНПУ-н зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг	Барилгын ажлын гүйцэтгэл-70%	70

	үргэлжлүүлэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс/		
2	5.1.1.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих	Дэд бүтэц байгуулагдсан байршил-5	90
3	6.2.1.1."Залуус-1" төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажлыг үргэлжлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл-50%	100
4	6.2.1.2."Ногоон нуур 1008" төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл-100%	90
5	6.2.1.3."Солонго 1, 2" төслийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл-10%	100
6	6.2.2.1. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх /Чингэлтэй, Сонгинохайрхан/	Арга хэмжээний хэрэгжилт-38%	90
7	6.2.3.2."Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төслийг үргэлжлүүлэх /инженерийн байгууламж/	Дэд бүтцийн бүтээн байгуулалт-10	100
8	8.1.2.3. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих	Төслийн ажлын гүйцэтгэл90%	90
Нийт үнэлгээ			91.25%

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn)

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцүүлэн, тайланг 2024 оны 12-р сарын 30-ны өдрийн 01/2153 тоот албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д байршуулан, баталгаажуулсан.

#### 4.4. Салбарын хөгжлийн үзүүлэлт

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт /2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2020 он/	2024 он		Үнэлгээ /хувь/
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
1	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь	33,3	34	38.57	100
2	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	82,5	83	83,16	100
3	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	38	40	69,6	100
4	Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо, өссөн дүнгээр	6476	14476	48654	100
5	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдаж, ашиглалтад орсон орон сууц, айлын тоо өссөн дүнгээр	5,189	15189	20247	100
6	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдсон өрх, тоо өссөн дүнгээр	300	2300	16470	100
7	Барилгын материал, ус, эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго авсан орон сууцны барилга, тоо өссөн дүнгээр	-	-	3	100

8	Дулаалах төсөлд хамрагдсан нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилга, айлын тоо	5/300	27/2100	88/300	100
9	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж барилгажуулах төслийн хүрээнд шинээр ашиглалтад орсон орон сууц, айлын тоо	301	1500	3772	100
10	Шинээр байгуулагдсан үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэр, тоо	3	4	4+	100
11	Импортыг орлох, экспортыг дэмжих шинэ материал, бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	10	6+	70
12	Барилга угсралтын ажлын улирлын нөлөөллийг бууруулах судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	2	100
13	Инженер геологийн болон инженерийн бэлтгэл ажлын судалгаа, тоо	-	2	2	100
14	Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	2	100
15	Ногоон барилгын технологи нэвтрүүлэх гарааны компани, тоо	-	1	3	100
16	Барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ	3.7	4.1	3.3	90
17	Ногоон барилгын үнэлгээний систем	-	-	2	100
18	Ногоон гэрчилгээтэй барилга, тоо	-	-	3	100
19	Шинээр барьж ашиглалтад оруулсан Улаанбаатар хот болон аймгуудын цэвэрлэх байгууламж, тоо	5	8	10	100
20	Орон нутагт шинээр барьсан инженерийн шугам сүлжээний нийт урт, км	100	150	128,18	85,4
21	Шинээр баригдсан үерийн далан сувгийн урт, км	44	69	129	100
22	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, хувь	30	70	-	-
23	Ус дамжуулах, түгээх шугамын алдагдлын бууралт, хувь	18,6	10,0	6.0	70
24	Орлого болоогүй усны эзлэх хувийг бууруулах хувь	20,5	17,5	10.0	70
25	Удирдлага, хяналтын ухаалаг систем бүхий инженерийн дэд бүтцэд холбогдсон хот, аймгийн төв, тоо	2	3	2	70
26	Хот, суурин газарт шинээр болон шинэчлэн барьсан нийтийн халуун усны төв, тоо	634	642	639	70
Дүн					93.6

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт /2024 оны жилийн эцсийн байдлаар/-ийн биелэлтийг хавсаргав. /Хавсралт 1/

## **ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

### **5.1. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагч хянаж баталсан байна.

Монгол Улсын 2024 оны 07-р сарын 10-ны өдөр баталсан “Засгийн газрын бүтцийн тухай хууль, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн



газрын 2024 оны 08-р сарын 28-ны 51 дүгээр тогтоолын дагуу яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн баталж дараах 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

Барилга, хот байгуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 32 зорилтын 320 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 96.2%-тай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж байна.

**Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн Шууд захирагчийн  
2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ  
/зорилт тус бүрээр/**

№	Газрууд	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар %/						ХБ	Биелэлтийн дүн
				100	90	70	50	30	0		
1	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар	3	50	42	4	4					96.8
2	Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар	1	35	28	4	3					96.3
3	Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар	6	42	29	9	2	1			1	95.1
4	Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар	4	40	32	3	4	1				95.0
5	Төрийн захиргааны удирдлагын газар	6	50	40	6	2	2				95.6
6	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	4	23	20	3						98.7
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	4	43	31	11				1		95.1
8	Салбарын хяналтын газар	4	37	36			1				98.6
	Дүн	32	320	258	40	15	5	0	1	1	96.2

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn)

Тайлбар: Барилга, хот байгуулалтын яамны 2024 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав. /Хавсралт-2/

**5.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан.

Үүний дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилт, 7 үйл ажиллагааны биелэлтийг 26 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах шалгуурын биелэлтэд өгсөн үнэлгээ /2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт /хувиар/
<b>Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</b>			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	11	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	7	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	2	100
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	2	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	1	100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	2	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	1	100
<b>НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ</b>		<b>26</b>	<b>100</b>

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn)

## ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

### 6.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар 5 зорилтын 46 шалгуур үзүүлэлтийг баталсан.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангах нийт 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай бүрэн хэрэгжсэн байна.

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт /хувиар/
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	100
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	100
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	100
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	100
Нэгдсэн үнэлгээ		46	100

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn)

### 6.2. Шилэн дансны танилцуулга

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9.8-д заасны дагуу шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ гэж заасны дагуу Сангийн яамнаас нэгдсэн үнэлгээ хийгдэх ч төсвийн

ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын шилэн дансны хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлсэн үнэлгээг оруулж тооцсон болно.

Барилга, хот байгуулалтын сайдын багцын харьяа байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, тайлан, мэдээг хуулийн хугацаанд үнэн, зөв, иж бүрэн байршуулж байгаад болон хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ”-ний нэгтгэлийн дундаж 97.6 хувийн үзүүлэлттэй байна.

**Төсвийн ерөнхий захирагч, түүний харьяа байгууллагуудын  
шилэн дансны нэгдсэн мэдээлэлд өгсөн үнэлгээ  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/**

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлэгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжилт хувь /%/
			Хугацаанд аа	Хугацаа хоцроосон			
1	Сайд /төсвийн ерөнхий захирагч/	144	135	6	0	3	95.8
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	171	159	6	0	6	96.5
3	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ	109	106	1	0	2	99.0
4	Төрийн орон сууцны корпораци	157	152	3	0	2	98.0
5	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	171	167	2	0	2	98.8
6	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	171	167	2	0	2	98.8
7	Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	171	154	12	0	5	93.0
8	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл	155	151	3	0	1	98.0
9	Ногоон нуур 1008 айлын Орон Сууцны Төсөл	155	153	1	0	1	99.3
10	Солонго-2	155	149	5	0	1	96.7
11	Солонго-1	155	149	5	0	1	96.7
12	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл	155	155	0	0	0	100
13	Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл	155	152	2	0	1	98.7
<b>Нийт</b>		<b>2024</b>	<b>1949</b>	<b>48</b>	<b>0</b>	<b>27</b>	<b>97.6</b>


### 6.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.7-д заасан үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газраас гаргаж олон нийтэд мэдээлдэг.

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу төрийн байгууллагуудын 2024 оны шударга байдлын үнэлгээг хийсэн байна.

Шударга байдлын үнэлгээ нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээ юм.

График 8. Яамдын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын яам 2024 онд 80.9 оноогоор 16 яамнаас 4-р байрт орсон нь улсын дунджаас 8.3 оноогоор өндөр үзүүлэлттэй байна.

## ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ


### 7.1. Нэгдсэн дүгнэлт

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь 2024 оны Бодлогын баримт бичгүүдийн 4 баримт бичиг, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдийн 2 баримт бичиг, байгууллагын нээлттэй байдлын 2 арга хэмжээ, нийт 8 баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, журамд заагдсан хугацаанд нь Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) баталгаажуулан, албан тоотой холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх 8 баримт бичгийн үнэлгээ, АТГ-аас гаргасан шударга байдлын түвшний үнэлгээ /2024 он/, нийт 9 баримт бичгийн дунджаар байгууллагын жилийн эцсийн тайлангийн үнэлгээг гаргалаа. Дундаж үнэлгээ 91.0 буюу 4,5 оноотой байна.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй /4/ төслүүдийн хэрэгжилт, аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан /22/ гэрээний биелэлтүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Тайланг хавсаргав. /Хавсралт 1, 2, 3, 4, 5/

3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь жилийн эцсийн байдлаар дараах бүтцийн хүрээнд төлөвлөгдсөн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТШЗ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жилийн эцсийн байдлаар тусгагдсан арга хэмжээ чиглэл тус бүрээр графикаар үзүүлэв.



4. Монгол Улсын барилгын салбарын статистик, тоон мэдээлэл 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах түвшинд хэрэгжсэн байна. Үүнд:

- Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 9.2 их наяд төгрөг болж, 8.1 (88.8%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 1.0 (11.2%) их наяд төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна. Барилга угсралт, их засварын ажил 2024 онд өмнөх оноос 1.2 (14.8%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 733.3 (9.9%) тэрбум төгрөг, гадаадын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 447.2 (77.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.
  - Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 80.0 их наяд төгрөгт хүрсний 2.6 (3.3%) их наяд төгрөгийг Барилгын салбар бүрдүүлж байна. Салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 оны мөн үеэс 1.2 (90.5%) их наяд төгрөгөөр, 2022 оны мөн үеэс 821.8 (46.0%), өмнөх оны мөн үеэс 335.8 (14.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2 605.6 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 1 016.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.9 (10.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.
  - Ажиллах хүчний судалгааны 2024 оны 4 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд Барилгын салбарт 96.1 мянган ажиллагчид ажиллаж байна. Үүнээс: Улаанбаатар хотод 73.6 (76.5%), баруун бүс 7.0 (7.3%), хангайн бүс 8.5 (8.8%), төвийн бүс 5.2 (5.4%), зүүн бүс 1.7 (1.8%) мянган ажиллагчид тус тус ажиллаж байна.
  - Барилгын салбарын нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 2237.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 360.9 (19.2%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 4.7 (0.2%) мянган төгрөгөөр буурчээ.
5. 2024 онд Үндэсний аудитын газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас бодлогын баримт бичгүүдэд хийсэн аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдийн биелэлтийг гарган хүргүүлж ажилласан байна.
6. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

#### **Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр:**

1. "Алсын хараа 2050" улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын 9 арга хэмжээг тусгуулсан. Үүнд: Төрийн захиргааны удирдлагын газар 1 зорилт 1 арга хэмжээ, Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар 1 зорилтын 1 арга хэмжээ, Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар 2 зорилт 7 арга хэмжээг тус бүр тусгуулсан. Хэрэгжилтийн тайланг 2024.09.19-ний өдөр 01/587 тоот бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2024.09.18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврыг хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024.10.11-ний өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан. Төлөвлөгөөнд туссан 47 төсөл арга хэмжээний явцын тайлан мэдээг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024.11.12, 2024.12.15-ны өдрүүдэд хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2024.12.16-ны өдрийн 01/1793 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

3. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг боловсруулж, зорилтот бүлгийн иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, цогц тогтолцоог бий болгох шаардлагатай гэж дүгнэн, холбогдох хуулийн төслийн хамт Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар "Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл"-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлүүлсэн.

4. Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1,287.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 10,983 зээлдэгчид олгосон.

5. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж Улсын 2024 оны төсөвт 50.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагааны зориулан баталсан бөгөөд Хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2023 оноос батлан даалт гаргадаг болсноос хойш 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батлан даалт хийгээд байна. Үүнээс 2024 онд ипотекийн 1211 зээлд 24.5 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргаад байна. Батлан даалтыг хамгийн их 196 Орхон, 132 Дорнод, 110 Баянхонгор, 76 Сүхбаатар, 71 Өвөрхангай, 69 Говь-Алтай, 63 Сэлэнгэ, 61 Дархан-Уул аймгуудад тус тус гаргаад байна.

6. “Монголын орон сууцжуулалтын ирээдүй – 2024” олон улсын форумыг 2024.10.28-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банктай хамтран зохион байгуулав.

7. Тусгай зөвшөөрлийн цахим систем /www.mcis.gov.mn/-ээр дамжуулан 2024.12.09-ны өдрийн байдлаар нийт 1913 хүсэлтийг хүлээн авч, давхардсан тоогоор барилгын ажил гүйцэтгэх 1465, зураг төсөл боловсруулах 303, өргөх байгууламжийн 47, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх 94 тусгай зөвшөөрөл олгосон байна.

8. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан бүртгэлийн маягтын дагуу улсын хэмжээнд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан, ашиглалтад оруулсан барилга байгууламжийн 2023 оны жилийн мэдээг 2024.01.09-ний өдрийн 3/95 тоот албан бичгээр, 2024 оны I улирлын мэдээг 2024.04.05-ны өдрийн 03/1079 тоот албан бичгээр, II улирлын мэдээг 2024.06.21-ний өдрийн 03/2043 тоот албан бичгээр, III улирлын мэдээг 2024.10.07-ны өдрийн 03/786 тоот албан бичгээр хүргүүлсэн.

#### **Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр:**

1. Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанаас “Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүсийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйчилгээний тендер шалгаруулалтын зарлаж, гүйцэтгэгчээр “Гоби Травэл” ХХК ХХК шалгарч, 2024.07.03-ны өдөр ХХББАХЗ/20240101003 дугаартай гэрээг байгуулсан. Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүсийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төслийг МАЭ-ийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2024.11.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох санал, зөвлөмжийг тусгасан. Батлагдсан ажлын даалгаврын дагуу 2024.12.20-ны салбарын Шинжлэх ухааны техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

2. “Сэлбэ сэргэлт” төслийн усны барилга байгууламж, зам, гүүр, тохижилтын ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ болон “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын орон тооны бус экспертүүдээр хянан баталгаажуулж, магадлалын нэгдсэн дүгнэлт гарч дууссан.

3. “Шинэ Зуунмод” хотын эрх зүйн орчин, институтийн тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдуулан сургалт, урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулж, бүтээн байгуулалтад тулгарч буй сорилт, зорилтыг тодорхойлох талаарх саналыг төслийн багт хүргүүлж, төслийн эхний тайланг 2024.05.01-нд хүлээн авсан.

4. “Эмээлт эко аж үйлдвэрлэлийн парк”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/-ны Шинжлэх ухааны техник, технологийн зөвлөлийн 2024.05.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдэн, 01-3/2024 тоот шийдвэр гарсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 114 дүгээр тушаалаар зураг төсөлд экспертиз хийх ажлын хэсгийг байгуулж, 2024.07.05-ны өдрийн 1520/2024 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан.

5. Нийслэл Улаанбаатар хотод байгуулсан улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, Улаанбаатар хотын дагуул 3 хотын асуудал, 20 минутын хотын зарчим зэрэг асуудлуудыг тусган боловсруулахаар зааж тусгуулсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 2 үндэсний хороо, 16 яам, 6 дүүрэг, нийслэлийн 33 агентлагаас санал авч тусгасан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг “Монголын архитектуруудын

эвлэл” ТББ-ын дэргэдэх Архитектур, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2024.11.29-ний өдөр хэлэлцүүлсэн.

6. Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн болон амины орон сууцанд ипотекийн зээл олгох боломжтой бүсийн иргэдийн орон сууцны хэрэгцээ шаардлага нөхцөл байдлын судалгаа хийх ажлын даалгаврыг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 2024/145 дугаарт ажил гүйцэтгэх гэрээг Тэнхлэг зууч ХХК-тай байгуулан ажилласан. Тус судалгааны хүрээнд түүврийн аргаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19,24, Чингэлтэй дүүргийн 15,21,22 дугаар хороонуудад тус тус зохион байгуулж нийт 334 өрхийн 205 өрхөөс тоон мэдээлэл судалгааны аргаар хийж судалгааны ажлын тайланг 024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч, гэрээг дүгнэсэн.

### **Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын чиглэлээр:**

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 54 дүгээр тушаалаар батлагдсан журмын хүрээнд “Барилгын нэгдсэн систем” <https://mcis.gov.mn/mn>-д барилгын нэг маягийн зураг төслийн баримт бичгийг хүлээн авах, цахим архив, хадгалалт, нийтэд түгээх, хэрэглэх боломж бүхий мэдээллийн санг үүсгэж, хөгжүүлэлт, баяжуулалтыг хийж ажиллаж байна. БХБС-ын 2019 оны 54 дүгээр тушаалаар батлагдсан журмын хүрээнд “Барилгын нэгдсэн систем” <https://mcis.gov.mn/mn>-д барилгын нэг маягийн зураг төслийн баримт бичгийг хүлээн авах, цахим архив, хадгалалт, нийтэд түгээх, хэрэглэх боломж бүхий мэдээллийн санг үүсгэж, хөгжүүлэлт, баяжуулалтыг хийж ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар тус Барилгын нэгдсэн мэдээллийн системийн “норм норматив” гэсэн цэсэд шинээр дараах төрлөөр ангилан нийт 132 зураг төсөл, төсвийн мэдээллийг байршуулсан байна. Үүнд:

- “нэг маягийн зураг” -30;
- “тухайлсан барилга” - 42;
- “шугам сүлжээ” - 35;
- “хот байгуулалтын баримт”-14;
- “усны барилга байгууламж” -11 зураг төсөл, төсвийн мэдээлэл.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 68/A/74 дугаартай Комисс томилох тухай тушаалаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан “Буянт-Ухаа спорт цогцолбор”-ыг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, 2024.12.06-ны өдрийн 2024/22 дугаартай дүгнэлтээр баталгаажсан.

3. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийн нийт хэрэгжилт 2024.12.06-ны байдлаар 75%-тай явж байна.

4. Солонго-1, Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл”-ын барилга барих бэлтгэл ажил 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж, 2024 оны 04 дүгээр сарын 18-ний барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл гарсан.18 блок барилгын төмөр бетон каркас цутгалтын ажил бүрэн дуусаж, 5 блок 9 давхар, 12 блок 8 давхрын каркас цутгалтын ажил гүйцэтгэж, 2 дугаар ээлжийн 31 блок барилгаас энэ жил 16 блок барилгын суурийн ул бетон хийж үүнээс 11 барилгын суурийн бетон цутгалт, нэгдсэн гражийн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажил төслийн хэмжээнд 35 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

5. Барилгын салбарт барилгын мэдээлэлтэй загварчлал /bim/ -ыг нэвтрүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам /road map/ боловсруулах зөвлөх буюу “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ёнсэй их сургуулийн профессор Sang-Но Lee-тэй 2023.08.18-ний өдрийн №2023/154 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ-аас /BIM/ Барилгын салбарт нэвтрүүлэх ажлыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг судлах судалгааны ажлыг дуусгаж эцсийн тайлан ирүүлсэн.

6. Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдааныг хагас жилийн хугацаанд 5 удаагийн хурлын төлөвлөгөөг зөвлөлийн даргаар батлуулж 26 асуудал хэлэлцүүлээд байна.

7. “Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг”-ийг шинэчлэн Барилга, хот байгуулалтын сайдын 2024.05.21-ний өдрийн 95 дугаар тушаалаар баталсныг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 2024.06.03-ны өдрийн 6841 дугаарт бүртгэгдсэн.



8. 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2024” -ийг “Аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагаа” уриатайгаар Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд 21 аймаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 400 гаруй төлөөлөл оролцсон.

#### **Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр:**

1. “Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн тогтолцооны дэлхийн дүн шинжилгээ, үнэлгээ-2024” дүн шинжилгээний тайлан нь дэлхийн улс орнуудад ундны ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, гарын эрүүл ахуйг хангахад чиглэсэн арга хэмжээний өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилготой. Энэхүү тайлан нь засаглал, хяналт-шинжилгээ, хүний нөөц, санхүүжилт гэсэн 4 бүлэг, 597 асуумжтай. Үнэлгээний тайланг Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Усны газар, Хот суурны усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо, Ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Шинжлэх ухаан техникийн их сургууль, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, Ус сувгийн удирдах газар болон манай яам хамтран боловсруулж, 2024.10.14-нд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагад цахимаар хүргүүлсэн.

2. Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг “Залуус 2” хорооллын гадна ус хангамжийн Ф200-Ф250мм-ын голчтой 3,35 км, Ф200-Ф250 мм-ийн 2,115 км шугам хоолойн ажлыг 2024.10.30-нд улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.

3. Орхон аймгийн “Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил”-ын хүрээнд 2Ф273мм-ын дулааны 0,5 км, Ф219мм цэвэр усны 0,497 км урттай шугам, ус дулаан дамжуулах төвийн барилгыг 2024.06.04-нд ашиглалтад оруулсан.

4. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын явц 85,5%-тай. Төслийн хэрэгжилт 80%-тай байна.

5. “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд цэвэр усны 9,2 км шугам сүлжээний болон 4662 ш ухаалаг тоолуур суурилуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

6. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг шинээр барих төслийн хүрээнд үйлдвэрийн технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 66%-тай. Ус дамжуулах системийн хувьд төслийн нийт барилга угсралтын ажил 63%-тай байна.

7. Орон сууцны тухай хуулийн төслийн зөвлөх үйлчилгээний гэрээг “Кэй вишн” ХХК-тай 2024.12.02-ны өдрийн 2024/193 дугаартай гэрээ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.10-ны өдрийн дугаар 123 тушаалаар хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

#### **Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр:**

1. “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлуулсан. “Мэргэшлийн зэрэг олгох тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/66 дугаар тушаалаар /мэргэжлийн зэрэг 530 мэргэжилтэнд, 427 мэргэжилтэнд/ мэргэшлийн зэргийг олгов.

2. Салбарын төрийн албан хаагчдыг удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн-4, ахлах түшмэлийн-5, шинээр томилогдсон мэргэшүүлэх багц сургалтад 8 албан хаагчийг сургасан. “Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал” хэлэлцүүлэгт 10 албан хаагчийг хамруулсан. Төрийн албаны уламжлал, шинэчлэл эрдэм шинжилгээний бага хуралд -3, Салбарын стратеги боловсруулах сургалтад 5 албан хаагчийг хамруулсан.

3. Салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө, төсвийн төслийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Орон тооны бус салбар Зөвлөлийн даргаар батлуулсан. Жендэрийн Үндэсний хороонд тайланг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/233 тоот албан бичгээр хүргүүлэв.

4. Гамшгийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Барилга, хот байгуулалтын шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 50 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.

5. Улсын онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай” Албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Барилга, хот байгуулалтын сайдаар 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан. Улсын онцгой комиссын “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай” 2024 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг гарган uok@nema.gov.mn хаягаар хүргүүлсэн.

6. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, түүний харьяа байгууллага, албан тушаалтанд 2024 оны хагас жилийн байдлаар нийтдээ 2477 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг иргэдээс ирүүлсэн байна. Шийдвэрлэлт 98%. Тайланг 2024.07.8-ны 3/2227 албан тоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

7. Тайлант хугацаанд төрийн болон аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нууцын зэрэглэлтэй албан бичгийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж, хариу бичгийн боловсруулалт, хадгалалтад хяналт тавьж хариу албан бичгийг холбогдох байгууллагад нууцын зэрэглэлтэй илгээсэн байна. Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудын нууц хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, буцаан төвлөрүүлэх ажлыг хийсэн. Тус яаманд 2023 онд бусад байгууллагаас ирүүлсэн албан бичиг, бусад байгууллагад илгээсэн албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу архивлан хадгалсан.

8. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд 280 мэдээ мэдээллийг бэлтгэж яамны вэб сайт болон харьяа байгууллагуудын вэб сайт, цахим хуудсаар түгээж ажиллав. Үүнд:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам- 86 мэдээлэл
- “Төрийн орон сууцны кропори” ТӨХХК- 109 мэдээлэл
- “Барилга хөгжлийн төв” ТӨААТҮГ- 85 мэдээлэл

Яамны хэмжээнд нийт 12 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

#### **Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:**

1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2025 оны төсвийн хязгаарт тусгах урсгал зардлын саналыг 24.9 тэрбум төгрөгөөр нэгтгэн боловсруулж Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1851 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /ТЭЗ/-ын багцын 2025 оны төсвийн төсөлд тусгах урсгал зардлын саналыг 76,5 тэрбум төгрөгөөр нэгтгэн боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 7 төслийн хүрээнд гадаад зээлээс 509,085.0 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т 48,741.2 сая төгрөгийн саналыг холбогдох төслийн танилцуулгын хамт 2025 оны төсвийн хязгаарт хүргүүлсэн.

3. Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2024 оны батлагдсан төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийн саналыг Сангийн яаманд хүргүүлж батлуулсан. 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 03/1540 дугаартай албан бичгээр БХБЯ-ны сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулах, арга хэмжээ хооронд гүйлгэх хүсэлтийг хүргүүлэн холбогдох өөрчлөлтийг хийлгэсэн. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга 2024 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 03/92 дугаартай албан бичгээр, 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1139 тоот, 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/1224 тоот албан бичгүүдээр төсвийн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан.

4. 2024 онд тус Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад тусгагдаж худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар батлагдсан нийт 77 төсөл, арга хэмжээнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар 69 төсөл, арга хэмжээний тендерийг цахимаар зохион байгуулсан буюу худалдан авах ажиллагаа 90 хувьтай хэрэгжсэн.

5. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дараах 7 төслийн хүрээнд 2024 оны хөрөнгө оруулалтад 623,314.81 сая төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлд өссөн дүнгээр 591,210.91 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж, шийдвэрлүүлсэн. Хэрэгжилтийн хувь 95% байна.

6. Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан журмын дагуу 2024 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 6 төслийн хүрээнд нийт 655,624.39 сая төгрөгийн импортоор оруулж ирэх бараа материалын жагсаалтыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан.

7. Барилга, хот байгуулалтын салбарт 2024 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 7 төсөл хэрэгжүүлж байгаа ба Төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 23, 24, 25, 26, 27 дугаар тушаалаар мөн Төслийн захирлуудыг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны Б/31 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн батлуулсан. Барилга, хот байгуулалтын салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж төслүүдээс 7 төслийн, Төслийн удирдах хорооны хурлыг 28 удаа зохион байгуулсан. Төслийн удирдах хороооос нийт 31 үүрэг даалгавар өгөгдсөн ба шийдвэрийн биелэлт 90 хувьтай байна.

8. 2024 онд хэрэгжүүлэх нийт 1,145,3 тэрбум төгрөгийн 405,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 179 төсөл, арга хэмжээнээс 2024 онд дуусах 84 төсөл, арга хэмжээнээс 2024 оны эцсийн жилийн байдлаар нийт 70 төсөл, арга хэмжээ улсын комисст хүлээлгэн өгсөн.

9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайланд хийсэн хяналт шалгалтын дүн, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нийт 25 мэдээллээс жилийн эцсийн байдлаар 25 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан, хэрэгжилтийн хувь 100%.

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:**

1. Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн

2. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2024 онд хэрэгжүүлэх 69 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан, 2024.06.27-ны өдрийн 2/2144 албан тоотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

3. Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл арга хэмжээний 8 заалтын биелэлт болон Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн хүснэгтийн дагуу биелэлтийг нэгтгэн хагас жилийн байдлаар 60 хувьтай үнэлж 2024.6.14-ний 02/1973 тоотор болон цахим хаягаар нотлох баримтын хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаарх хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулан, Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн.

4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-т туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 26 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 83.1 хувьтай “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдэж дүгнэлт зөвлөмж гарган, хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.07.30-ны өдрийн 01/41 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.

5. Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан журмын цагалбарын хугацаанд цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д 7-р сарын 01-ны дотор баталгаажуулж тайланг 2024.06.27-ны өдрийн 02/2114 тоотор хүргүүлсэн. Сар бүр биелэлтийг гарган баталгаажуулж ажилласан.

6. Яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн тайланг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн 01/597 албан тоотор Засгийн газрын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд хүргүүлсэн.

7. 2024 онд Үндэсний аудитын газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас бодлогын баримт бичгүүдэд хийсэн аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн дараах зөвлөмжүүдийн биелэлтийг гарган хүргүүлж ажилласан. Үүнд:

- Яамны 2022 оны нэгдсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 03-р сарын 05-ны өдрийн 03/703 тоот албан бичгээр хүргүүлсэн.
  - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 01/622 тоот албан бичгээр ирсэн яамны 2023 оны нэгдсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн 5 зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10-р сарын 30-ний өдрийн 03/1097 тоот албан бичгээр хүргүүлсэн.
  - Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын мөрөөр өгсөн 2 зөвлөмжийн хүрээнд 2024 оны 12-р сарын 19-ны өдрийн 03/1867 тоот албан бичгээр хүргүүлсэн.
  - “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн биелэлт хийсэн аудитын мөрөөр өгсөн 1 зөвлөмжийн хүрээнд 2024 оны 12-р сарын 19-ны өдрийн 03/1867 тоот албан бичгээр хүргүүлсэн.
  - Монгол Улсын ерөнхий Аудиторын 2024 оны 695 тоот албан бичгээр ирсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын мөрөөр өгсөн 3 зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөөг 5 арга хэмжээтэйгээр төлөвлөж биелэлтийг 2024 оны 12-р сарын 19-ны өдрийн 03/1867 тоот албан бичгээр хүргүүлсэн.
8. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2024 оны төлөвлөгөөнд 4 арга хэмжээ төлөвлөн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж ажиллалаа. Үүнд:
- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа
  - Яамны 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа
  - “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн үйл ажиллагаа
  - Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2024 оны хэрэгжилт.

### **Салбарын хяналтын чиглэлээр:**

1. Засгийн газрын яхэрэг эрхлэх газарт 2023.11.01-ний өдрийн 1/3964 тоот албан бичгээр 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг хүргүүлж, ЗГ-ын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлуулан “Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 399 объектын жагсаалт”-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 09 дүгээр тушаалаар батлуулсан.
2. Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 09 дугаар тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09 дүгээр удирдамжийн дагуу 17 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр тусгагдсанаас 11 аж ахуйн нэгж, байгууллага, 4 төслийн нэгжийн 132 барилга байгууламжид хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 164 зөрчил илрүүлснээс 137 арилгуулж, 142 заалт бүхий 8 албан шаардлага, 53 заалт бүхий 3 зөвлөмж, 3 эрх бүхий албан тушаалтны даалгавар, 16,500.000 төгрөгийн шийтгэл ногдуулж, барагдуулсан, 1 түр зогсоосныг дуусгавар болгож битүүмж лац, ломбыг авсан.
3. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-00/08 дугаар удирдамжийн дагуу 89 иргэн, 630 аж ахуйн нэгж байгууллагын 719 барилга байгууламжид хяналт шалгалт хийхэд 2587 зөрчил илрүүлэн 1975 зөрчлийг арилгуулж, 890 заалт бүхий 193 албан шаардлага, 28 акт, 160 дүгнэлт, 756 заалт бүхий 97 зөвлөмж, 29 иргэн, 47 аж ахуйн нэгжид эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 462,400.00 төгрөгийн шийтгэл ногдуулан 394,400.000 төгрөгийг барагдуулсан.
4. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-00/12 дугаар удирдамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд 2118 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын шинээр баригдаж буй 822, ашиглагдаж байгаа 1296 барилгад хяналт шалгалт хийж гүйцэтгэн 12878 зөрчил илрүүлэн 8990 зөрчлийг арилгуулж, 107 албан шаардлага, 49 дүгнэлт, 2653 зөвлөмж, 3 акт, 11 иргэн, аж ахуйн нэгжид эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 72,000.000 төгрөгийн шийтгэл ногдуулан 62,000.000 төгрөгийг барагдуулж, 1158 барилгын зураг төсөлд хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлт, 1962 налуу зам, 984 тэмдэг тэмдэглэгээ, 942 хөтөч зам, 940 ариун цэврийн өрөө, 865 авто зогсоол тус тус хийлгүүлсэн.

5. Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 87 дугаар тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-0005 дугаар удирдамжийн дагуу арматур импортлогч 47 аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд 21 зөрчил ирүүлэн 7 арилгуулж, 15 заалт бүхий 14 зөвлөмж, 6 заалт бүхий 14 албан шаардлага, 7 аж ахуйн нэгжид эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 35,000.000 төгрөгийн шийтгэл ногдуулж, барагдуулж, хэрэгжилтийг хангуулсан.

6. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02-00/04 дугаар удирдамж, "Лифтний аюулгүй байдлыг хангуулах тухай" 02-00/01 дугаар албан даалгаврын дагуу өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөл бүхий 79 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 315 лифт буюу 6315 лифтний хонгилын хаалганы аюулгүй байдлыг хангуулж ажилласан.

7. 2024 онд 380 лифт, 14 эскалатор, 300 кран, 713 барилгын өргүүр, 267 манипулятор кран, 22 бетон зуурмагийн шахуургат төхөөрөмж, 113 сагстай өргөгч зэрэг нийт 1809 өргөх байгууламжийг улсын бүртгэлд шинэчлэн бүртгэсэн.

8. Засгийн газрын "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09 дүгээр удирдамжийн дагуу 7 төлөвлөгөөг буюу 9 аж ахуйн нэгж, 4 төслийн 92 объектод хяналт шалгалтыг хийж нийт 3.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ, 5 албан шаардлага, 3 зөвлөмж, 20 үүрэг даалгаврыг өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

## 7.2. Нэгдсэн санал, зөвлөмж

1. Орон сууцны тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл/, Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж дуусган Улсын Их Хуралд өргөн барьж, чуулганаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах, 2025 оны төлөвлөгөөнд тусгах;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний бислэлтийг ирүүлэхдээ тайлант хугацаанд хэрэгжсэн арга хэмжээнүүдийн үр нөлөөг товчоор дурдаж, Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.8-д зааснаар гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

3. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 0-50%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах яамны газар, хэлтсийн дарга нарт даалгах;

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээс "гүйцэтгэл нь үргэлжилж байгаа" арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллах;

5. Шилэн дансны тухай хуулийн хугацаанд багтаан шаардлага хангасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт даалгах;

6. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхөд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тоо болон чанараар тодорхойлж, тухайн шалгууртай үнэлэх боломжтойгоор, бодитой үр дүнд хүрэхээр төлөвлөгөөг төлөвлөхөд анхаарч ажиллах.

7. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 2021-2024 онд хэрэгжиж дуусаж байгаа тул Төрийн албаны тухай хуулийн 55.3 Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ заалтын биелэлтийг ханган ажиллах.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Төмөрхүү

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын дарга

Х.Ган-Очир

## НАЙМ. ХАВСРАЛТУУД

### 8.1. Хавсралт-1

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2020	2024 он				Хэрэгжилт
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Тайлбар	
1.	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь	33.3	34	38.57	5.27	<p>2021 онд Инженерийн бүрэн хангамжтай орон сууц гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 4909, 10000 айлыг инженерийн дэд бүтцэд холбох ажлын хүрээнд 4256 орон сууц, ашиглалтын шаардлага хангахгүй барилга 2266, НОСК-221 орон сууц, зах зээлийн 47116 орон сууц баригдсан.</p> <p>2022 оны жилийн эцсийн байдлаар нийслэлд 14184 айлын орон сууц, орон нутагт 3294 айлын орон сууц нийт 17478 орон сууц шинээр ашиглалтад орсон.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 2021-2023 онд нийт 7692 айлын орон сууц ашиглалтад орж, төрийн болон орон нутгийн түрээсийн 6170 айлын орон сууцны сан бүрдүүлж, нийслэл болон орон нутагт 2021 онд 17478, 2022 онд 23201, 2023 онд 19196, 2024 онд 19790 нийт 79665 айлын орон сууц шинээр ашиглалтад орсон байна.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлд 14578 айлын орон сууц, орон нутагт 4618 айлын орон сууц нийт 19196 орон сууц шинээр ашиглалтад орсон.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар нийслэлд 14950 айлын орон сууц, орон нутагт 4840 айлын орон сууц нийт 19790 орон сууц шинээр ашиглалтад орсон.</p>	100
2.	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	82.5	83	83.16	0.66	ХСУХАТАҮЗХороо нь хуульд заасан чиг үүргийн дагуу зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хүрээнд тайлан мэдээнээс гаргадаг. Харин 5 жилд нэг удаа Үндэсний статистикийн хорооноос Улсын хэмжээнд судалгаа явуулдаг.	100
3.	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжа ар хангагдсан хүн амын эзлэх хувь	38	40	69.6	31.6	ХСУХАТАҮЗХороо нь хуульд заасан чиг үүргийн дагуу зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хүрээнд тайлан мэдээнээс гаргадаг. Харин 5 жилд нэг удаа Үндэсний статистикийн хорооноос Улсын хэмжээнд судалгаа явуулдаг.	100

4.	Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо, өссөн дүнгээр	6476	14476	48654	42178	2021 онд 13,292 иргэн, 2022 онд 7,847 иргэн, 2023 онд 8,889 иргэн, 2024 онд 12,150 нийт 42,178 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хоёрдугаар хавсралтаар баталсан ипотекийн зээлд хамрагдсан 6,476 иргэдийн суурь тоог 42,178 иргэнээр нэмэгдүүлж 2024 оны эцсийг байдлаар өссөн дүнгээр 48,654 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.	100
5.	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдаж, ашиглалтад орсон орон сууц, айлын тоо өссөн дүнгээр	5.189	15189	20247	15.058	2024 оны байдлаар төвийн зургаан дүүргийн нутаг дэвсгэрт 16 байршил 41 хэсэгчилсэн талбайд 38 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,247 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд 3,404 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн.	100
6.	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдсон өрх, тоо өссөн дүнгээр	300	2300	16470	16170	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалын хүрээнд Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулж иргэд, олон нийтэд үзүүлэх нийгмийн болон төрийн үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлж нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэхээр тусгагдсан. Үүний хүрээнд Сэлбэ дэд төв (158 га) хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Баянхошуу дэд төв (325 га) хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг НИТХ тэргүүлэгчдийн 2015 оны 198 тогтоолоор баталж, Сэлбэ дэд төвд 6.7 км авто зам, 5.3 км цахилгаан холбоо, 9.97 км дулаан хангамж, 19.78 км ус хангамж, ариутгах татуурга, 2.4 км үерийн хамгааллын далан суваг, 3.01 га тохижилт, 150, 240 хүүхдийн хоёр цэцэрлэг, 1000 м3 усан сан, 24 м, 30 м, 60 м гурван гүүр, дулааны станц, мэдээлэл холбооны төв, бизнес инкубатор, сургалтын төв, дэд станц, Баян дэд төвд 7,42 км авто зам, 7 км цахилгаан холбоо, 15 км дулаан хангамж, 23,8 км ус хангамж, ариутгах татуурга, 9,97 км үерийн хамгааллын далан суваг, 4.65 га тохижилт, 150, 240 хүүхдийн хоёр цэцэрлэг, 1000 м3 усан сан, 2 га	100

						цэцэрлэгт хүрээлэн, мэдээлэл холбооны төв, спорт цогцолбор, олон нийтийн хөгжлийн төв, бизнес инкубатор, сургалтын төв, дэд станцын бүтээн байгуулалтуудыг хийж дууссан. 2021 онд 3294, 2022 онд 3718, 2023 онд 4618, 2024 онд 4840 нийт 16470 өрх айлын орон сууц ашиглалтад орж, инженерийн хангамжид холбогдсон байна.	
7.	Барилгын материал, ус, эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго авсан орон сууцны барилга, тоо өссөн дүнгээр	-	-	3	3	Кингспан ХХК-ийн эрчим хүчний хэмнэлттэй ногоон бүтээгдэхүүндээ “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” авах хүсэлтийг дэмжин БОАЖ-ийн сайдад 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/3407 тоотор уламжилснаар тус компанид 2021 онд “Ногоон гэрчилгээ” олгосон. 1. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Барилгын салбар дахь стратегийн түншлэл” төсөлд эрчим хүчний тооцоолуурын программын тухай 2023.01.25-ны өдрийн 9/279 тоотор мэдээлэл хүргүүлэв. 2. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан А/257, А/252 дугаар тушаалаар баталсан “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ын хэрэгжилтийг 2022, 2023 оны байдлаар гарган ирүүлэхийг хүсч “БХТ” ТӨААТҮГ-т 2023.03.14-ний өдрийн 3/844 тоот албан бичиг хүргүүлэн мэдээлэл авч, холбогдох танилцуулгад хавсаргав. 2022 оны 10 дугаар сараас хойш Халаалт, агаар сэлгэлтийн 84 эксперт, инженерүүдэд 2 удаа сургалтыг зохион байгуулсан. Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээг барилгын ажлын зураг төсөлд олгож, бүртгэлжүүлсэн. - 2022 онд 315 зураг төсөл - 2023 онд 585 зураг төсөл - 2024 онд 728 зураг төсөл	100
8.	Дулаалах төсөлд хамрагдсан нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилга, айлын тоо	5/300	27/2100	88/300	83	Нийслэл орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 83 орон сууцны барилгын гадна ханын дулаалга хийхээр зураг төсөл нь магадлал хийгдсэн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны төсөвт Германы олон улсын байгуулагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын орон сууцны барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслийн гэрээний дагуу 800 сая.төгрөгний хөрөнгө оруулалтыг улсын төсөвт	100



						суулган батлуулсан. Төслийн санхүүжилтээр Баянгол дүүрэг, Баянзүрх дүүргийн нийт 23 блок барилгын зураг төсөлд магадлал хийлгэсэн.	
9.	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж барилгажуулах төслийн хүрээнд шинээр ашиглалтад орсон орон сууц, айлын тоо	301	700	3772	3471	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд 120 барилгыг буулган дахин барилгажуулах 43 төсөл хэрэгжүүлэгч шалгарч, батламжлагдсан. Төсөл хэрэгжүүлэгч шалгараагүй ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 59 барилга байна. Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчтэй 120 барилгаас 74 барилгын 1,552 айлын орон сууцны барилгыг буулгаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,772 өрхийн үйлчилгээ, орон сууцны 31 барилгыг барьж ашиглалтад оруулсан. /Эх сурвалж НОСБГ-2024/	100
10	Шинээр байгуулагдсан үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэр, тоо	3	4	7	4+	Дүүргэгч материалын, бетон зуурмагийн цонх, хаалганы гм олон нэр төрлийн үйлдвэр шинээр байгуулагдаж, Тохирлын гэрчилгээ шинээр авсан.	100
11	Импортыг орлох, экспортыг дэмжих шинэ материал, бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	10	6	-	Арматурын үйлдвэр-2 үйлдвэр /Мөнх хаан айрон ХХК, Дөл түшиг ХХК/, Мяндал полимер арматурын-2 үйлдвэр /Универсал композит/ гм, Базальт арматур /Монгол базальт ХХК/-ийн 1 үйлдвэр шинээр байгуулагдсан. Цементийн үйлдвэр /Вестерн Холд ХХК/-ийн-1 нэмэгдсэн	70
12	Барилга угсралтын ажлын улирлын нөлөөллийг бууруулах судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	2	-	Эрдэс хөвөн дулаалгатай сэндвич хавтангийн үйлдвэрлэл -Хэсэгчлэн угсрах кассет сэндвич технологи, архитектурын уян хатан шийдэл, оффис, супермаркет, гараж, спортын ордон, үйлдвэрийн барилгын хийцэд тохиромжтой технологи нь хөдөлмөрийн бүтээмж 3 дахин нэмэгдүүлж, барилга угсралтын хугацааг 2 дахин багасгаж, компанийн ашигт ажиллагааны түвшин нэмэгдүүлэх шийдэл болсон. Хуурай хольцын үйлдвэрлэл - Дотоодын үйлдвэрүүд хуурай хольцын төрлүүд болох замаска, блокны цавуу, хөөсөнцөрийн цавуу, шал тэгшлэгч, плитаны цавуу, торны цавуу, шавардлагын болон шалны бэлэн зуурмаг зэргийг үйлдвэрлэж байна. Хуурай хольцыг хүйтний улиралд ч хэрэглэх	100

						боломжтой тул улирлын хамаарлыг багасгаж байна.	
13	Инженер геологийн болон инженерийн бэлтгэл ажлын судалгаа, тоо	-	2	2	2	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 338 дугаар тогтоолоор “Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах байр зүйн зураг зохиох эхний ээлжийн ажил /Архангай, Өвөрхангай/ боловсруулахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэсэн. Тус ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Инженер геодези” ХХК, “Бэйспойнт” ХХК-ий түншлэл Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2024/56 дугаар гэрээт ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 2024 оны 2024/71 дугаар гэрээг Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан. Мөн “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Даргын 2024 оны А/09 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 2024/ГБ33/19 дугаар акт үйлдэн хүлээлгэн өгснөөр ажил бүрэн дууссан.</p> <p>Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгч “Престиж инженеринг” ХХК-тай 2021.05.06-нд гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.</p> <p>“Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө”-г НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулахаар уг баримт бичгийг боловсруулах ажлын даалгаварт заасан үе шатны дагуу хэрэгжсэн бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2023.04.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. НИТХ-ын 2023.06.21-ний 65 дугаар тогтоолоор батлагдсан. Сайдын зөвлөлийн 2023.06.28-ны 4-р хурлаар дэмжиж, 2023.09.06-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Улаанбаатар хот болон дагуул хаяа хот тосгодын</p>	100

					инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөтэй болсон. Мастер төлөвлөгөөний ажлын хүрээнд 2040 он хүртэл 42 цооногийг хөрсний усны түвшин бууруулах болон шүүрүүлэх 58 км байгууламж барих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.	
14	Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	2	<p>Хаягдал гялгар уутыг дахин боловсруулан нүхэн жорлонгийн доторлогооны иж бүрдэл болон худгийн таг, кольцо үйлдвэрлэж, 1000 гаруй гэр хорооллын өрхийн нүхэн жорлонгийн асуудлыг шийдвэрлэн, хөрсний бохирдлын хэмжээг бууруулахад хувь нэмэр оруулж буй үндэсний үйлдвэрлэгч Пластик центр ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Тус компаниас бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалт мэргэжлийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, тус бүтээгдэхүүнд стандарт гарган батлуулах, Сурталчилгаа хийх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх тал дээр дэмжлэг авахыг хүсэж, албан бичгээр хүсэлтээ уламжилсан. Асуудлыг судлан, эерэг үр дүн гаргахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар холбогдох нэгжүүдэд танилцуулж, шаардлагатай техникийн зохицуулалтыг боловсруулах талаар зөвлөгөө өгсөн.</p> <p>Барилгын шинэ техник технологийг нэвтрүүлж, Грийн ресорт амралтын газарт суурилуулан бодит хэмнэлт, сурталчилгаа хийж буй Ультрасоник ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, салбарын норм, нормативын тогтолцоо, хууль эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжийн талаар зөвлөлдөж санал солилцлоо. Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай ногоон барилгыг хөгжүүлэх, иргэдэд зөв мэдээлэл өгч, сэдэл өгөх, сэтгэлгээг өөрчлөх тал дээр дэмжлэг үзүүлэх, төвлөрсөн системээс татгалзаж, байгальд ээлтэй, цомхон бүтцийг бий болгох чиглэлээр судалгаа хийх, тус компанийн хэрэглээнд үндэслэсэн тооцоолол гаргах, хамтран ажиллаж байна.</p> <p><b>1. Хог хаягдлыг дахин боловсруулах судалгааны чиглэлээр:</b> “Барилгын материалд үнс хэрэглэх технологийн судалгаа”, “Барилгын материалын хортой бодисын ялгарлын</p>	100

						судалгаа"-г ШУТС-ийн захиалгат ажлын жагсаалтад оруулуулахаар тус сангийн Инженерийн ухаан, технологийн салбар зөвлөлд 2023.09.22-ны өдөр танилцуулсан. Тус зөвлөлөөс үнсийг барилгын материалд хэрэглэх талаар хийгдсэн судалгааны ажлууд тус санд байдаг талаар дурдсан тул тэдгээр төслүүдийн хувийг ирүүлэх тухай хүсэлтийг 2023.11.13-ны 6/4123 тоот албан бичгээр ШУТС-д хүргүүлж, судалгааны 7 төслийн тайланг файлаар авсан. <b>Барилгын дотоод орчны агаарын чанарын судалгааны чиглэлээр:</b> "Түмэн Амгалан Ордон" ХХК-иар барилгын дотоод орчны агаарын чанарын бодлого, зохицуулалтын баримт бичгийн суурь судалгаа хийлгэсэн. Мөн "Ногоон титэм" ХХК-иар барилгын дотоод орчны агаарын чанарт барилгын материалаас нөлөөлөх нөлөөллийн судалгаа хийлгэсэн. Эдгээрийг судалгааны санд нэгтгэснээр эрхзүйн баримт бичиг боловсруулах боломж бүрдээд байна.	
15	Ногоон барилгын технологи нэвтрүүлэх гарааны компани, тоо	-	1	3	-	- Амины орон сууцны инновацийн төв ТББ, - АОС-ны мэдээллийн төв Барилгын зураг төсөл гүйцэтгэгч, барилга угсралт болон барилгын материал нийлүүлэгч, үйлдвэрлэгч хувийн хэвшлийн ААН-үүд олноороо байгуулагдаж байна.	100
16	Барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ	3.7	4.1	3.3	-0.4	Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 80.0 их наяд төгрөгт хүрсний 2.6 (3.3%) их наяд төгрөгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбар бүрдүүлж байна. Салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 оны мөн үеэс 1.2 (90.5%) их наяд төгрөгөөр, 2022 оны мөн үеэс 821.8 (46.0%), өмнөх оны мөн үеэс 335.8 (14.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2 605.6 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 1 016.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.9 (10.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.	90
17	Ногоон барилгын үнэлгээний систем	-	-	2	-	- Дэлхийн банкны ОУСК-ын EDGE үнэлгээний системд Монгол Улсын датаг оруулсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 108 дугаар тушаалаар "Ногоон барилгын үнэлгээ (BestGER)-ний аргачлал" /БД 25-102-24/-ыг, 2024	100

						оны 153 дугаар тушаалаар “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”-ыг батлуулсан.	
18	Ногоон гэрчилгээтэй барилга, тоо	-	-	3	-	“Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам”-ыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 153 дугаар тушаалаар баталсан. Барилга, хот байгуулалтын сайд болон Эрчим хүчний сайдын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/257, А/252 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ын дагуу Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээг 2024 онд 728 барилгын ажлын зураг төсөлд олгож, бүртгэлжүүлсэн. LEED гэрчилгээтэй 2 барилга EDGE гэрчилгээтэй 1 барилга	100
19	Шинээр барьж ашиглалтад оруулсан Улаанбаатар хот болон аймгуудын цэвэрлэх байгууламж, тоо	5	8	10	+2	Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2020 онд, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар, Дархан-Уул аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2023-2024 онуудад ашиглалтад оруулсан. АХБ-ны зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймгийн төвд хоногт 3000 м <sup>3</sup> ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийг, Дархан-Уул аймгийн төвд хоногт 24000 м <sup>3</sup> ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг, Өвөрхангай аймгийн Хужирт суманд хоногт 310 м <sup>3</sup> , Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд хоногт 50м <sup>3</sup> ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг тус тус ашиглалтад оруулсан. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хэрэгжилт 95%, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын зээлээр “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламж” төслийн хэрэгжилт 95%, Бүгд Найрамдах Польш Улсын зээлээр Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийн барилга угсралтын ажил 62,9%, Дорнод аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төслийн боловсруулалт 20%, Бүгд Найрамдах Австри Улсын зээлээр Дархан-Уул аймгийн төвд цэвэр усны 9,2 км шугам сүлжээ, 5,000 ш цэвэр усны ухаалаг тоолуур	100

						суурилуулсан, төслийн хэрэгжилт 54%-тай хэрэгжиж байна.	
20	Орон нутагт шинээр барьсан инженерийн шугам сүлжээний нийт урт, км	100	150	128.18	28.18	2024 онд: Цэвэр ус 45.296 км, Бохир ус 48.48 км, Дулаан 34.41 км.	100
21	Шинээр баригдсан үерийн далан сувгийн урт, км	44	69	129	85	2021-2024 онд улсын төсвийн хөрөнгөөр нийслэл болон 21 аймагт нийт 18 байршилд 52,534 сая төгрөгийн санхүүжилттэй үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил хийгдсэн байна, 15 байршлын ажил нь бүрэн дуусаж ашиглалтад орсон бол 3 байршлын ажил одоогоор үргэлжлэн хийгдэж байна. 2021-2024 онд 21 аймгийн хэмжээнд ойролцоогоор 43,9 км ҮББ-ийн ажил хийгдэж, ашиглалтад хүлээж авсан. 2020-2024 онд нийслэлийн хэмжээнд 40.9 км ҮББ-ийн ажил хийгдэж, ашиглалтад хүлээж авсан.	100
22	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, хувь	30	70	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 294 дүгээр тогтоолын 1.2-т “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус үүрэг болгосон. Үүнтэй холбогдуулан тус яамнаас Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулж, Улсын Их Хуралд	-

						өргөн барьсан. Улсын Их Хурлаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталснаар Засгийн газрын тухай хууль болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт орж газрын харилцаа, геодези, зураг зүйн чиг үүргийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас биелэлт гарна.	
23	Ус дамжуулах, түгээх шугамын алдагдлын бууралт, хувь	18.6	10.0	6.0	-12.4	ХСУХАТАҮЗХороо нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хүрээнд эдгээр үзүүлэлтүүдийг гаргасан бөгөөд тусгай зөвшөөрлийн зохицуулалтанд хамрагдаагүй сум, суурин газрын мэдээлэл ороогүй болно. Энэхүү үзүүлэлт нь 2023 оны байдлаар бөгөөд 2024 оны тайлан, мэдээг 2025.02.28-нд ирүүлсний дараа нэгтгэлээр гарна.	70
24	Орлого болоогүй усны эзлэх хувийг бууруулах хувь	20.5	17.5	10.0	-10.5	ХСУХАТАҮЗХороо нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хүрээнд эдгээр үзүүлэлтүүдийг гаргасан бөгөөд тусгай зөвшөөрлийн зохицуулалтанд хамрагдаагүй сум, суурин газрын мэдээлэл ороогүй болно. Энэхүү үзүүлэлт нь 2023 оны байдлаар бөгөөд 2024 оны тайлан, мэдээг 2025.02.28-нд ирүүлсний дараа нэгтгэлээр гарна.	70
25	Удирдлага, хяналтын ухаалаг систем бүхий инженерийн дэд бүтцэд холбогдсон хот, аймгийн төв, тоо	2	3	2	-	1. Бүгд Найрамдах Австри Улсын зээлээр 2023 оноос эхлэн “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд усны зүй бус хэрэглээнд хяналт тавих, алсын зайнаас мэдээлэл авах, хэрэглэгчдийн болон хангагч байгууллагын цаг хугацаа, зардлыг хэмнэх зорилгоор 4850 ш ухаалаг тоолуурыг суурилуулсан. Мөн хэрэглэгч хангагчийн уялдаа холбоог сайжруулах, үүлэн технологид суурилсан хялбар усны бичилт	70

						хийх, хяналт тавих программ хөгжүүлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг хяналт удирдлагын нэгдсэн системд бүх насос станцууд, дахин дамжуулах өргөтгөлийн станцууд, усан сангууд, түгээх шугамын зохицуулах хаалттай хяналтын 70 гаруй цэг холбогдсон.	
26	Хот, суурин газарт шинээр болон шинэчлэн барьсан нийтийн халуун усны төв, тоо	634	642	639	-3	Сумын хөгжил:Инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээний хүрээнд Архангай аймгийн Их тамир, Увс аймгийн Зүүнхангай, Дундговь аймгийн Луус, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан суманд халуун усны байрыг барьж байна.	70
ДҮН							93.6

## 8.2. Хавсралт-2

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /жилийн эцсийн байдлаар/

### НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж баталсан байна.

Монгол Улсын 2024 оны 07-р сарын 10-ны өдөр баталсан “Засгийн газрын бүтцийн тухай хууль, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2024 оны 08-р сарын 28-ны 51 дүгээр тогтоолын дагуу яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн баталж дараах 8 тэргүүлэх чиглэл:

1. Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр
2. Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр
3. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын чиглэлээр
4. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр
5. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр
6. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр



8. Салбарын хяналтын чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг дүгнэх, төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах зорилгоор тус хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсрууллаа.

### ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь тухайн хугацааны хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, мэдээллийн үнэн, зөв байдлыг нягтлах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлсэн болно.

### ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 32 зорилтын 320 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### Хүснэгт 1. ХББОСЯ-ны ТШЗ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /газар тус бүрээр/

№	Газрууд	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар /%/						ХБ	Биелэлтийн дүн
				100	90	70	50	30	0		
1	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар	3	50	42	4	4					96.8
2	Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар	1	35	28	4	3					96.3
3	Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар	6	42	29	9	2	1			1	95.1
4	Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар	4	40	32	3	4	1				95.0
5	Төрийн захиргааны удирдлагын газар	6	50	40	6	2	2				95.6
6	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	4	23	20	3						98.7
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	4	43	31	11				1		95.1
8	Салбарын хяналтын газар	4	37	36			1				98.6
	Дүн	32	320	258	40	15	5	0	1	1	96.2

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТШЗ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **96.2%**-ийн гүйцэтгэлтэй “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлж байна.

**ТШЗ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт газар тус бүрээр харуулбал:**

	Стратегийн зорилт	Зорилго	Арга хэмжээ тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ
<b>Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр</b>				
11	Монгол Улсын байгаль, орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах замаар салбар дундын зохицуулалтыг хангаж, иргэдийн хууль ёсны амьдрах болон баялаг бүтээх эрхийг баталгаажуулах, байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий газар ашиглалтын бодлого, төлөвлөлтөөр ил тод, тэгш хүртээмжтэй, хариуцлагатай газрын харилцааг бий болгоно.	1.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний нэгдсэн бодлого, төлөвлөлт, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах.	14	95
12		1.2. Орон сууцжуулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх. /Үндэсний орон сууцжуулалтын тогтолцоо, Хуримтлалын сангийн реформыг хэрэгжүүлэх;/	19	97.4
13		1.3.10. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангана.	3	100
14		1.3.11. Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна	6	100
		1.3.12. Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана.	3	100
		1.3.13. Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулсан байна. Салбарын статистикийн мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулж өгөгдлийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.	5	100
<b>Дундаж оноо</b>			<b>89</b>	<b>95.6</b>
<b>Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр</b>				
15	Барилга, барилгын материалын үйлдвэрийн хууль тогтоомж, эрх зүйн болон норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх	Хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийн хувилбарыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.	35	96.3
<b>Дундаж оноо</b>			<b>96</b>	<b>95,7</b>
<b>Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын чиглэлээр</b>				
	"Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах,	3.1. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	23	92.6
		3.2. Барилгын норм, норматив, төсөв, үнэ бүрдлийн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	9	98.9
		3.3. Барилгын салбарын механикжуулалт, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, газар хөдлөлт, инженер геологи, хайгуул судалгааны чиглэлээр норм, дүрэм, журмыг боловсруулан	2	100

	хэрэгжилтийг зохион байгуулах;"	батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		
		3.4. Барилгын материалын үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээний лабораторийн нэгдсэн сүлжээг бий болгох, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	3	100
		3.5. Салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох, цахимжуулах ажлыг зохион байгуулах	2	90
		3.6. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан	3	100
<b>Дундаж оноо</b>			<b>42</b>	<b>95,1</b>
<b>Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр</b>				
	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалтаар хангах,	4.1 Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.	8	91.3
	төлөвлөлтийг хэрэгжүүлэх, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалт,	4.2. хот, тосгон, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, халаалтын шугам сүлжээ, эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжийн системийг төлөвлөх, байгуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалтаар хангах.	22	90.9
	норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй	4.3. Орон сууцны ашиглалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	5	94.0
	болгох, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	4.4. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэх, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.	5	100
<b>Дундаж оноо</b>			<b>40</b>	<b>95,0</b>
<b>Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр</b>				
	Салбарын хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	5.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	50	95.6
		5.2. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, төрийн зарим чиг үүргийг нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагуудаар төлөөлүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.		
		5.3. Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн албан хаагч, инженерийн ёс зүйн чадамжийг дээшлүүлэхэд холбогдох ажлыг зохион байгуулна.		
		5.4. Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана.		
		5.5. Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох.		

		5.6. Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх.		
<b>Дундаж оноо</b>			<b>50</b>	<b>95,6</b>
<b>Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр</b>				
27	Санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	6.1. Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих	5	100
28		6.2. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах	4	100
29		6.3 Төрийн сангийн гүйлгээ гүйцэтгэх, тайлан, баланс гаргах.	4	98
30		6.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах.	1	96
<b>Дундаж оноо</b>			<b>23</b>	<b>98.7</b>
<b>ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР</b>				
32	Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах	7.1. Хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах	7	98.9
33		7.4. Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн тайлан зөвлөмж, гаргах	24	98.3
34		7.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	4	100
34		7.4. Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарцуулалтад дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	8	92.5
<b>Дундаж оноо</b>			<b>43</b>	<b>97.4</b>
<b>САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР</b>				
43	Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүл	1.1. Салбарын хяналтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн ангиллыг тогтоох ажлыг нэгдсэн арга зүй, зохион байгуулалтаар хангана	5	100
44		1.2. Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	19	100
45		1.3. Салбарын хяналтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ	13	96.2
<b>Дундаж оноо</b>			<b>37</b>	<b>98.6</b>
<b>46</b>	<b>НИЙТ ОНОО</b>		<b>320</b>	<b>95,8</b>

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “хангалтгүй” 0, эрчимжүүлэх шаардлагатай 50%-тай үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “Үр дүнгүй” буюу 0%-тай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. “Монголын архитекторуудын эвлэл” ТББ-аар гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, тайлагнах.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.1.11 “Батлагдсан зураг төслийг давтан хэрэглэх болон нэг маягийн зураг төсөлд холболт хийх журам”-ын төсөл боловсруулж, батлуулна.

2. 4.2.10. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно.

3. 5.1.3. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулна. Монгол хэлний сургалтыг яамны ажилчдад зохион байгуулна.

4. 5.1.35. Яамны цахим хуудсыг сайжруулж, нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулна.

5. 8.3.8. Зуух, даралтат савны техникийн магадлал баталгаажуулалтад хамруулах.

#### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТШЗ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан нийт 32 зорилтын 320 арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үнэлгээ **96,2** хувьтай **"тодорхой үр дүнд хүрсэн"** байна.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2024 оны 08-р сарын 28-ны 51 дүгээр тогтоолын дагуу яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулалгүйгээр удааширсан нь гүйцэтгэлдээ тааруулан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн тоо болон чанарын тодорхойлолтыг гаргасан харагдаж байна.

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.4, 3.1.5, 3.1.6, 3.1.8, 4.2.17, 4.2.18, 4.2.20, 4.4.4, 4.4.5 зэрэг арга хэмжээний зорилтот түвшинг “зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ”, “холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана”, гэж төлөвлөсөн нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй үнэлэхэд хүндрэлтэй, үр дүнд суурилсан, бодит төлөвлөлт хийгдээгүй байна.

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.2.3, 8.2.4, 8.2.5, 8.2.7, 8.2.9, 8.2.10, 8.2.14, 8.3.10 зэрэг арга хэмжээг төлөвлөхдөө хүрэх түвшний тоон илэрхийлэл нь хүрсэн түвшний тоон дүнтэй харьцуулахад хэт бага төлөвлөсөн нь бодиттой бус төлөвлөлт байна.

5. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь жилийн эцсийн байдлаар дараах бүтцийн хүрээнд төлөвлөгдсөн байна.

#### **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1. Орон сууцны тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл/, Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж дуусган УИХ-д өргөн барьж, чуулганаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах, 2025 оны төлөвлөгөөнд тусгах;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлэхдээ тайлант хугацаанд хэрэгжсэн арга хэмжээнүүдийн үр нөлөөг товчоор дурдаж, Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.8-д зааснаар гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

35	2.1.17	Ажлын зураг төсөл, төсвийн тооцоог эцэслэж экспертизээр батлуулах /Дорнод/	Ажлын зураг төсөл, төсвийн тооцоо эцэслэгдэж экспертизээр батлагдсан байна.	Дорнод аймгийн Чойбалсан хотын 10000м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ технологи схемийн талаар ХББОСЯ-ны ББМБЗГ дарга Төслийн захирал болон НААБЗГ-ын дарга нараар ахлуулан 2024 оны 09 дүгээр сарын 02-ний өдөр Мелиорекс ХХК-ний Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Adam-тай ойлголцлын төвшинд уулзалт зохион байгуулж зургийн үе шатны ажил удаашралтай байгаа талаар ярилцан эхний ээлжийн концепцийг БХТ-ийн дэргэдэх мэргэжлийн зөвлөлд танилцуулж батлуулах дараа нь захиалагч болох ХББОСЯ-д танилцуулж зураг төслийн үе шатны ажлыг яаравчлах талаар үүрэг чиглэл өгсөн. 2024.09.23-ны өдөр ТХН-ийн	30

				<p>info@polandproject.mn хаягаар Мелиорекс ХХК-аас ерөнхий ойлголт өгөх зорилгоор байгууламжийн концепцийн холбогдох материалыг ирүүлсэн.</p> <p>“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн Дорнод аймгийн Чойбалсан хотын 10000м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, технологийн 2-р хувилбарыг 2024.11.27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хурлаар хэлэлцүүлсэн АО технологийн төсөвт өртгийг урьдчилсан байдлаар танилцуулах, мөн ашиглалтын зардал, технологийн харьцуулалт, IFAS, АО технологийн цэвэрлэгээний түвшний харьцуулалтыг хурлын гишүүдэд цахимаар дахин танилцуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу гүйцэтгэгч компанид албан бичгээр хандан харьцуулсан тооцоо, холбогдох материалыг яаралтай гаргаж өгөхийг хүссэн бөгөөд үүний дагуу гүйцэтгэгч Мелиорекс ХХК-аас цэвэрлэгээний түвшний харьцуулалт, ашиглалтын зардлын харьцуулалтыг хийж ирүүлсэн боловч шаардлага хангаагүй байна. Гүйцэтгэгчээс дахин ирүүлсэн холбогдох мэдээллийг 2024.12.19-ний өдөр Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд цахимаар хүргүүлсэн.</p>	
36	2.1.18	БОНУ, БОЕУ-ний төлөвлөгөөг холбогдох газруудаар батлуулах /Дорнод/	БОНУ, БОЕУ-ний төлөвлөгөөг батлагдсан байна.	Зураг төсөл хийгдэж байгаа бөгөөд эцэслэн батлагдаагүй байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны ерөнхий үнэлгээг гүйцэтгэгч компани дуусгаж албан ёсоор хүлээлгэж өгөөгүй байна.	0
37	2.1.19	Магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах /Дорнод/	Магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан байна.	<p>БХБЯ-ны 2024 оны 05 сарын 28-ний өдрийн №2024/10 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд АО технологи схемийг БХБЯ-д танилцуулан зөвшилцөж зураг төсөл боловсруулах ажил дахин эхлүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн Дорнод аймгийн Чойбалсан хотын 10000м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, технологийн 2-р хувилбарыг 2024.11.27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>Зураг төсөл дууссаны дараа БХТ-ийн магадлалын хэлтэсд зураг төсөл, төсвийг өгч дүгнэлт гаргуулах болно.</p>	30
38	2.1.20	Гэрээт ажлын цар хүрээг тодорхой болгох /Дорнод/	Барилгын ажил чанартай хийгдсэн байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024.08.02-ны өдрийн а/222 тоот албан бичгээр Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын нөхцөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд Дорнод аймгийн Чойбалсан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн	0

				<p>2021/220 дугаартай гэрээт ажлын ерөнхий гүйцэтгэгч БНПУ-ын “Meliorex Sp.Z.o.o” компанид ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2024.12.31-ний өдрийг хүртэл сунгасан талаар мэдэгдэж, гэрээний сунгалтын цэвэрлэх байгууламжийн зураг төслийн 2 дугаар хувилбарыг танилцуулах, төсөвт өртгийг бууруулах үүрэг хүлээсэн талаар мэдэгдсэн. Гэрээт ажлын хүрээнд 30%-ийн урьдчилгаа төлбөр буюу 959,400 еврогийн төлбөрийг захиалагч талаас төлсөн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 2024/10 тоот зургийн даалгаврын дагуу зураг төслийн ажлын явц, урьдчилсан төсвийн тооцооны талаар гэрээний үүргээ биелүүлж ажлын тайлан, явцын мэдээллийг ирүүлэх талаар хүссэн албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>Зураг төслийн 2 дугаар хувилбар эцэслэгдээгүй тул ажлын цар хүрээ, хийгдэх ажил тодорхой болоогүй байна.</p>	
39	2.1.21	Гэрээний өөрчлөлт хийж, /Дорнод/ нэмэлт №2-ийг батлуулах	Барилгын ажил чанартай хийгдсэн байна.	<p>“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн гүйцэтгэгч “Meliorex” Sp. z o.o. компанитай 2021 оны 07 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих ажил”-ын 2021/220 дугаартай гэрээний нэмэлт өөрчлөлт /№2/-ийг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан бөгөөд Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу уг гэрээний нэмэлт, өөрчлөлт /№2/-ийг Бүгд Найрамдах Польш Улсын Сангийн яаманд уламжлах тухай албан бичгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.07.26-ны өдрийн 01/2130 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	100
40	2.1.22	Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах /Дорнод/	Барилгын тухайн ажил эхлэхээс өмнө зөвшөөрлийг авсан байна.	<p>БХБЯ-ны баталсан 2022.05.11 №2022/39 дугаартай зургийн даалгаварт Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон, эдийн засгийн хувьд хэмнэлттэй 2-оос доошгүй хувилбар байна гэж заасны дагуу ерөнхий гүйцэтгэгч БНПУ-ын Meliorex Sp.Zo.o компани эхний ээлжинд танилцуулсан IFAS технологи нь БХТ-ийн 2023 оны 11 сарын 28-ний өдрийн №2045/2023 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлтээр татгалзсан дүгнэлт гаргасан байна. БХБЯ-ны 2024 оны 05 сарын 28-ний өдрийн №2024/10 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд АО технологи схемийг БХБЯ-д танилцуулан зөвшилцөж зураг төсөл боловсруулах ажил дахин эхлүүлэх ажил хийгдэж байна.</p>	0
41	2.1.23	Барилга ажил угсралтын эхлүүлэх /Дорнод/	Барилга угсралтын ажил эхлэх бэтгэл ажил хангагдаж, ажлыг	<p>БХБЯ-ны 2024 оны 05 сарын 28-ний өдрийн №2024/10 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд АО технологийн дагуу</p>	0

			эхлүүлсэн байна.	зураг, төсөв магадлалаар орж батлагдсаны дараа барилгын ажлын төлөвлөгөө батлагдана.	
42	2.1.24	Гадна цахилгаан хангамжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх /Дорнод/	Барилгын тухай хууль, холбогдох хууль, БНБД, стандартууд, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэсэн байна.	БХБЯ-ны 2024 оны 05 сарын 28-ний өдрийн №2024/10 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд зураг, төсөв магадлалаар орж батлагдсаны дараа барилгын ажлын төлөвлөгөө батлагдана.	0
43	2.1.25	Гадна цахилгааны шугам сүлжээний ажлыг эхлүүлж, үргэлжлүүлэх /Баян-Өлгий/	Барилгын тухай хууль, холбогдох хууль, БНБД, стандартууд, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэсэн байна.	Баян-Өлгий аймгийн "Цахилгаан шугам сүлжээний газар"-аас ирүүлсэн албан бичгийн дагуу газар дээр нь үзэж танилцсан. Баян-Өлгий аймгийн "Цахилгаан шугам сүлжээний газар"-аас 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн №22/93 олгосон техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулсан. Мөн гадна цахилгаан хангамжийн трасс давхацсан асуудал орон нутгийн "Цахилгаан шугам сүлжээний газар", аймгийн ГХБХБГ-ын хоорондын уялдаа холбоогүйгээс шалтгаалсан байсан. Тус аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хүсэлтийн дагуу аймгийн Эрчим хүчний хяналтын Улсын байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн №11-15-02/018/30 дүгнэлт гарсан. Тус дүгнэлтээр хоёр шугамыг тус тусдаа өөр трассаар татах газаргүй, эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зай хэмжээг бариулах боломжгүйгээс болж нэг л шугам татаж цахилгаан хэрэглээний цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээг харгалзан шугамын чадал дамжуулах чадварыг хамтран нэмэгдүүлэх техникийн боломжийг ашиглан шийдэл гаргах нь зүйтэй байна гэж гарсан тул тус шугамыг хамтран ашиглах тал дээр дэмжлэг үзүүлэх тухай Эрчим хүчний яамны Эрчим хүчний хөгжлийн төвд 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №а/284 дугаартай албан бичиг хүргүүлж шийдвэрлэв. Баян-Өлгий аймгийн БУЦБ-ийн гадна цахилгааны ажилд аймгийн "Цахилгаан шугам сүлжээний газар"-ын инженертэй төслийн нэгж болон гүйцэтгэгч байгууллагатай хамтарсан уулзалт хийж Баян-Өлгий аймгийн "Цахилгаан шугам сүлжээний газар"-аас 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн №24/123 олгосон техникийн нөхцөлийн агаарын шугамын хөндлөн огтлолыг АС95-аар гаргасан байсныг АС70 болгон өөрчлүүлж техникийн нөхцөл гаргуулсан.	90
44	2.1.26	Гадна цахилгааны ажилд Улсын комисс ажиллуулж, хүлээлгэн өгөх /Говьсүмбэр/	Улсын комиссын актыг баталгаажуулсан байна.	Говьсүмбэр аймгийн Бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна цахилгааны ажилд барилга, байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссыг 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр ажиллуулсан.	100
45	2.1.27	Гадна цахилгааны ажилд Улсын комисс ажиллуулж, хүлээлгэн өгөх /Завхан/	Улсын комиссын актыг баталгаажуулсан байна.	Завхан аймгийн Бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна цахилгааны ажилд барилга, байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр ажиллуулсан.	100

46	2.1.28	Тоног төхөөрөмжийн захиалга хийх, үйлдвэрлэх /Дорнод/	Тоног төхөөрөмжийн захиалга хийгдэж, үйлдвэрлэгдсэн байна.	БХБЯ-ны 2024 оны 05 сарын 28-ний өдрийн №2024/10 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд АО технологийн дагуу зураг, төсөв магадлалаар орж батлагдсаны дараа тоног төхөөрөмжийн захиалга хийгдэнэ.	0
<b>ЗОРИЛТ 2. Барилгын ажлын үе шатны ажлуудад хөндлөнгийн хяналтыг бусад холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллах зорилтын хүрээнд:</b>					<b>100</b>
47	2.2.1	ТХН болон Баян-Өлгий аймгийн ГХБХБГ хооронд байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Баян-Өлгий аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Баян-Өлгий аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01 өдрийн ЗХ-2023/06 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ГХБХБГазрын хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Баян-Өлгий аймгийн ГХБХБГазраас 2024.06.17-ны өдрөөс 2024.06.23-ны өдрүүд, 2024.06.24-ний өдрөөс 2024.06.30-ны өдрүүд, 2024.07.01-ний өдрөөс 2024.07.31-ний өдрүүд, 2024.08.01-ний өдрөөс 2024.08.11-ний өдрүүд, 2024.08.12-ны өдрөөс 2024.08.25-ны өдрүүд, 2024.08.26-ны өдрөөс 2024.09.27-ны өдрүүдэд тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
48	2.2.2	ТХН болон Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Нийтийн аж ахуйн СУАТ ХХК -тай байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах.	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Баян-Өлгий аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж "Суат" ХХК-ний хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Нийтийн аж ахуйн СУАТ ХХК-аас 2024.10.14-ний өдрөөс 2024.10.19-ний өдрүүдэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
49	2.2.3	ТХН болон Говьсүмбэр аймгийн ГХБХБГ хооронд байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Говьсүмбэр аймгийн төвийн цэвэрлэх байгууламж	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Говьсүмбэр аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ГХБХБГазрын хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Говьсүмбэр аймгийн ГХБХБГазраас 2024.09.12-ны өдөр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100

		барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах			
50	2.2.4	ТХН болон Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Нийтийн аж ахуйн Ус-Ду ОНӨААТУГ-тай байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Говьсүмбэр аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж Сүмбэр сумын Нийтийн аж ахуйн Ус-Ду ОНӨААТУГ-ын хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Нийтийн аж ахуйн Ус-Ду ОНӨААТУГ-аас 2024.09.17-ны өдөр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
51	2.2.5	ТХН болон Завхан аймгийн ГХБХБГ хооронд байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Завхан аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Завхан аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ГХБХБГаарын хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Завхан аймгийн ГХБХБГаараас 2024.07.16, 2024.09.27, 2024.11.15-ны өдөр тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
52	2.2.6	ТХН болон Завхан аймгийн Нийтийн аж ахуйн Амь Ус ХХК-тай байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Завхан аймгийн Улиастай сумын цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Завхан аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж Нийтийн аж ахуйн "Амь Ус" ХХК-ний хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Завхан аймгийн Нийтийн аж ахуйн Амь Ус ХХК-	100



		гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах		аас 2024.10.21-ний өдрөөс 2024.10.25-ны өдрүүдэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	
53	2.2.7	ТХН болон Увс аймгийн ГХБХБГ хооронд байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Увс аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Увс аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 2 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ГХБХБГазрын хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Увс аймгийн ГХБХБГазраас 2024.06.03-ны өдөөс 2024.09.26-ны өдрүүдэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
54	2.2.8	ТХН болон Увс аймгийн Улаангом сумын Нийтийн аж ахуйн Чандмань-Увс ХХК-тай байгуулсан "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Увс аймгийн Улаангом сумын цэвэрлэх байгууламж барих болон бусад туслах үйлчилгээ" барилгын ажлын гэрээнүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Увс аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 1 тоот гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж Нийтийн аж ахуйн "Чандмань УС" ХХК-ний хяналтын инженерүүдээс хяналтын тайланг сар бүр хугацаандаа авч байхаар шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд Увс аймгийн Улаангом сумын Нийтийн аж ахуйн Чандмань-Увс ХХК-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн.	100
55	2.2.9	ТХН болон Барилгын хөгжлийн төвийн хооронд "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр, Дорнод аймгуудын төвийн цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих барилгын ажлын захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, баталгаажуулах, тайлагнах	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс Барилгын хөгжлийн төвийн хооронд Захиалагчийн хяналт гүйцэтгэх 2023 оны 09 сарын 30-ний өдрийн 09/01 дугаартай гэрээг байгуулан хяналт хийгдэж байгаа бөгөөд 2024.09.19-ний 1/2568 тоот албан бичгээр "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн хүрээнд хэрэгжиж буй Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын барилга угсралтын ажлын захиалагчийн хяналтын тайланг ирүүлсэн.	100

<b>ЗОРИЛТ 3. Төслийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах зорилтын хүрээнд:</b>				<b>100</b>
<b>56</b>	2.3.1	Барилгын үйлдвэрлэлийн чанарын хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах	“Барилгын норм дүрэм”-12-01-09-г баримталсан байна.	100
<b>57</b>	2.3.2	Барилга угсралтын ажлын үед хөтлөх, бүрдүүлэх шаардлагатай холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулж ажиллах	Барилгын тухай хууль, холбогдох хууль, БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу бүрдүүлсэн байна.	100

58	2.3.3	Барилгын талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах хүрээнд харъяа аймгуудын мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах; Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулах	Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулсан байна.	Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын Барилгын талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах хүрээнд туслан гүйцэтгэгч "Байгууламж", "Сайн", "Сан", "Грэвинг Валю" ХХК-тай нийт ажилчдын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулах тал дээр зөвлөмж өгч талбайн инженерүүдэд үүрэг өгч мөрдүүлэн ажиллаж байна.	100
59	2.3.4	Барилгын ажлын сарын тайланг ТХН-ийн ИТА нараар хянагдан баталгаажсаныг бүртгэн цаасаар болон файлаар хадгалах	Барилгын ажлын долоо хоног тутмын тайланг ТХН-ийн ИТА нараар хянагдан баталгаажсаныг бүртгэн цаасаар болон файлаар хадгалагдсан байна.	Барилгын ажлын сарын тайланг ТХН-ийн ИТА нараар хянагдан баталгаажсаныг бүртгэн цаасаар болон файлаар хадгалж байна. Барилга угсралтын ажлын сарын төлөвлөгөөний биелэлт 2024 оны 1-11 сарын байдлаар 1-р сард 83,3% 2-р сард 91,6% 3-сард 75% 4-р сард 75,9% 5-р сард 78,9% 6-р сард 87,7% 7-р сард 92,2% 8-р сард 75,2% 9-сард 88,73% 10-р сард 95,2% 11-р сард 93% нийт дундаж хувь 85,15% байна.	100
60	2.3.5	Төслийн барилга байгууламжийн ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлд хяналт тавих, далдлагдсан ажлын чанарыг баталгаажуулах, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогчийн тавьсан шаардлагын биелэлтэд хяналт тавих	Барилгын ажил чанартай хийгдсэн байна.	Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн Гүйцэтгэгч "SWT" ХХК болон туслан гүйцэтгэгч Баян-Өлгий "Байгууламж" ХХК, Завхан "Сайн" ХХК, Увс "Сан" ХХК, Говьсүмбэр "Грэвинг Валю" ХХК-нуудын Улаан журнал дээр тэмдэглэгдсэн холбогдох байгууллагуудын тавьсан шаардлагын биелэлтийг гүйцэтгэгч компаниудаар гаргуулан хяналт тавин ажиллаж байна. Барилга байгууламжийн ил далд ажлын актыг захиалагч талаас аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Нийтийн аж ахуйн байгууллага, Барилгын хөгжлийн төвийн инженерээр хянуулж байна.	100
61	2.3.6	Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжсэн байна.	Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих POL-50-1 хувьд 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийн тайланг холбогдох журмын 3-р хавсралтын дагуу гаргах, Аймгуудын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Газарт хүргүүлж, дүгнэлтийг тайлангийн хамт байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тайлагнах, 2024 оны БОМТ-г батлуулах талаар холбогдох албан бичгийг ерөнхий гүйцэтгэгчид 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн а/214 тоот албан бичгээр хүргүүлсэн. Байгаль орчны менежментийн 2023, 2024 оны төлөвлөгөөний биелэлт, тайланг цахим мэдээллийн санд оруулсан.	100
62	2.3.7	"Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн Жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур	Мэдээллийг хагас, бүтэн жилээр гарган БХБЯ, БХТ-д	Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн Жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт, шалгах хуудасны дагуу "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн ерөнхий гүйцэтгэгч болон туслан	100

		зүүлэлт, шалгах хуудсыг батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 110 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	хүргүүлсэн байна.	гүйцэтгэгч компаниудаас мэдээллийг авч Төсөл хэрэгжүүлэх нэгжийн мэдээлэлтэй нэгтгэн 2024 оны хагас жилийн мэдээг 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр а/211 тоот албан бичгээр Хот байгуулалт, Барилга, Орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Жилийн эцсийн мэдээг дараа оны 02 дугаар сарын 21-ний дотор тайлагнана.	
<b>Зорилт 4. Төслийн барилгад зураг төслийн болон стандартын шаардлага бүрэн хангасан барилгын материал, тоног төхөөрөмжийг ашиглах, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ туршилтад тогтмол хамруулж чанарыг баталгаажуулах зорилтын хүрээнд:</b>					<b>65</b>
63	3.4.1	Барилгын ажилд хэрэглэх импортоор орж ирэх барилгын материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, татан авалтын төлөвлөгөөг гаргуулан хянуулах, батлуулах, гааль НӨАТ-ийг төлөх ажлыг зохион байгуулах	Барилгын ажил төлөвлөгдсөн хугацаанд саадгүй явах нөхцөл бүрдсэн байна.	Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулагдсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 1-р ээлжийн тоног төхөөрөмжийн гаалийн татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварын дүн болох 2,005.6 тэрбум төгрөгийн төлбөрийг Монгол улс хариуцан төлөхөөр 2024 оны улсын төсөвт тусгуулсан бөгөөд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газарт хандаж санхүүжилтийн эрхийг нээлгэн 2024 оны 8 дугаар сард Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төрийн сангийн 100900011657 тоот дансанд төсөв тавигдсанаас Гаалийн ерөнхий газарт 1,571.4 тэрбум төгрөгийг шилжүүлсэн. “Smart Waste Technologies” Sp.z.o.o компанийн 2021/221, 2021/222, 2021/223, 2021/223, 2021/224 тоот дугаартай гэрээний хүрээнд 2024 онд импортоор оруулж ирэх 2 -р ээлжийн тоног төхөөрөмжийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татварт 2.2 тэрбум, туслан гүйцэтгэгч компаниудын нэмэгдсэн өртгийн албан татварт 1.2 тэрбум төгрөг буюу нийт 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.18-ны өдрийн 03/1401 тоот албан бичгийг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн бөгөөд туслан гүйцэтгэгч компаниудын нэмэгдсэн өртгийн албан татварын 1,2 тэрбум төгрөгийн төлбөрийг Татварын ерөнхий газрын дансанд шилжүүлсэн. 2021/221, 2021/222, 2021/223, 2021/223, 2021/224 дугаартай гэрээт ажлын 4 аймгийн халаалтын зуухны гаалийн татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварын дүнд Баян-Өлгий аймаг-7,315,585.74 <b>төгрөг</b> ; Говьсүмбэр аймаг-7,717,334.73 <b>төгрөг</b> ; Завхан аймаг-6,895,368.90 <b>төгрөг</b> ; Увс аймаг-7,244,619.05 <b>төгрөг</b> Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн.	100
64	3.4.2	Барилгын ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын сорил шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэж зохих дүгнэлтийг гаргуулах	Барилгын тухай хууль, холбогдох хууль, БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024.08.15-ны өдрийн а/229 тоот албан бичгээр Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын нөхцөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын барилга угсралтын ажилд нийлүүлэх барилгын материалыг баталгаажуулах ажлыг хүрээнд материал нийлүүлэх, худалдан авахаас өмнө Материал баталгаажуулах зөвшөөрөл авах; Материал баталгаажуулах хуудсаар баталгаажиж, зөвшөөрөл авсны дараа төслийн талбайд материалыг нийлүүлэх; Материал татан авалт, нийлүүлэлтийн	100

				төлөвлөгөөг гаргаж танилцуулах шаардлагатай мэдэгдэж, урьдчилж захиалагчаар баталгаажуулж байхыг 2021/221; 2021/222; 2021/223; 2021/224 дугаартай гэрээт ажлын ерөнхий гүйцэтгэгч Smart Waste Technologies Sp.z.o.o компанид болон туслан гүйцэтгэгч нарт /Байгууламж ХХК, Грэвинг Валю ХХК, Сайн констракшн ХХК, Сан ХХК, Их Дельта инженеринг ХХК/ мэдэгдсэн бөгөөд материал баталгаажуулах хуудасны дагуу ТХН-ийн зүгээс хяналт тавин ажиллаж байна.	
65	3.4.3	Цэвэрлэх байгууламжид лаборатори болон лаг усгүйжүүлэх байгууламжид ашигд агдах химийн бодис, урвалжийг нийлүүлэх, хадгалалтын талаар судалгаа хийх, лагийг байгалийн шохойгоор боловсруулах арга норм дүрэм, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулах холбогдох судалгааг хийх	Химийн бодис, урвалжийн нийлүүлэлт ийн холбогдох судалгааг хийн, гарын авлага, зааврыг боловсруул сан байна.	Бүгд Найрамдах Польш Улсын нөхцөлт зээлийн хүрээнд хэрэгжиж буй Баян-өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн төслийн хүрээнд яаралтай шийдвэрлэх шаардлагатай Цэвэрлэх байгууламжид хэрэглэгдэх ПАК ПАМ бодисын татан авалт болон хадгалалт, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх талаарх шаардлагыг 2024.09.10-ны өдрийн а/237 тоот албан бичээр хүргүүлсэн бөгөөд судалгааны ажил хийгдэж байна. Цэвэрлэх байгууламжид ашиглагдах лабораторид ашиглах химийн бодис, цэвэрлэх байгууламжид ашиглагдах урвалж бодисуудын худалдан авалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтыг хариуцан ажиллах Монгол улсад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий компаниудтай хамтран ажиллахаар албан хэргийн уулзалт зохион байгуулан гэрээ байгуулах түвшинд ажиллаж байна.	30
66	3.4.4	Бүгд найрамдах Польш улсаас нийлүүлэгдэх Цэвэрлэх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын норм, стандартад нийцлийн талаар холбогдох судлагааг хийх, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулан, НААҮБ-ын чадавхийг бэхжүүлэх, инженер техникийн ажилчдыг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах.	Монгол улсад мөрдөгдөж буй БНБД 3,05,04-90 БНБД 40-02-16, БНБД 40-01-14, БНБД 40-05-16, БНБД 11-01-98 MNS 4943:2011 MNS 4288:95 стандарт, норм дүрэмд нийцсэн байна.	БНПУ-аас орж ирж байгаа тоног төхөөрөмжийг Монгол улсын стандартад нийцэж байгаа эсэх талаар үйлдвэрлэгч болон гүйцэтгэгч компани зүгээс тодорхойлолт гаргаж тоног төхөөрөмж бүрийг паспортжуулах зэрэг асуудлуудын талаар ерөнхий гүйцэтгэгч "Smart waste technologies Sp. Zo.o ХХК-д Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэх талаарх шаардлагыг 2024.09.10-ны өдрийн а/237 тоот албан бичээр хүргүүлсэн. Бүгд Найрамдах Польш Улсаас орж ирэх тоног төхөөрөмжүүд 2025 оны 4-р сард Монголд ирэх төлөвтэй байна. Шаардлагатай техникийн паспорт, Тохирлын гэрчилгээ, тоног төхөөрөмжийн гарын авлагуудын хамт нэгдсэн байдлаар хийхээр төлөвлөж байна. Холбогдох судалгаа хийгдэж байгаа бөгөөд НААҮБ-ын чадавхийг бэхжүүлэх, инженер техникийн ажилчдыг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг гаргасан хөтөлбөрийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглагч байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу цэвэрлэх байгууламж дээр ажиллах технологи болон ээлжийн инженерүүдэд зориулан 1. Бохир усны тухай ерөнхий ойлголт, бохир ус зайлуулах схем, сүлжээ, түүний байгууламж, 2. Бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн схем, сонголт гэх мэт агуулгын хүрээнд, • Бохир усны ангилал, бохир ус зайлуулах систем, схем, трасс • Бохир ус дамжуулах хоолой, худаг, өргөлтийн насос станцын үүрэг зориулалт, ажиллагааны зарчим, аюулгүй ажиллагаа, ашиглалт, засвар үйлчилгээ • Бохир ус цэвэрлэгээний технологийн ангилал	30

				<ul style="list-style-type: none"> <li>• Монгол орны байгаль цаг уурын нөхцөл, онцлогт тулгуурлан боловсруулсан технологийн сонголтын талаар</li> <li>• Бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн схем, ажиллагааны ерөнхий зарчим зэрэг сэдвүүдээр.</li> </ul> <p>Дархан хотын шинээр ашиглалтад орсон бохир ус цэвэрлэх байгууламжийг үзэж танилцах танхим, дадлага хосолсон 2 өдрийн сургалт зохион байгуулж ажиллаа.</p>	
<b>ЗОРИЛГО ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД</b>					
<b>ЗОРИЛТ 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:</b>					<b>90</b>
67	4.1.1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухай бүр оруулах, баталгаажуулах	"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн оруулсан байна.	Төслийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах зорилгын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн мэдээллийг цаг тухайд нь Шилэн дансны нэгдсэн цахим систем <a href="https://gap.mof.gov.mn/">https://gap.mof.gov.mn/</a> -ээр илгээж, баталгаажуулсан. ТХН-ийн сар бүрийн мэдээг "Шилэн дансны тухай хууль"-ийн 6.1.2 дугаарт заасан хугацаанд буюу дараа сарын 08-ны дотор холбогдох бүх мэдээллийг шилэн дансны системд оруулсан.	90  2 мэдэ элэл хоцр оосон
<b>ЗОРИЛТ 2. Төслийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, хүний хүчин зүйлсээс шалтгаалах эрсдэлийг бууруулах, хяналт тавих, үнэлэх, тайлагнах зорилтын хүрээнд төслийн нэгжийн нэгдсэн санг "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн удирдлагын мэдээллийн систем" -д үүсгэх зорилтын хүрээнд:</b>					<b>100</b>
68	4.2.1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системд цаг тухайд нь оруулах	Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу ажиллаж, мэдээллийг оруулсан байна.	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системд <a href="https://odamis.mof.gov.mn/">https://odamis.mof.gov.mn/</a> системд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 3 ажилтан хандах эрхтэй бөгөөд тайлант хугацаанд "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийн 2024 оны II, III улирлын тайланг болон 2024 оны 7, 8, 9, 10, 11 дүгээр саруудын хэрэгжилтийн явцын тайланг болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын 2024 оны шинэчилсэн Хөлсөөр ажиллах гэрээг цаг тухайд нь оруулан ажилласан. "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс/" төслийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, хүний хүчин	100

				зүйлсээс шалтгаалах эрсдэлийг бууруулах, хяналт тавих, үнэлэх, тайлагнах зорилгоор төслийн нэгжийн нэгдсэн санг “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн удирдлагын мэдээллийн систем” ODAMIS-д үүсгэн төслийн гэрээ хэлэлцээр байгуулах үе шатнаас эхлээд төсөл хэрэгжиж дуусах хүртэлх төслийн баримт бичгийн бүрдлийг оруулан ажиллаж байна.	
<b>ЗОРИЛГО ТАВ. АЙМГУУДЫН /БАЯН-ӨЛГИЙ, ГОВЬСҮМБЭР, ЗАВХАН, УВС, ДОРНОД/ НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГЫГ ЧАДАВХЖУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД</b>					
<b>ЗОРИЛТ 1. Төслийн аймгуудын НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг гадаад болон дотоод сургалт, семинарыг зохион байгуулах, хамруулах зорилтын хүрээнд:</b>					<b>100</b>
<b>69</b>	5.1.1	Төслийн менежментийн PMIS системийн сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулагдсан байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудад 2024 оны 1-р улиралд PMBOK (Project management Body of Knowledge) болон PMIS (Project management information system)-ийн талаар сургалтыг төслийн барилгын инженер М.Одмандах зохион байгуулсан.	100
<b>70</b>	5.1.2	Төслийн талбай дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах	Сургалт зохион байгуулагдсан байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд, туслан гүйцэтгэгч компанийн инженерүүдэд 2024 оны 1-р улиралд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг SAFETY TRAINING AND CONSULTING SERVICES LLC байгууллагаас зохион байгуулсан.	100
<b>71</b>	5.1.3	Төслийн аймгуудын НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах болон цэвэрлэх байгууламж дээрх технологийн болон дотоод сургалт	Сургалт зохион байгуулагдсан байна.	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд баригдаж буй БУЦБ-д ажиллах НААҮБ-ын инженер техникийн ажилтнуудад зориулсан онол-дадлагын сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтад Баян-Өлгий аймгийн нийтийн ах ахуйн үйлчилгээний “СУАТ” ХХК; Говьсүмбэр аймгийн нийтийн ах ахуйн үйлчилгээний “УС ДУ” ОНӨААТҮГ; Завхан аймгийн нийтийн ах ахуйн үйлчилгээний “АМЬ-УС” ХХК; Увс аймгийн нийтийн ах ахуйн үйлчилгээний “ЧАНДМАНЬ-УВС” ХХК-ийн төлөөллүүд, инженерүүд хамрагдав. Баян-Өлгий, Завхан, Увс, Говьсүмбэр аймгуудын Бохир ус цэвэрлэх байгууламжийн инженер, техникийн ажилтнуудыг дадлагын сургалтаар Дархан-Уул аймгийн төвд баригдсан Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцуулж, Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээний горимын талаарх ойлголтыг нарийвчилж олгов.	100
<b>72</b>	5.1.4	Төслийн аймгуудын НАА байгууллагын инженерүүдийг ШУТИС-д сургах	Сургалт зохион байгуулагдсан байна.	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй Баян-өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжуудыг хариуцан ажиллахаар суралцаж байгаа инженерүүдийн судалгаагаар нийт 4 аймгийн 10 оюутан Ус хангамж ус цэвэрлэгээний чиглэлээр суралцаж байгаа бөгөөд 9 оюутан Шинжлэх Ухаан Технологийн Их сургуульд; 1 оюутан Техник Технологийн коллежид суралцаж байна. Үүнээс: ● Баян-Өлгий аймгийн 3 оюутан / ШУТИС/-д;	100

				<ul style="list-style-type: none"> <li>● Говьсүмбэр аймгийн 2 оюутан /ШУТИС; ТТ коллеж/;</li> <li>● Увс аймгийн 2 оюутан / ШУТИС/-д;</li> <li>● Дорнод аймгийн 3 оюутан / ШУТИС/-д тус тус суралцаж байна.</li> </ul> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024.11.19-ний өдрийн а/301; а/302; а/303; а/304 тоот албан бичгээр байгууллагын хүний нөөцийн дутагдалтай байдлын талаарх судалгаа, эрэлт хэрэгцээнд тулгуурлан дотоодын их, дээд сургуулиудад суралцуулах шаардлагатай мэргэжлийн чиглэлийн талаарх холбогдох саналыг Төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлж, НАА-н байгууллагад шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад хамтран ажиллахыг хүссэн албан бичгийг Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын Нийтийн аж ахуйн “СУАТ” ХХК-д; “УС ДУ” ОНӨААТҮГ-Т; “АМЬ-УС” ХХК-д; “ЧАНДМАНЬ-УВС” ХХК-д тус тус хүргүүлээд байна. Тайлант хугацаанд Говьсүмбэр аймгийн “УС ДУ” ОНӨААТҮГ-аас саналаа ирүүлээд байна.</p>	
73	5.1.5	БНПУ-д орон нутгийн нийтийн аж ахуйн инженер, техникийн ажилчдыг БНПУ-д дадлагжуулах гадаад сургалт зохион байгуулах ажлын бэлтгэл ажил хангах	Сургалт зохион байгуулах ажлын бэлтгэл ажил хангагдсан байна.	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжуудын ерөнхий гүйцэтгэгч “Smart Waste Technologies” Sp.zo.o компаниас 2024.09.10-ны өдөр Гадаад сургалтын төлөвлөгөөг ирүүлж, Төсөл хэрэгжүүлэх нэгжээс төлөвлөгөөнд саналаа тусгуулан БНПУ-д зохиогдох гадаад сургалтад Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн нийтийн аж ахуйн байгууллагаас тус бүр 1 инженер нийт 4 инженер сургахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан.	100
74	5.1.6	БНПУ-д Орон нутгийн НАА байгууллагын удирдлагын менежментийн гадаад сургалт зохион байгуулах ажлын бэлтгэл ажил хангах	Сургалт зохион байгуулах ажлын бэлтгэл ажил хангагдсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>● Орон нутгийн удирдлага, ажилтнуудад танилцуулга хийх ба БУЦБ-ийн технологийн схем, цэвэрлэх байгууламжийн анхан шатны сургалт, мэдээлэл</li> <li>● БУЦБ-ийн механик хэсэг, онолын танилцуулга, ашиглалтын практик сургалт</li> <li>● БУЦБ-ийн биологийн хэсэг, онолын танилцуулга, ашиглалтын практик сургалт</li> <li>● БУЦБ-ийн лагийн хэсэг, онолын танилцуулга, ашиглалтын практик сургалт</li> <li>● БУЦБ-ийн бүтэн буюу цогц бүрэн тойм, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, зааварчилгаа, ашиглалтын гарын авлага, тайлан, лабораторийн шинжилгээ, ашиглалтын зориулалтаар ашиглах арга барил зэрэг бусад нарийвчилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд нийт 10 өдрийн сургалт дадлага хийхээр төлөвлөгөөнд тусган, Төслийн захирлаар батлуулсан.</li> </ul>	100

Төслийн нэгжийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “хангалтгүй” 0-30, “эрчимжүүлэх шаардлагатай” 50%-тай үнэлэгдсэн 15 арга хэмжээнүүд байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “Үр дүнгүй” буюу 0-30%-тай 14 арга хэмжээ байна. Үүнд:

“Үр дүнгүй” буюу 0%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ

1. 2.1.18. БОНУ, БОЕУ-ний төлөвлөгөөг холбогдох газруудаар батлуулах /Дорнод/;
2. 2.1.20. Гэрээт ажлын цар хүрээг тодорхой болгох /Дорнод/;
3. 2.1.22. Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах /Дорнод/;
4. 2.1.23. Барилга угсралтын ажил эхлүүлэх /Дорнод/;



5. 2.1.24. Гадна цахилгаан хангамжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх /Дорнод/;
6. 2.1.28. Тоног төхөөрөмжийн захиалга хийх, үйлдвэрлэх /Дорнод/.

“Үр дүнгүй” буюу 30%-ийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ

1. 2.1.7. Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын гадна ариутгах татуургын шугамын ажлыг улсын төсөвт суулган гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
2. 2.1.8. Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан аймгийн биоцөөрмийн хуучин картуудыг суллаж лагийг зайлуулах ажлыг орон нутагт уламжилж хийлгэх;
3. 2.1.9. Говьсүмбэр аймгийн Хотын насос станцын барилгын ажлыг улсын төсөвт суулгах, барилгын ажлыг цэвэрлэх байгууламжийн ажилтай уялдуулан хийлгэх;
4. Тоног төхөөрөмж угсрах, суурилуулах /Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс/;
5. 2.1.17. Ажлын зураг төсөл, төсвийн тооцоог эцэслэж экспертизээр батлуулах /Дорнод/
6. 2.1.19. Магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах /Дорнод/;
7. 3.4.3. Цэвэрлэх байгууламжид лаборатори болон лаг усгүйжүүлэх байгууламжид ашиглагдах химийн бодис, урвалжийг нийлүүлэх, хадгалалтын талаар судалгаа хийх, лагийг байгалийн шохойгоор боловсруулах арга норм дүрэм, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулах холбогдох судалгааг хийх;
8. 3.4.4. Бүгд найрамдах Польш улсаас нийлүүлэгдэх Цэвэрлэх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын норм, стандартад нийцлийн талаар холбогдох судлагааг хийх, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулан, НААҮБ-ын чадавхийг бэхжүүлэх, инженер техникийн ажилчдыг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.1.10. Завхан аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн аваарын сангийн зураг төсөлд тусгагдсан төлөвлөлтийн шийдлийг шинэчлэх.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. Төслийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн төслийн хэрэгжилтийн нийт түвшин 62.95 хувь, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 81.45 хувьтай “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.
2. Тухайн төсөл арга хэмжээ нь 5 аймгийн цэвэрлэх байгууламжийн ажил зэрэг явж байж гүйцэтгэл хэвийн явах боловч Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын хоцрогдлоос шалтгаалан жилийн төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэл буух шалтгаан болж байна.

## **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Төслийн нэгж /Ц.Ариунтуяа/-д үүрэг болгох:

1. Төслийн нэгж нь батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэгч байгууллагаас 2025 оны барилга угсралтын ажлын нэгдсэн төлөвлөгөө болон календарьчилсан төлөвлөгөөг гаргуулж төслийн нэгжийн төлөвлөгөөнд тусган дахин хойшлуулахгүйгээр төслийг хугацаанд нь дуусгах;
2. Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, төсөвт батлуулах, ажлыг эрчимжүүлж магадлалын дүгнэлтийг гаргуулан батлуулж, 2025 онд барилга угсралтын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах;
3. Төслийн нэгжийн 2024 оны “Үр дүнгүй” буюу 0-30%-тай 14, “Эрчимжүүлэх шаардлагатай” 50%-тай 1 арга хэмжээ, үнэлэх боломжгүй /ҮХ/ 5 арга хэмжээ, нийт 20 арга хэмжээг 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллах;
4. Барилгын талбайд ажиллах хүн хүч, машин механизмын хүчин чадал, тоног төхөөрөмжийн татан авалт, бараа, материалын нөөцлөлт, барилгын талбайн зохион байгуулалтын үйл ажиллагааг сайн оновчтой төлөвлөн зохион байгуулж, барилга байгууламжийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах ажлын төлөвлөгөө, графикийг холбогдох байгууллагуудтай хамтран гаргаж батлуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллах;
5. Төслийн нэгжийн 2025 оны төлөвлөгөөг холбогдох байгууллагатай уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч батлуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахад хяналт тавих, ажиллах

нөхцөл бололцоогоор хангаж ажиллахыг НААБЗГ /О.Мөнхбаяр/-т, санхүү, хөрөнгө оруулалтын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг СХОГ /Ц.Ариунсанаа/-т тус, тус даалгасугай.

“ДАРХАН ХОТЫН ЦЭВЭР УСНЫ ШУГАМ СҮЛЖЭЭГ ӨРГӨТГӨХ, ШИНЭЧЛЭХ, УХААЛАГ  
ТООЛУУР НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ”- ИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

### **ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Бүгд найрамдах Австри Улсын Экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”- ийн нэгжийг Сангийн сайдын 2023 оны 113 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог 6 албан хаагчтай баталсан.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Дархан-Уул аймгийн ЗДТГ

Төслийн нэгж: “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”- ийг хэрэгжүүлэх нэгж

Төсөл хэрэгжих хугацаа: 2023-2025

Төсөвт өртөг: 7,5 сая евро

Гүйцэтгэгч байгууллага: Ерөнхий гүйцэтгэгч “ТИ АР ЭМ” ХХК, туслан гүйцэтгэгч “Мелиорекс” ХХК

Төслийн зорилго: Усны нөөцийг хамгаалахад бодит хувь нэмэр оруулж Дархан хотын усны алдагдлыг бууруулах, усны зүй зохистой хэрэглээг дэмжих, ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг сайжруулан хэрэглэгчдийг баталгаат ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээгээр хангах нөхцөлийг дээшлүүлэх, Дархан хотын усны хэрэглээнд ухаалаг систем нэвтрүүлж, Монголын анхны ухаалаг хэрэглээтэй цахим хот болгоход оршино.

Төслийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- ✓ Батлагдсан зураг төслийн дагуу инженерийн шугам сүлжээний угсралт хийж, ашиглалтад оруулах, ил болон далд акт үйлдэн баталгаажуулах;
- ✓ Техникийн комисс ажиллуулах,
- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах, комисс ажиллуулах,
- ✓ Ухаалаг тоолуур суурилуулж нэвтрүүлэх;
- ✓ Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг явуулах;
- ✓ Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлсэн байна.

#### Төслийн хүрэх үр дүн:

- ✓ Дархан хотын инженерийн дэд бүтцийг сайжран, ус хангамжийн насжилт өндөртэй 13,3 км шугам хоолойгоор шинэчлэгдэнэ.
- ✓ Усны зүй зохистой хэрэглээ бий болж, Дархан хотын усны алдагдлыг буурч, 15000 усны ухаалаг тоолуур суурилагдан, ухаалаг систем нэвтэрнэ.
- ✓ Инженер техникийн ажилчдын мэдлэг чадавх дээшилж, нийт хэрэглэгчдийн цэвэр усны хэрэглээний боловсрол нэмэгдэнэ.

### **ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн 2024 оны цэвэр усны шугам хоолойг суурилуулах бэлтгэл ажлын болон барилга угсралтын ажлын календарчилсан төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сард батлуулсан байна.

Шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 5 зорилт, 29 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төслийн хэрэгжилтийн нийт түвшин 66,6 хувь, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 83,1 хувь, төслийн хэрэгжилтийг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Арга хэмжээний нэр	Нийт хувь
	Ажлын нийт түвшин	66,6
	2024 оны төлөвлөгөөний биелэлт	83,1

Төслийн хүрээнд 2024 онд 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувь хэрэгжсэн 20 арга хэмжээ, 90 хувьтай 1, 70 хувьтай 0 арга хэмжээ, 50 хувьтай 4, 30 хувьтай 4, 0 хувьтай буюу хэрэгжээгүй 0, хугацаа болоогүй 3 арга хэмжээ байна.

#### 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАДАРГАА

№	Ажил үйлчилгээ	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Биелэлт хувь
				100	90	70	50	30	0	
1	Нийт арга хэмжээ	5	29	20	1	-	4	4	-	83,1

#### ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Төслийн зорилт, арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилт	Үнэлгээ
<b>ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ УГСРАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР</b>				
1.1	Уян ширмэн хоолой, холбох хэрэгслийн татан авалт	I-II	2024 онд 4000 м уян ширмэн хоолой, холбох хэрэгслийн захиалга, татан авалт хийгдсэн.	100
1.2	Төслийн байршлуудад цэвэр усны уян ширмэн хоолой угсрах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх	II-IV	2024 онд төслийн 8 байршилд Ф150мм-Ф600мм-ийн голчтой /2-р өргөгч станцын дэргэдэх Ф400мм-ийн голчтой худгаас “Дархан Нэхий” ХХК-ийн дэргэдэх уулзварын худаг хүртэл цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, Хатуу төмөрлөгийн дэргэдэх юүлэгчтэй худгаас “Улаанбаатар гурил”ХХК-ийн дэргэдэх худаг хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, “Дархан нэхий” ХХК уулзварын дэргэдэх худгаас “ДДСтанц” ТӨХК-ийн мазут орох худаг хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, 2-р өргөгч станцын дэргэдэх худгаас Өндрийн сан хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, 2-р өргөгч станцын дэргэдэх худгаас “Дархан нэхий” ХХК-ийн хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, 2-р өргөгч станцын дэргэдээс “Улаанбаатар гурил” ХХК хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, Батлан хамгаалахын дэргэдэх Ц92.15-с Ц92.23 худаг хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил,Алтны уулзварын дэргэдэх Ц41 худгаас Төмөр замын 78 айлын орон сууцны байрны дэргэдэх худаг хүртэлх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил/ нийт 5879.6 метр уян ширмэн хоолойг угсарсан.	50
1.3	Нөхөн сэргээх тохижилтын ажил хийх	II-IV	Цэвэр усны шугамын трассын дагуу 5879.6 м газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийж ажиллалаа.	100

1.4	Шугам хоолой суурилуулах ажилд үе шатны болон өдөр тутмын хяналт хэрэгжүүлэх	II-IV	Төслийн хүрээнд "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур суурилуулах ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг Барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/, Төсөл хэрэгжүүлэх нэгж, "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ийн хооронд байгуулсан 2023 оны 2023/298 дугаартай гэрээний дагуу үе шатны хяналтыг 5 удаа хэрэгжүүлэн ажилласан. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүд өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн.	100
1.5	Уян ширмэн хоолойн угсралтын ажилд ил болон далд ажлын акт үйлдэж баталгаажуулах	II-IV	VRS-T маркийн Ф150мм-Ф600мм-ийн уян ширмэн хоолойн угсралт суурилуулалтын ажилд даралтаар ус шахаж шалган, 5879.6 м уян ширмэн хоолойн ил далд ажлын акт үйлдэн баталгаажуулан ажилласан.	50
1.6	Техникийн комисс ажиллуулах	IV	Хугацаа болоогүй байна.	30
1.7	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах	IV	Хугацаа болоогүй байна.	30
<b>2. УХААЛАГ ТООЛУУР СУУРИЛУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
2.1	БНХАУ-аас 15000 ширхэг тоолуур, холбох хэрэгсэл, захиалга, татан авалт, суурилуулалт	I-IV	Эхний ээлжийн 5000 ширхэг ухаалаг тоолуур, холбох хэрэгслийн захиалга, татан авалт хийгдсэн. 2 дугаар ээлжийн 5000 ширхэг тоолуурыг үйлдвэрлэж, туршилт тохиргоо хийж, ханган нийлүүлэхээр тээвэрлэлт хийгдсэн. Эхний ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлүүлж, цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажлыг төслийн төслийн гүйцэтгэгч компаниас 9 бригад, 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. 4409 ширхэг тоолуур суурилуулж, ил далд ажлын актыг захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч талуудын төлөөллийг оролцуулан гарын үсэг зурж, баталгаажуулсан. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 01-А/349 дүгээр захирамжаар төслийн хүрээнд 15000 ширхэг ухаалаг тоолуур суурилуулах ажилд хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг 2024 оны 11-р сарын 15-ны өдөр хуралдаж, ухаалаг тоолуур суурилуулалтын ажил холбогдох норм, дүрмийн хүрээнд чанарын шаардлага хангасан гэж үзэн, дэмжсэн шийдвэр гарсан. 2024 онд 4850 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулаад байна. Цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулсанаар "Дархан-Ус суваг" ХК-ийн усны балансыг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад олборлосон болон борлуулсан усны эдийн засгийн үр ашиг өссөн нэмэгдэж, усны алдагдал буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2023 оны 10-р сард 225,5мян.м3 цэвэр ус олборлож, 170,4мян.м3 ус борлуулж, усны алдагдал 24,43% байсан бол 2024 оны мөн үед 226,8мян.м3 цэвэр ус олборлож, 178,8мян.м3 ус борлуулж, усны алдагдал 21.16% болж буурсан үр дүн гарсан байна.	50
2.2	17 ширхэг Gateway антенн татан авалт, суурилуулалт	I-III	Нийт 16 ширхэг Гейтвей антенныг Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын 15, 17-р	100

			сургууль, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн даатгалын газар, 22-р цэцэрлэг, 14, 15-р багийн байр зэрэг газруудын дээвэр дээр суурилуулж, нөөцөд 1 антенныг үлдээсэн. Антенныг ухаалаг тоолуур болон компьютерийн серверт таниулах ажил хийгдсэн. 16 ширхэг Гэйтвэй антенны гүйцэтгэлд хяналт, дохиоллын тохируулга хийгдсэн байна.	
2.3	Тоолуурыг үйлдвэрийн унтаа байдлаас /Sleep mode/ сэрээж бүртгэлжүүлэх	I-IV	Эхний ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуурыг унтаа байдлаас сэрээж, бүртгэлжүүлэн угсралтын ажлыг гүйцэтгэсэн.	30
2.4	Тоолуурыг төлөвлөсөн бүсүүдэд суурилуулах айл өрхийн жагсаалт гаргах, холболтын зураг хийлгэх, СХЗГазраар тоолуурын баталгаажуулалт хийлгэх	I-IV	Эхний ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуурыг суурилуулах ажлын төлөвлөгөө буюу айл өрх, аж ахуйн нэгжийн жагсаалтыг гарган 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр батлуулан, хяналт тавин ажилласан. Ухаалаг тоолуурыг унтаа байдлаас сэрээж, баталгаажуулах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн газрын эрх бүхий мэргэжилтнүүд "Дархан-Ус суваг" ХК-ийн цэвэр усны итгэмжлэгдсэн лабораторид хийж гүйцэтгэсэн. Энэхүү тоолуур нь "Хүйтэн усны тоолуур шалгах арга хэрэгсэл" MNS 2662:2002 стандарт болон "Ундны хүйтэн ус ба халуун усны тоолуур, хэмжил зүйн ба техникийн шаардлага" MNS OIML R 49-1:2020 стандартын шаардлагад нийцсэн тул ухаалаг тоолуур бүрт Стандарт, хэмжил зүйн газраас баталгаажуулалтын гэрчилгээг 6 жилийн хугацаатай олгосон.	50
2.5	Төслийн хүрээнд Фэйсбүүк болон цахим хуудсуудад байршуулсан төслийн талаарх мэдээллүүдэд өгсөн сэтгэгдэлд дүн шинжилгээ хийж, олон нийтэд чиглэсэн зөв мэдээлэл, зөвлөмж, ойлголт өгөх	I-IV	Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, "Дархан-Ус суваг" ХК, Монголын үндэсний мэдээллийн агентлаг /монцамэ/, Дархан-Уул аймгийн телевиз, хэвлэл мэдээллийг хэрэгсэлтэй хамтран цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хандаж зөв мэдээлэл, ойлголт өгсөн. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан "Барилга, хүрээлэн буй орчны инженерчлэл ба технологи 2024" үзэсгэлэнд оролцсон. Тус үзэсгэлэнд төслийн хэрэгжилт явц байдал, уян ширмэн хоолой, цэвэр усны ухаалаг тоолуурын талаар олон нийтэд хандсан зөв мэдээллээр ханган, сурталчлан таниулах ажлыг хийж ажилласан. ХББОСЯ-ны цахим хуудсанд 2 удаа төслийн хэрэгжилтийн талаарх мэдээг байршуулж ажилласан. Мөн төслийн ашиглагч "Дархан-Ус суваг" ХК-тай хамтран хэрэглэгчдэд цэвэр усны ухаалаг тоолуур, хэмнэлттэй хэрэглээний талаар мэдлэг олгох зөвлөмж бүхий хэвлэмэл хуудсыг гарган, хүргэж ажиллалаа.	100
2.6	Хэрэглэгчдэд хандан ухаалаг тоолуурын ач холбогдлын талаар сурталчлан таниулах ажил зохион байгуулах	I-IV	Цэвэр усны ухаалаг тоолуурын ач холбогдлыг сурталчлан таниулах ажлын хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгжээс "Дархан-Ус суваг" ХК-тай хамтран цэвэр усны ухаалаг тоолуурын талаар хэрэглэгчдээс судалгаа авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, "Дархан-Ус суваг" ХК-ийн цахим хуудсаар дамжуулан сурталчилан таниулах ажлыг 2-3 удаа зохион	100

			байгуулсан. Цэвэр усны ухаалаг тоолуурыг сурталчилах ажлын хүрээнд 200 хэрэглэгчдээс ухаалаг тоолуур суурилуулах ажлын талаар түүвэр судалгаа авлаа. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 95 хувь нь тоолуур суурилуулах ажлыг дэмжиж, тодорхой мэдээлэлтэй байгаа гэсэн бол 5 хувь нь огт мэдээлэлгүй гэсэн байна. Эдгээр хэрэглэгчдэд холбогдох мэдээлэл сурталчилгаа хийж ажиллалаа. Сурталчлан таниулах ажлын үр дүнд Дархан-Уул аймгийн хэрэглэгчид ухаалаг тоолуурын талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажил хэвийн явагдаж байна.	
<b>3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>				
3.1	Төслийн гүйцэтгэгч компанийн ажиллагсдад ХАБЭА-н заавар, зөвлөмжийг өдөр тутам өгөх, аюулгүй ажиллагааг ханган ажиллах, хяналт тавих	I-IV	Төслийн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч компанийн ажиллагсдад ХАБЭА-н заавар, зөвлөмжийг өдөр тутам өгсөн бөгөөд ХАБЭА-н сургалтыг 2024 оны 4, 10-р сард зохион байгуулсан. Ажиллагсдыг ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах, аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглээг байршуулах зэрэг ажлуудыг хангаж ажиллах, явцын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.	100
3.2	Төслийн хүрээнд ашиглагч болон гүйцэтгэгч компанийн инженер техникийн ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах	II-IV	Төслийн 2024 онд сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулан, хэрэгжүүлэн ажилласан. Сургалтыг зохион байгуулахад “Дархан-Ус суваг” ХК, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хороо, Стандарт, хэмжилзүйн газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, Гүйцэтгэгч “Ти Ар Эм” ХХК, туслан гүйцэтгэгч “Эм Ти Юу” ХХК хамтран ажиллаж, төсөл хэрэгжүүлэх нэгж болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч компани, “Дархан-Ус суваг” ХК-ийн 50-60 инженер, техникийн ажилтнууд хамрагдсан. Ухаалаг тоолуурын программ хангамжийн сургалтыг “Дархан-Ус суваг” ХК болон “ЕСМ” ХХК-тай хамтран 2024 оны 06 дугаар сард Дархан-Уул аймагт, 2024 оны 10 дугаар сард БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулсан.	90
<b>4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР</b>				
4.1	2024 оны зорилт, арга хэмжээний төлөвлөгөө болон сар бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг урд сарын 25-ны өдрийн дотор Барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/ хүргүүлэх, батлуулах	I-IV	Төслийн удирдах хорооны хурлаар 2024 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Сар бүрд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамаар батлуулан, тайланг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
4.2	Ажлын талбайд ажиллаж, гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллах	I-IV	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүд ажлын талбайд өдөр тутам хяналт хэрэгжүүлж ажилласан бөгөөд шугам угсралт, ухаалаг тоолуур суурилуулах багуудтай хамтран ажилласан. Төслийн гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх, мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангаж ажилласан.	100
4.3	Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар Барилга, хот байгуулалтын яамны /хуучин нэрээр/ төлөөлөл,	I-IV	Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төлөөлөл, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, төслийн гүйцэтгэгч	100

	Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, гүйцэтгэгч компани болон холбогдох газруудтай хурал, уулзалт зохион байгуулах		"Ти Ар Эм" ХХК, "Дархан-Ус суваг" ХК болон холбогдох байгууллагуудтай хурал, уулзалтыг 6 удаа зохион байгуулан ажилласан. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын гзарт хүсэлт хүргүүлж, 2024 оны 08 дугаар сард уулзалт зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 01-А/349 дүгээр захирамжаар төслийн хүрээнд 15000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажилд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хуралдуулж, ухаалаг тоолуур суурилуулах ажлын явц, ил далд ажлын акт, холбогдох мэдээ мэдээллийг танилцуулсан. Хурлаас ухаалаг тоолуур суурилуулалтын ажил холбогдох норм, дүрмийн хүрээнд, чанарын шаардлага хангасан гэсэн шийдвэр гарсан.	
4.4	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, төслийн тайлан, мэдээг холбогдох яам, газруудад хугацаанд нь хүргүүлж ажиллах	I-IV	Төслийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулж, төслийн гүйцэтгэгч "Ти Ар Эм" ХХК, туслан гүйцэтгэгч "Эм Ти Юу" ХХК-д санал, зөвлөмж хүргүүлсэн. Сангийн яам болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд Төслийн тайлан, мэдээг цаг тухай бүрд хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
4.5	Дархан-Уул аймагт тухай бүр томилолтоор ажиллах	I-IV	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төслийн захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2024 онд Дархан-Уул аймагт 30 удаа томилолтоор ажиллаж, тухай бүрд тайлагнан ажиллалаа.	100
4.6	Төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг батлуулах, тухай бүр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах	I-IV	Төслийн удирдах хорооны 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар 2024 оны төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулж, хэлэлцүүлэн, мөн өдрийн 02 дугаар тогтоолоор төлөвлөгөөг тус тус батлуулан, шийдвэр гаргуулан ажилласан.	100
4.7	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Төслийн зохицуулагчаар батлуулж, архивын нэгжийг тухайн онд бүрдүүлэн ажиллах	IV-V	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, Төслийн зохицуулагчаар батлуулж, архивын нэгжийг тухайн онд бүрдүүлэн ажилласан.	100
4.8	Төслийн хаалтын тайланг боловсруулах, тайлагнах	IV	Хугацаа болоогүй байна.	30
<b>5. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>				
5.1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх	I-IV	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2023 оны санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн тайланг боловсруулж, Сангийн яаманд хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	100
5.2	Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн нэхэмжлэх болон гааль, НӨАТ-с чөлөөлөх импортоор оруулж ирэх бараа, материалын нэхэмжлэх, тээврийн бичиг баримт, бусад холбогдох материалыг хянаж боловсруулж, Монгол Улсын	I-IV	Ажлын гүйцэтгэлийн 4,1 сая евро буюу 15,0 тэрбум төгрөгийн нэхэмжлэхийг хянаж, бичиг баримтыг бэлтгэн Шилэн дансны цахим хуудас болон Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системд байршуулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд илгээн ажиллалаа. Гүйцэтгэгч компаниас ирүүлсэн 1,3 сая евро буюу 4,7 тэрбум төгрөгийн импортын	100

	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /Odamis/, шилэн дансны /https://gap.mof.gov.mn/ сайтад байршуулж, Барилга, хот байгуулалтын яаманд /хуучин нэрээр/ албан бичгээр хүргүүлэх		барааг гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хүсэлтийг хянаж, "Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /Odamis/"-д байршуулан илгээж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Сангийн яаманд албан бичгээр хүргүүлж, гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэн ажилласан.	
5.3	Шилэн дансны /https://gap.mof.gov.mn/ сайтад болон Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /Odamis/-д хуулийн дагуу холбогдох мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулж, улирал бүр дээд байгууллагад тайлан хүргүүлэх	I-IV	2024 онд Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /Odamis/, шилэн дансны /https://gap.mof.gov.mn/ сайтад төслийн үйл ажиллагаатай холбоотой сар бүр мэдээлэн, нийт 155 удаагийн мэдээ, мэдээлэл, төсөв, гүйцэтгэл, санхүүжилтийг тухай бүрд хугацаанд нь байршуулсан. Мөн улирал бүр шилэн дансны тайланг Сангийн яамны ttps://info.shilendans.gov.mn/ шилэн дансны цахим системээр цаг тухайд нь илгээж ажилласан. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.	100
5.4	Гадаад зээлийн ашиглалтын тооцоог төлбөрийн гүйцэтгэгчээс ирүүлсэн баримтыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/, Гүйцэтгэгч болон Сангийн яамны Санхүү бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтэс, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газартай сар бүр тооцоо нийлж, баталгаажуулах	I-IV	Сангийн яам болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай гадаад зээлийн ашиглалтын тооцоо нийлж 4,1 сая евро буюу 15,0 тэрбум төгрөгийг анхан шатны баримтыг үндэслэн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэж тайлагнан ажилласан.	100
5.5	Сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргаж, батлуу-лан Барилга, хот байгуулалтын яамны /хуучин нэрээр/ Санхүү, хөрөнгө оруулалтын газар болон Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсээр хянуулж, улсын мэдээнд оруулах, НДШ, ХХОАТ-ын тайлан, Гааль, НӨАТ-ын тайлан бэлтгэж, холбог-дох байгууллагуудад хүргүүлж, хянуулах	I-IV	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган өгч, жилээр нийт 15,531.9 сая төгрөгийг Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэст мэдээллэн ажилласан. Ажиллагсдын цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгож, нийгмийн даатгалын болон татварын байгууллагатай холбогдох тооцоо, тайланг өгч баталгаажуулсан.	100
5.6	Төсөл хэрэгжүүлэх нэгж-ийн санхүүгийн тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж холбогдох байгуул-лагад тайлагнах, 2023 оны санхүүгийн аудитын дүг-нэлт, зөвлөмжийг хэрэг-жүүлж ажиллах, тайлан хүргүүлэх.	I-IV	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргаж, 2024 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний Аудитын Газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн бөгөөд Сангийн яаман дээр түүвэр аудитад оруулж, зөрчилгүй гарсан. 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна.	100

**“Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:**

1. 1.2. Төслийн байршлуудад цэвэр усны уян ширмэн хоолой угсрах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх,
2. 1.5. Уян ширмэн хоолойн угсралтын ажилд ил болон далд ажлын акт үйлдэж баталгаажуулах,



3. 2.1. БНХАУ-аас 15000 ширхэг тоолуур, холбох хэрэгсэл, захиалга, татан авалт, суурилуулалт

4. 2.4. Тоолуурыг төлөвлөсөн бүсүүдэд суурилуулах айл өрхийн жагсаалт гаргах, холболтын зураг хийлгэх, Стандарт хэмжил зүйн газраар тоолуурын баталгаажуулалт хийлгэх

“Үр дүнгүй” 30 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. 1.6. Техникийн комисс ажиллуулах
2. 1.7. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах
3. 2.3. Тоолуурыг үйлдвэрийн унтаа байдлаас /Sleep mode/ сэрээж бүртгэлжүүлэх
4. 4.8. Төслийн хаалтын тайланг боловсруулах, тайлагнах

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Төслийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ жилийн эцсийн байдлаар 89,2 хувьтай үнэлж ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 83.1 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

## **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Төслийн нэгж /А.Пүрэвсүрэн/-д үүрэг болгох:

1. Үйл ажиллагааг оновчтой төлөвлөн, зохион байгуулах,
2. Барилга байгууламжийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах, батлуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллах,

Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахад хяналт тавих, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, санхүү, хөрөнгө оруулалтын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг НААБЗГ /О.Мөнхбаяр/, СХОГ /Ц.Ариунсанаа/-т тус, тус даалгасгай.

“НОГООН НУУР 1008 АЙЛЫН ОРОН СУУЦ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

## **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төслийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

## **ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Төслийн зорилго: Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг барьж ашиглалтад оруулсанаар хүн амын орон сууцны хангамж, хүртээмж нэмэгдэж, гэр хорооллын оршин суугчдын ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэж, байгаль орчны бохирдол багасан, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХБОСЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2025.06.15.

Хөрөнгө оруулалтын хэмжээ: Нийт 347,4 сая юань, үүнээс БУА-ын зардал – 328,7 сая юань, Хятадын талын төслийн менежментийн зардал - 11,4 сая юань.

Төслийн зорилтууд:

Зорилт-1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг цаг тухайд нь холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд тасралтгүй хэвийн явуулах нөхцлийг хангаж ажиллах;

Зорилт-2. “Ногоон нуур 1008 айлын орон сууц”-ны төслийн барилга угсралтын ажлыг барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм нормативын баримт бичиг, батлагдсан зураг төслийн дагуу чанартай гүйцэтгүүлэх;

Зорилт-3. Төслийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах.

**Төслийн товч танилцуулга :**

Энэхүү төслийг дараах шийдвэрүүдийг үндэслэн хэрэгжүүлж байна. Үүнд:

-Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичиг;

-Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2016 оны 07 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээр;

-Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулагдсан “Солилцох захидал”;

-БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Засгийн газар болон Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны хооронд 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан “УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх протокол”.

Төслийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр УБ хотын Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт 1008 айлын 8 блок орон сууцны барилгыг авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барина.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайд болон БХБСайдын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан 27/30 дугаар тушаалаар, нэгжийн дүрмийг БХБСайдын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 70 дугаар тушаалаар тус тус батлуулан ажиллаж байна.

**ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төслийн хэрэгжилтийн түвшин 2024 оны жилийн эцсийн байдлаар 75 хувь, төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 96 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

**Төслийн хэрэгжилтийн түвшинг харуулбал:**

Төслийн хэрэгжилт-ийн үнэлгээ /хувь/	Хэрэгжилт /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	2024 оны төлөвлөгөөний биелэлт 96%	3	98,3	92,6	100
Төслийн хэрэгжилтийн түвшин - 75%					

Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 46 арга хэмжээг дүгнэхэд хэрэгжилт **96** хувьтай байна. Үүнд:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Биелэлт	Үнэлгээ
<b>Зорилт 1: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг цаг тухайд нь холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд тасралтгүй хэвийн явуулах нөхцлийг хангаж ажиллах</b>				<b>99,5</b>
1	1.1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Төлөвлөгөөг оновчтой төлөвлөн боловсруулж, 2024 оны 1 дүгээр улиралд батлуулсан байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгж /ТХН/-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг оновчтой төлөвлөн боловсруулж, 2024 оны 1 дүгээр сарын 05-ний өдөр Төслийн захирал бөгөөд БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулгаар батлуулсан.	100
2	1.2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан тус бүрийн ажлын хийх	Төлөвлөгөө цаг хугацаандаа боловсруулагдан, биелэлтийг	Төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 96 хувьтай хэрэгжсэн байна.	90

	төлөвлөгөөг сар, улирал, жилээр гарган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	хангаж ажилласан байна.		
3	1.3. Сангийн яамны төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан <a href="http://www.odamis.mof.gov.mn">www.odamis.mof.gov.mn</a> сайтад мэдээллийг цаг тухай бүрт оруулж шинэчлэх	Цахим системд оруулсан тайлангийн тоо	Уг зорилт арга хэмжээний хүрээнд Сангийн яамны төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан <a href="http://www.odamis.mof.gov.mn">www.odamis.mof.gov.mn</a> сайтад ТХН-ийн 3 ажилтан нэвтрэх эрхтэй бөгөөд нийт 85 мэдээллийг оруулсан байна..	100
4	1.4 Харуул хамгаалалтын ажлын явцад байнгын хяналт тавьж, 7 хоног, сар, улиралд тайлан гаргуулж дүгнэж ажиллах.	-Гэрээний хүрээнд үүргээ биелүүлж ажилласан талаар улирал тутамд тайлан гаргана. -Харуул хамгаалалтын ажлын явцад байнгын хяналт тавьж ажиллах	Харуул хамгаалалтын компанийн тайланг өдөр, 7 хоног, сараар авч биелэлтийг хянан ажиллаж байна.	100
5	1.5. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт-шинжилгээ хийж, Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн хяналт-шинжилгээний тайлангийн загвар” маягтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд ТУХ-нд хагас жил тутам танилцуулна.	Зөвлөмж гаргаж, ТХН-ийн зохицуулагчид танилцуулсан байна.	ТХН-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хяналт шинжилгээ хийж 2024.10.20-нд зөвлөмж гарган төслийн зохицуулагчид танилцуулсан.	100
6	1.6. Төслийн явцын үнэлгээг гаргах	Төслийн явцын үнэлгээг гаргасан байна.	Төслийн явцын үнэлгээг гаргаж хагас жил, гуравдугаар улирлын тайланд тусган ХББОСЯаманд хүргүүлсэн.	100
7	1.7. Барилгажих талбайн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэх /Гадна инженерийн шугам сүлжээ, авто замын трасс, Сургууль цэцэрлэгийн барилгажих талбайн газар чөлөөлөлт/	Барилга угсралтын ажилд саад учруулахгүйгээр газар чөлөөлөгдсөн байна.	2024 оны газар чөлөөлтөд 9 нэгж талбар газар хамрагдахаар төлөвлөсөн бөгөөд, 7 айл чөлөөлөгдсөн байна.	70
8	1.8. ТУХ-г төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлагаар хуралдуулахад	ТУХ-ны тогтоолоор холбогдох асуудлуудыг цаг тухайд нь	Төслийн удирдах хороо 2024 онд нийт 7 удаа хуралдсан байна.	100

	шаардлагатай холбогдох баримт материалыг бэлтгэн ТХБ-д хүргүүлж, тогтоол болон зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	танилцуулан шийдвэрлүүлсэн байна.		
9	1.9. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бичгийн хэлний түвшинд төслийн нэгжийн баримт бичиг, яриа хэлэлцээрийг орчуулах	Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу төслийн нэгжийн өдөр тутмын орчуулгын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн байна.	2024 онд Албан бичиг -265 -Сар бүрийн хурлын тэмдэглэл: 12 сард -60 хуудас -Зөрчлийн хуудас-45 -Хурлын аман орчуулга нийт 144 цаг хийгдсэн байна.	100
10	1.10. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн архивын нэгжийг тухайн онд бүрдүүлэн ажиллах	Архивын баримт бичгийн стандартын дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн тухайн оны бичиг баримтыг архивын нэгж болгон хадгалсан байна.	Нийт-103 боть архивын материал архивласан байна.	100
11	1.11 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг төлөвлөн батлуулах, тайлагнах	Төлөвлөгөөг цаг хугацаанд нь батлуулсан байна.	“ТХН-ийн -1 дүгээр улирлын урсгал үйл ажиллагааны зардалд 486,485,700, -2 дугаар улирлын төсөвт 495,938,591 төгрөг -3 дугаар улирлын төсөвт 454,166,265 төгрөг тус тус батлагдсан байна. -4 дүгээр улирлын төсөвт 448,000,259 батлагдсан.	100
12	1.12. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох журмын дагуу өмчлөлийг шийдвэрлэхэд шаардлагатай баримтыг бүрдүүлж ажиллах	Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох журмын дагуу ажилласан байна.	2024 онд нийт <b>67,847,902,293.64</b> төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт шилжсэн. Гадаад тусламжийн ашиглалтын тооцоо нийлэн, ХББОСЯ-ны Санхүү,хөрөнгө оруулалтын газраар хянуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын ахлах мэргэжилтэнтэй тооцоо нийлэн баталгаажуулсан. -ХББОСЯ-нд 2024 оны 07 дүгээр сарын 17-ны А/254 тоот ашиглалтыг бүртгэж авах талаар албан бичгээр хүргүүлсэн. ХББОСЯ-ны эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэж авсан байна.	100
13	1.13 <b>2025</b> оны үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн санал боловсруулж, хүргүүлэх /ТХН нь ТУХ-оор батлагдсан үйл ажиллагааны болон худалдан авах	Төлөвлөгөө цаг хугацаандаа батлуулсан байна.	ТХН-ийн 2025 оны үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн хүрээний мэдэгдлийг 2024 оны төсөв болон БУА-ын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан ХББОСЯ-нд 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/184 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: Нийт 43 тэрбумын төсвийн хүрээний саналыг явуулсан. 2025 оны төсвийн	100

	ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн төсөл, арга хэмжээний ирэх жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8.4.2-т заасны дагуу боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх/		саналыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор хүргүүлсэн.	
14	1.14 Үйл ажиллагааны зардлын санхүүгийн тайлан тэнцлийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах, аудитын дүгнэлт хийлгэн баталгаажуулах	Төслийн санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргасан байна. 2023 оны санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргуулж баталгаажуулсан байна.	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2024 оны 01 дүгээр сарын 25-ны А/32 тоот албан бичгээр БХБЯ, Сангийн яам А/31, Үндэсний аудитын газарт А/33 тус тус хүргүүлэн, сангийн яамны Э-тайлангийн программд оруулан тайланг илгээсэн. 2023 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраас томилогдсон "Конфиденсе Аудит" ХХК санхүүгийн тайланд аудитын шалгалт хийлгэн Үндэсний аудитын газрын 2024 оны 02 дугаар сарын 28 ны өдрийн 07/523 тоот албан бичгээр зөрчилгүй буюу өөрчлөлтгүй санал дүгнэлт хүлээн авч, Аудитын дүгнэлтийг БХБЯ, СЯ-нд 2024 оны 3-р сарын 14-ний өдрийн А/81, А/80 тоот албан бичгээр хүргүүлсэн	100
15	1.15. Шилэн дансны мэдээллийг сар бүрийн 8-ны өдрөөс өмнө цахим хуудсанд тогтмол оруулах	Хуулийн хугацаанд мэдээллээ оруулсан байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн гүйлгээний болон худалдан авалтын талаарх мэдээллийг сар бүр, тогтмол шилэн дансны мэдээллийн санд сар бүр, нийт 33 мэдээлэл, тухай бүрт оруулан, 2 бүлгийн 109 мэдээлэл, нийт 142 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна. 1, 2, 3 дугаар улирлуудын шилэн дансны тайланг хуулийн хугацаанд илгээн ХББОСЯ-ны шилэн данс хариуцсан мэргэжилтэнд мэдэгдсэн байна.	100
16	1.16. Татварын болон нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	Татвар, нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулсан байна.	2024 оны 1-3 дугаар улирлын татварын тайланг бэлтгэн цахим татварын <a href="https://etax.mta.mn/">https://etax.mta.mn/</a> системд илгээн баталгаажуулсан.	100
17	1.17. Тухайн жилийн төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянан батлуулах, бүртгэх, тайлагнах	Засгийн газрын 2016 оны 176-р тогтоол болон холбогдох хууль журмын дагуу төлөвлөгөө гаргаж батлуулсан байна.	Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 38 дугаар тушаалаар МТХ хөрөнгөд 9,731,000,000 төгрөг батлагдсан.	100

18	1.18 Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг хянаж баталгаажуулан санхүүжилтийг шийдвэрлэх. Гадаад тусламжийн тооцоог холбогдох яамдтай нийлж баталгаажуулж ажиллах	Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг хянаж баталгаажуулан санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. Гадаад тусламжийн тооцоог холбогдох яамдтай нийлж баталгаажуулсан байна.	2024 онд нийт 3 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулан ХББОСЯ-нд -5 дугаар сарын 15-ны А/174 тоот албан бичгээр 28.026.406 юанийн - 10 дугаар сарын 07-ны өдөр А/414 тоот албан бичгээр 13.136.860.10, -11 дүгээр сарын 01-ний А/464 тоот албан бичгээр 34.382.470 юань, нийт үнийн дүн бүхий 75.545.736.1 юанийн БУА-ын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан хүргүүлсэн.	100
19	1.19 ТХН-ийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж тайланг хагас, бүтэн жилээр гарган батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, батлагдсан ажлуудыг хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулан тайланг хагас, бүтэн жилээр гаргасан байна.	2024 онд худалдан авалт байхгүй учраас Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй болно.	ҮБ
20	1.20. Төсөлд ажиллах гадаад ажиллах хүчнийг ажлын байрны хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах, оруулж ирэх, гаргах	Барилгын ажилд шаардлагатай ажиллах хүчний квот батлуулж, ажлын байрны хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулж, оршин суух зөвшөөрлийг авсан байна.	Монгол улсын Засгийн газрын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” 477 дугаар тогтоолоор төслийн барилга байгууламж дээр ажиллах 300 ажиллах хүч батлагдсанаас <b>276</b> ажилтан орж ирж төслийн барилгын ажил дээр ажилласан байна.	100
21	1.21. ТХН-ийн ажилтнуудын “Хөлсөөр ажиллах гэрээ”-г сунгуулах, жилийн эцэст үнэлүүлэх	ТХН-ийн ажилтнуудын “Хөлсөөр ажиллах гэрээ” сунгагдаж цахим системд оруулсан байна.	2024 оны 06 дугаар сарын 03-нд ТХН-ийн 20 ажилтнуудын “Хөлсөөр ажиллах гэрээ” батлагдсан.	100
22	1.22. Иргэд ААН, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэх	Иргэд ААН, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэсэн байна	2024 онд ТХН-д бичгээр болон аман хэлбэрээр өргөдөл гомдол ирээгүй байна.	100
23	1.23. Төслийн ХШҮ, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар БХБЯ-ны хэрэгжүүлж байгаа бусад төслүүдэд сургалт зохион байгуулах	Төслийн ХШҮ, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар бусад хэрэгжиж байгаа төслүүдэд сургалт зохион байгуулсан байна	2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтын үйл ажиллагаатай танилцах удирдамжийг батлан 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ТХН-ийн байранд тус үйл ажиллагааг зохион байгуулсан.	100

<b>Зорилт 2: “Ногоон нуур 1008 айлын орон сууц”-ны төслийн барилга угсралтын ажлыг барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм нормативын баримт бичиг, батлагдсан зураг төслийн дагуу чанартай гүйцэтгүүлэх</b>				<b>92,6</b>
24	2.1. Барилгын ажил гүйцэтгэх 2024 оны календарчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Батлагдсан төлөвлөгөөний дагуу барилгын ажил хийгдсэн байна..	Төслийн Барилгын ажил гүйцэтгэх 2022-2025 оны шинэчилсэн болон 2024 оны барилгын ажлын календарчилсан төлөвлөгөө 2024 оны 01 дүгээр сард ТУХ-ны тогтоолоор батлагдсан.	100
25	2.2. 2024 онд барилгын ажилд хэрэглэгдэх импортоор орж ирэх, дотоодын зах зээлээс худалдан авах барилгын материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, татан авалтын төлөвлөгөө гаргуулан хянан батлуулж, гааль НӨАТ-аас чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулна.	Барилгын ажил төлөвлөгдсөн хугацаанд саадгүй явах нөхцөл бүрдсэн байна.	2024 онд нийт 23 удаагйн хүсэлтээр 35.418.532.11 юанийн үнийн дүн бүхий бараа материалыг импортын гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлсэн байна. Татвараас чөлөөлөгдсөн бараа материал барилгын талбайд бүгд ирж барилгын ажилд хэрэглэгдэж байна.	100
26	2.3. Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг сунгуулах	Барилгын тухайн ажил эхлэхээс өмнө зөвшөөрлийг авсан байна	2024 оны 12-р сарын 31-нд Барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацаа дуусах бөгөөд, 11 дүгээр сард хугацаа сунгуулах хүсэлтийг ХББОСЯ-нд илгээж сунгагдсан байна.	100
27	2.4. Техникийн нөхцлүүдийн хүсэлтийг өгч шийдвэрлүүлэх, сунгуулах Дулаан, ЦБУ, Цахилгаан, Холбоо дохиолол	Барилгын ажил эхлэхээс өмнө зөвшөөрлийг авсан байна	Дулаан: 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн №86/2024 тоот техникийн нөхцөл Холбоо дохиолол: 2024 оны 05 сарын 01-ний өдрийн D-U2024/221 тоот , Ухат: УСУГ-ын 216/22 тоот техникийн нөхцлийн дугаартай техникийн нөхцөл авсан.	100
28	2.5. Барилгын ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын материалын сорил шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэж зохих дүгнэлтийг гаргуулсан байна.	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	2024 онд орж ирсэн барилгын материалын төрлүүд: 1. Барилгын материал: Бетон зуурмаг, фасадны материалууд, цонх, цонхны шил, цонхны туслах материалууд, гадна хаалга, заслын материал, 2. Инженерийн шугам сүлжээний материалууд: Салхивчны цайрдсан хоолой, цайрдсан ган хоолой, дотор, гадна шугам сүлжээний бүх төрлийн шугам хоолойнууд, туслах материалууд, усан сан, ган регистер, панелан халаах хэрэгсэл, цахилгаан хангамжын гадна, дотор кабель утаснууд, цахилгаан шат зэрэг орж ирсэн сорил шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэж зохих дүгнэлтийг гаргуулсан байна.	100
29	2.6. Барилгын ажлын үе шатны ажлуудад хөндлөнгийн	Тухайн онд хэрэгжүүлэх ажилд	2024 онд Барилгын ажлын үе шатны ажлуудад хөндлөнгийн хяналтыг 7 удаа хийлгэсэн байна	100

	хяналтыг бусад холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллах	хөндлөнгийн хяналт хийлгүүлсэн байна.		
30	2.7. Барилгын ажлын үе шатны ажилд зохиогчийн хяналт тавих ажлыг зохион байгуулах	Тухайн онд хэрэгжүүлэх үе шатны ажилд зохиогчийн хяналт хийлгүүлж тайлан, баталгаажуулсан байна	График төлөвлөгөөний дагуу 2024 онд зургийн зохиогч нь 41 удаа, шаардлагатай дуудагдсан тохиолдол 25 удаа төслийн талбайд ирж барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт хийж барилгын ажлын өдрийн тэмдэглэлд үүрэг даалгавар өгч, зургийн өөрчлөлттэй холбогдолтой асуудлаар газар дээр нь зөвшилцөн ажилласан байна.	100
31	2.8. Түр барилгын ашиглалтын хэвийн нөхцлийг хангах	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн байна.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженер техникийн ажилчдын ажиллах бололцоог хангах хүрээнд инженер техникийн ажилчдын түр байрны дотор шугамын сүлжээний урсгал засвар үйлчилгээг цаг тухай бүрд нь хийж, хэрэгцээний цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах ажлыг тогтмол зохион байгуулан ажилласан байна.	100
32	2.9. Барилгын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах.	Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, батлагдсан зураг төсөвтэй нийцсэн байна	2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт <b>143.985.253.6 юань</b> буюу -2022 онд 40.374.443.594.51 төгрөг -2023 онд 8.223.363.452.25 төгрөг -2024 онд: 1. 19.250.095.246.87 2. 13.047.132.692.07 төгрөг Нийт <b>67.847.902.293.64</b> төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.	100
33	2.10 Үндсэн бүтээцийн дутуу ажлуудыг гүйцээх /1-8 дугаар блок, нэгдсэн граж НГ-А, В /	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	Төслийн орон сууцны 8 блок, "НГ-А", "НГ-В" нэгдсэн гаражуудын барилгын дутуу ажлыг чанартай хийж дуусгуулах, хяналт тавих ажлын хүрээнд: - 1, 2, 3 дугаар блок барилгуудын техникийн давхар болон парапетны бетон цутгалтын ажил 2024 оны 05 дугаар сард хийгдэж дууслаа. - 1, 2, 4, 5, 6 дугаар блокуудын барилгын 1 дүгээр давхрын тагтны хэсгийн бетон цутгалтын ажил хийгдэж дуусав.	100
34	2.11 Гадна, заслын ажил /Гадна фасад, дээвэр, гадна өргөх шат гэх мэт/	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	1-р багцын 1-3р блокуудын парапет цутгалт-100% -1-8 дугаар блок нэгдсэн гражуудын дээврийн ажил- 98% -1-8 блок заслын ажил -90% -Нэгдсэн гражуудын дээврээс бусад ажлууд -98% -Цахилгааны дэд өртөө 1,2- 98% -Гадна инженерийн шугам сүлжээний ажил-99% -1-8 блок нэгдсэн гражын дотор дулааны шугам сүлжээ угсралт-100%	90
35	2.12 Дотор заслын ажил /Цонх, хаалга, шалны угсралтын ажил гэх мэт/	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм	1-р багц буюу 1-4-р блокуудын заслын ажлыг "Хос энх хөгжил" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд тайлант хугацаанд тагтны дулаалга, шал цутгалт, гипсэн тааз,	90



		нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	цонхны амалгаа, цагаан замаска татах ажил дунджаар 46 хувьтай хийгдсэн. “Баам электрик” ХХК 5-8-р блокуудын цонхны амалгаа, балконы дулаалга, шал цутгалт гипсэн тааз, цонхны амалгаа, балконы дулаалга, төмөр хаалга угсрах, цагаан замаска татах, цахилгааны “Дэд өртөө-2”-ын ханын өрлөг, хучилтын угсралтыг 100 хувь гүйцэтгэсэн байна. Үүнд: 5-р блок дээр 609 цонхны амалгаа хийхээс 97 хувь, балконы дулаалга 80%, шал цутгалт 100 хувьтай гүйцэтгэгдсэн, 6-р блок: шал цутгалт 5670м2-аас 100 хувь, гипсэн тааз 2849.28 м2 аас 63 хувь, цонхны амалгаа 606 м2-аас 100 хувь, балконы дулаалга 126 ш-ээс 100 хувь, 7-р блок: цонхны амалгаа 609 ш хийгдэхээс 97 хувь, 8-р блок: цонхны амалгаа 609 ш-ээс 100 хувь хийгдсэн байна. “Ганган анд” ХХК бүх блокуудын балконы хаалт /126 м2/, цонхны рам /480 м2/ угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Үүнд: Цонхны рам угсралтын ажил 97 хувьтай, балконы хаалтын угсралтын ажил 98 хувьтай хийгдсэн.	
36	2.13 Гадна инженерийн шугам сүлжээний ажлуудыг үргэлжлүүлж дуусгах	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна.	-Цэвэр бохир ус: 98% -Дулаан -95% -Цахилгаан-95% -Холбоо дохиолол-95% гүйцэтгэлтэй байна.	90
37	2.14 Дотор инженерийн шугам сүлжээний ажлуудыг хийх	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	<b>Дулаан</b> 1-8 блокуудын 1-р давхараас 21 дүгээр давхаруудад “АТТАЧР” ХХК , “Сэртэн констракшн” ХХК-ийн угсарч байгаа ф25-80мм-н халаалтын ган хоолойнууд болон ф100-350 мм-ийн салхивчийн цайрдсан хоолойнуудын угсралтын “Ажил гүйцэтгэх аргачлал”-уудыг хянаад ерөнхий инженер Б.Эрдэнсүрэнгээр баталгаажуулан, тус аргачлалуудыг мөрдүүлэн шугамын угсралтыг гүйцэтгүүлж байна. “НГ-А” гаражийн Блок №1, 2,3-ын холигч насос хүртэлх дулаан хангамжийн ф159-250 мм-ийн хэмжээтэй 231 метрийн урттай 2 хос шугам хоолойнуудын угсралт, 8 Ата даралттай хийгээр шалгаж актыг бүрдүүлсэн, <b>95%</b> гүйцэтгэлтэй байна. <b>УХАТ:</b> Барилгын хэрэгцээний халуун, хүйтэн ус хангамжийн систем нь доод бүс /зоорийн давхраас 12 давхар хүртэл/ дээд бүс /13 давхраас 21 давхар хүртэл/ гэж бүсчилсэн түгээлттэй мухардмал байх ба гол түгээх шугамууд нь зоорь	90

			<p>болон 12-р давхарын таазан доогуур явж босоо шугамуудад холбогдохоор зураг төсөлд тусгагдсаны дагуу угсралтын ажил явагдаж байна</p> <p><b>Цахилгаан:</b> Цахилгаан шат угсралтын ажлыг “Шидэ Сименс” ХХК гүйцэтгэж байна. 8 блок барилгын лифтний угсралт хийгдсэн-<b>100%</b></p> <p>1-р багцын цахилгаан холбоо инженерийн шугам сүлжээний ажлыг цахилгааны ажлын туслан гүйцэтгэгчээр “Сэртэн” ХХК инженер, техникийн 10-15 хүний бүрэлдэхүүнтэйгээр энэ онд ажиллан 2-21 давхар барилгын дотор монтажийг хийж дууссан- ажил <b>95%</b>-тай.</p> <p>Мөн 1-3 блокуудын дотор цахилгаан монтажийн босоо кабелийн тавиур угсрах ажил хийгдэж дууссан-<b>100%</b></p> <p>2-р багцын цахилгааны ажлын туслан гүйцэтгэгчээр “АТАЧР” ХХК ажиллаж цахилгаан холбоо инженерийн шугам сүлжээний ажлыг инженер, техникийн 18-21 хүний бүрэлдэхүүнтэй гүйцэтгэж байна. Цахилгааны кабель утас сувагчлал угсралтын ажлын чиглэлээр 4-8 блокуудын дотор цахилгаан монтажийн босоо кабелийн тавиур угсрах ажил хийгдэж дууссан-<b>95%</b></p> <p>5, 6, 7, 8 дугаар блокуудын дотор цахилгааны монтаж угсралтын кабель утас татах ажил 21 давхраас доош 2 давхар хүртэл хийгдэж дууссан байна-<b>95%</b></p> <p>Холбоо дохиолол: Блокийн галын дохиоллын сувагчлалын кабелийн сүвлэгээний ажил <b>96%</b>, НГА, НГБ дотор сүлжээ хийгдсэн.</p>	
38	2.15 Барилгажих талбайн буцаан дүүргэлтийн ажлуудыг үргэлжлүүлж дуусгах	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу хэрэгжүүлсэн байна	1-8 дугаар блокийн урд хэсэг, “НГ-А,В” гараажуудын урд болон хойд хэсэг, цахилгааны “Дэд өртөө-1”-ий эргэн тойронд шороон буцаан дүүргэлт, нягтаршуулалт хийгдсэн.	100
39	2.16 Барилга угсралтын ажлын үед хөтлөх, бүрдүүлэх шаардлагатай холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулж ажиллах	Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн дагуу бүрдүүлсэн байна	Барилгын ажлын үед хөтлөх, бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангуулах, улсын комиссд хүлээлгэн өгөх баримт бичгийн бүрдлийг ханган ажиллахад, ТХН болон төсөлд оролцогч талууд Монголын талаас ХББОСЯам, ТХНэгж, зураг төслийн “Интеллект Тауэр” ХХК-ийн инженерүүд, БНХАУ-ын талаас менежментийн “Жүн Ие баруун хойд инженерг технологи” ХХК, ерөнхий гүйцэтгэгч “Хятадын хоёр дахь Металлурги групп корпораци” ХХК талууд хамтран ажиллаж байна.	100

40	2.17 Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулах	Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулсан байна	ХАБАЭ-н зөвлөлийн хурал 7 хоног бүрийн даваа гарагт 14:00 цагаас хуралддаг бөгөөд 2024 онд нийт 19-н удаа хуралдаж, төслийн талбайд илэрсэн аюул, үл тохирлыг засаж сайжруулах хэрхэн арга хэмжээг аван ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.	100
41	2.18 Барилгын ажлын сар бүрийн төлөвлөгөө гарган батлуулах, тайлагнах	Барилгын ажлын сар бүрийн төлөвлөгөө гарган батлуулж, тайлагнасан байна.	Төслийн 1-11 дүгээр саруудын Барилгын ажил гүйцэтгэх график төлөвлөгөөг хянаж, ХББОСЯ-ны БМУБХЗГ-ын дарга бөгөөд, Төслийн захирал Д.Гантулгаар батлуулан ажиллаж байна.	100
42	2.19. Авто замын гадаргуугын ус зайлуулах далд байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил	Зөвлөх үйлчилгээний ажил хэрэгжиж, зурагт өөрчлөлт оруулж батлуулсан байна.	ТУХ-оор хэлэлцүүлэхээр 2 удаа материалаа хүргүүлсэн, одоогоор тодорхой шийдвэр гараагүй байна.	0
<b>Зорилт-3: Төслийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах</b>				<b>100</b>
43	3.1. Барилгын үйлдвэрлэлийн чанарын хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах	"Барилгын норм дүрэм" -12-01-09-г баримтлан ажилласан байна.	2024 онд -зөрчил үл тохирол-6 -Хяналтын хуудас-25, -АГА-12 -ыг бүртгэн хадгалж байна барилгын ажлын сар тутмын тайлан, нийт 8 удаагийн сарын тайлан ЕГ-ийн зүгээс боловсруулан ТХН-ийн ИТА нараар хянагдан баталгаажиж ирснийг бүртгэн цаасаар болон файлаар хадгалж байна. <b>Хурал:</b> ИТА нарын шуурхай хурал нийт 62 удаагийн хурал болсон. -Долоо хоногийн хурал нийт 22 удаа болсон. -Сарын тайлангийн хурлууд 6 удаа ТХН-ийн түр байранд болсон.	100
44	3.2. Зөвлөх үйлчилгээний эрхийг сунгуулах	Барилгын ажил чанартай хийгдсэн байна.	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл 2024.04.27-ний өдөр хүртэл 1 жилээр сунгагдсан.	100
45	3.3. Зөвлөх баг барилгын ажлын үе шатны ажлуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллана	Үйл ажиллагаанд хэрэгжсэн байна.	1-8 блокуудын 1-21 давхаруудад "АТТАЧР"ХХК "Сэртэн констракшн" ХХК-уудын хийж байгаа ф25-80мм-н халаалтын 10500 метрийн ган хоолойнууд болон ф100-350 мм-н салхивчийн цайрдсан 7450 метрийн урттай болон ф200-350 мм салхивчийн цайрдсан 6850 метрийн урттай хоолойнуудын угсралтанд зургын зохиогчтой хамтран <b>24 удаа</b> зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна.	100
46	3.4 Барилгын болон мэргэжлийн чиглэлийн сургалтад Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтануудыг хамруулах	Барилгын салбарын чиглэлийн сургалтад Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтануудыг хамруулсан байна	2024 онд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтануудыг нийт 11 удаа Барилгын болон мэргэжлийн чиглэлийн сургалтад хамруулжээ	100

<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>	<b>96%</b>
---------------------------------	------------

Ажил хийгдээгүй тасарсан 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

2.14. Авто замын гадаргуугын ус зайлуулах далд байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил.

Хэрэгжилт: ТУХ-оор хэлэлцүүлэхээр 2 удаа материалаа хүргүүлсэн, одоогоор тодорхой шийдвэр гараагүй байна.

### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. Төслийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 96 хувьтай, “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

### **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Төсөл хэрэгжүүлэх нэгж /Д.Од/-д үүрэг болгох нь:

1. Төслийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлж, холбогдох тайланг албан бичгээр болон цахимаар Төсөл, хөтөлбөрийн хэлтэст ирүүлэх;

2. Төслийн хэрэгжилтэд давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн тохиолдолд төлөвлөгөөнд тухай бүрд нь тодотгол хийж, Төслийн удирдах хороогоор шийдвэрлүүлж байх.

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР  
БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

### **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ**

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэхэд, энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

Хоёр. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл
Зээлдэгч:	Монгол Улсын Засгийн газар
Захиалагч байгууллага:	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Гүйцэтгэгч байгууллага:	БНХАУ-ын “Чайна тисижу сивил инженеринг групп” ХХК ба “Бээжин констракшн инженеринг групп” ХХК-уудын хамтарсан консорциум
Хүчин чадал:	250,000 м3/хоног бохир ус цэвэрлэх байгууламж
Зээлийн эх үүсвэр:	БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгох /1.0/ нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл
Тусгайлсан зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр:	2020 оны 01-р сарын 20-ны өдөр
Төслийн нийт өртөг:	262.7 сая ам.доллар
Төслийн санхүүжилт:	Монгол улс: 5% буюу 13.1 сая ам.доллар; БНХАУ: 95% буюу 249.6 сая ам.доллар.

Төслийн зорилго

Улаанбаатар хотод шинээр баригдах цэвэрлэх байгууламж нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ба хуучин цэвэрлэх байгууламжийн баруун талд био-цөөрмийг шинэчлэхээр төлөвлөсөн талбай дээр 17.6 га газарт баригдаж байна.

Төслийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь хоногт 250,000м<sup>3</sup> ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг Монгол улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой ба цэвэрлэх байгууламжаас гарах гаргалгааны усыг байгальд нийлүүлэхээс өмнө чанарын шаардлагыг хангахын тулд хэт ягаан туяаны UV төхөөрөмжөөр халдваргүйжүүлэгдэнэ. UV систем нь гаргалгааны усыг Туул голд нийлүүлэх, дахин ашиглагдахаас өмнө түүнд агуулагдах колиформ нянг устгаснаар Туул голд нийлүүлэх усны чанар сайжирч цэвэрлэх байгууламж ирээдүйд голын урсцыг нэмэгдүүлэх эх үүсвэр болно.

- Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр баригдана;
- Байгууламжаас гарах лаг багасах бөгөөд гарсан лагийг исгэлтийн аргаар тогтворжуулна;
- Гуравдагч цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт нь бохир усыг дахин ашиглах, Туул голын усны нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Байгууламжаас ялгарах эвгүй үнэр үнэртэхгүй;
- Байгууламжийн ойролцоо амьдарч буй оршин суугчдад дуу чимээ сонсогдохгүй;
- Байгууламжийг бүрэн автоматжуулснаар ашиглалтын зардлыг оновчтой болгож, эрчим хүчний хэрэглээг бууруулна;
- Лагийг мезофил зарчмаар био хий гарган авах технологийг нэвтрүүлэх;

Төв цэвэрлэх байгууламжид лагийн боловсруулалтад дэлхийн тэргүүлэгч технологийг хэрэглэхээр сонгосон. Лагийг мезофил зарчмаар био хий гарган авах замаар эрчим хүч ба дулаан гаргаж авснаар үйлдвэрлэлийн дотоод хэрэгцээний дулааныг ханган цэвэрлэх байгууламжийн ашиглалтын зардлыг нөхөж, цаашлаад эрчим хүч үйлдвэрлэдэг цэвэрлэх байгууламж болох эхлэл тавигдах юм.

#### ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл" нь 2024 онд 3 зорилтын хүрээнд 85 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90 хувьтай, "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэв.

Төслийн хүрээнд 2024 онд 85 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувь хэрэгжсэн 49 арга хэмжээ, 90 хувьтай 22 арга хэмжээ, 70 хувьтай 6 арга хэмжээ, 50 хувьтай 4 арга хэмжээ, 30 хувьтай 4 арга хэмжээ байна.

#### Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Ажил үйлчилгээ	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь						Биелэлт хувь
				100	90	70	50	30	0	
1	Нийт арга хэмжээ	3	85	49	22	6	4	4	-	90%

#### Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

№	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
<b>Зорилт 1. Барилга угсралтын ажлын хүрээнд</b>				
<b>1.1 Бэлтгэл ажил</b>				
1.	1.1.1 Төслийн 2024 оны барилга угсралтын бэлтгэл ажил	Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө шаардлагатай бараа материалын татан авалт, талбайн цэвэрлэгээ болон бусад бэлтгэл ажлуудыг гүйцэтгэнэ.	Барилга угсралтын ажил эхлэхийн өмнө шаардлагатай бараа материалын татан авалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хангах зорилгоор талбайн цэвэрлэгээ болон бусад бэлтгэл ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
<b>1.2 Бохир ус цэвэрлэгээний байгууламжуудын барилга угсралтын ажил</b>				

	1.2.1 Том завсартай сараалж ба оролтын насосын станц (DC01)	Төмөр бетон бүтээцийн угсралтын ажил, гадна ханын дүүргэлт болон дотор тусгаарлах ханын өрлөг, заслын ажил, хаалга, цонх суурилуулах ажил, дээвэр, гадна ханын дулаалга болон будгийн ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Том завсартай сараалж ба оролтын насосны станцын барилгын үндсэн төмөр бетон бүтээцийн ажил, гадна болон дотор ханын дүүргэлт өрлөгийн ажил, дээврийн ажил, гаралтын худгаас бусад гадна ханын дулаалга болон фасадны засал, дотор хана таазны заслын ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
3.	1.2.2 Нарийн завсартай сараалж ба агааржуулагчтай элс баригч (DC03)	Төмөр бетон бүтээц, өрлөг, заслын ажил, хаалга, цонх суурилуулах ажил, дээвэр, гадна ханын дулаалга болон будгийн ажлыг 100% гүйцэтгэнэ.	Нарийн засвартай сараалж ба агааржуулагчтай элс баригчийн өрлөг, засалын ажил, дулаалга, цонх суурилуулах, дээврийн ажил мөн холбогдох тоноглолын ажлууд хийгдсэн.	90%
4	1.2.3 Анхдагч тунгаагуурын хуваарилах камер (DC04)	Үндсэн бүтээц болон гадна ханын дулаалгын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Анхдагч тунгаагуурын хуваарилах 2 байгууламжийн үндсэн төмөр бетон бүтээцийн ажил, гадна ханын дулаалга болон засал, дээврийн бетон, төмөр бетон гадна шат, хамгаалалтын хашлага, бариул угсрах ажлуудыг гүйцэтгэсэн.	100%
5	1.2.4 Анхдагч тунгаагуур ба лагийн насосын станц (DC05)	Мембран дээврийн угсралт, өрлөг, гадна ханын дулаалга, хаалга, цонх суурилуулах ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Анхдагч тунгаагуурын лагийн насосны станц, лаг хадгалах сангийн 2 байгууламжийн үндсэн бүтээц, өрлөг, гадна болон дотор засал, хаалга, цонх суурилуулах ажил, 4 тунгаагуурын барилгын үндсэн бүтээц, гадна заслын ажлуудыг гүйцэтгэсэн. Мембран дээврийн ажил хийгдээгүй.	70%
6	1.2.5 Өндөр хүчин чадалтай анхдагч тунгаагуур (DC06)	Өрлөг, дотор засал, хаалга, цонх суурилуулах болон гадна фасад, дээврийн ажлуудыг барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 100% гүйцэтгэнэ.	Өндөр хүчин чадалтай анхдагч тунгаагуурын барилгын өрлөг, дотор засал, гадна ханын дулаалга болон фасадны засал, хаалга, цонх, аваарын шат, хамгаалалтын хашлага угсрах ажил, төмөр бетон тоног төхөөрөмжийн суурь, тунгаагуурын бетон дүүргэлт, ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэгийн ажлуудыг гүйцэтгэсэн.	100%
7	1.2.6 Хойд биореактор (DC07A)	Биореакторын туслах байгууламжууд болох дэд станц, үнэргүйжүүлэх систем, агааржуулах хоолойн сувгийн угсралт, гадна хана болон дээврийн дулаалгын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Биореакторын дэд станцын өрлөг заслалын ажлууд, дээвэр, дулаалгын ажлууд агааржуулах хоолойн сувгийн ажлууд дууссан. Дээврийн дулаалга, парапет ханын боон холбогдох тоноглолын ажлууд мөн хийгдсэн. Улирлын нөхцлөөс шалтгаалан усан туршилт хойшилж, бусад жижиг ажлууд хийгдэж байна.	90%
8	1.2.7 Урд биореактор (DC07B)	Гадна хана болон дээврийн дулаалга, дотор ханын хамгаалах түрхлэгийн ажлуудыг гүйцэтгэнэ.	Урд аэротенкийн барилгын дээврийн дулаалгатай бетон, дотор хана, таазанд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, дээвэр болон дээврийн люкний хамгаалалтын хашлага угсрах ажлуудыг гүйцэтгэсэн. Ус нэвчилтийн асуудлыг тодорхойлох хөндлөнгийн лабораторийн туршилт, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулахтай холбоотойгоор гадна ханын дулаалга	90%

			болон буцаан булалтын ажил хийгдээгүй байна.	
9	1.2.8 Хоёрдогч тунгаагуурын хуваарилах камер (DC08)	В хуваарилахын төмөр бетон бүтээцийн ажлыг 100% дуусгах, хоёр хуваарилах камерын гадна ханын дүүргэлт болон заслын ажлуудыг гүйцэтгэнэ.	Хоёрдогч тунгаагуурын хуваарилах 2 байгууламжийн үндсэн төмөр бетон бүтээцийн ажил, гадна ханын дулаалга, шавардлага болон эмульс хийх, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, дээврийн дулаалгатай бетон цутгалтын ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
10	1.2.9 Хоёрдогч тунгаагуур (DC09)	В, D тунгаагуурын халиагуурын сувгийн төмөр бетон бүтээцийн ажлыг дуусгах, нийт 8 тунгаагуурын гадна дулаалга, заслын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Хоёрдогч 8 тунгаагуурын байгууламжийн төмөр бетон үндсэн бүтээцийн ажил, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, гадна хананд хар тосон түрхлэг хийх, төслийн түвшин хүртэл буцаан булалт хийх ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
	1.2.10 Гүн цэвэрлэгээний тунгаагуур (DC10)	Өрлөг, гадна ханын дулаалга болон дотор засал, усан сангийн хананд хамгаалах түрхлэг хийх ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Гүн цэвэрлэгээний тунгаагуурын барилгын 4 камерт бетон дүүргэлт, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, урд, хойд шатны хонгил болон насосны өрөөний дотор хана, таазны заслын ажлууд, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, дээврийн хамгаалалтын хашлага болон тунгаагуурын гадна хананд хар тосон түрхлэг хийх, төслийн түвшин хүртэл буцаан булалтын ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
	1.2.11 Хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх байр (DC11)	Гадна ханын дүүргэлт, хаалга, цонх суурилуулах, дотор засал, гадна хана болон дээврийн дулаалга зэрэг ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх өрөөний барилгын гадна ханын дүүргэлт, гадна хананд дулаалга, шавардлага, эмульс хийх, дотор хана, таазны заслын ажлууд, дээврийн ажлууд, усан сангийн бетон дүүргэлт болон ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, хаалга, цонх, аваарын шат угсрах ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
<b>1.3 Лаг боловсруулах байгууламжуудын барилга угсралтын ажил</b>				
	1.3.1 Лаг өтгөрүүлэгчийн хуваарилах камер (DC20)	Бүтээцийн ажлыг дуусгаж, гадна ханын дулаалга, заслын ажлуудыг 100%-д хүргэнэ.	Лаг өтгөрүүлэгчийн хуваарилах камерын үндсэн төмөр бетон бүтээц, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
	1.3.2 Лаг өтгөрүүлэгч (DC21)	Дээврийн мембран бүтээцийн угсралтын ажил, гадна ханын дулаалга болон дотор ханын хамгаалах түрхлэгийн ажлуудыг гүйцэтгэнэ.	Лаг өтгөрүүлэгч 2 тунгаагуурын шалны бетон тэгшилгээ, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, В тунгаагуурын гадна хананд дулаалга, шавардлага, эмульс хийх ажлуудыг гүйцэтгэсэн. Тусгай технологийн ажлаар тул тунгаагуурын мембран дээвэр болон А тунгаагуурын гадна хана, заслын ажлууд улирлын нөхцлөөс шалтгаалан хойшилж байна. Мембран дээврийн ган бүтээцийн материалын татан авалт хийсэн.	70%
	1.3.3 Лаг боловсруулах байгууламж (DC22)	Гадна ханын дүүргэлт, хаалга, цонх суурилуулах, дотор засал, гадна хана болон дээврийн	Лаг боловсруулах байгууламжийн гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, тоног төхөөрөмжийн суурь,	90%

		дулаалга ажлуудыг гүйцэтгэнэ.	зэрэг 100%	хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан. Лаг хадгалах 2 сангийн байгууламжийн гадна ханын дулаалга, шавардлага, дээврийн дулаалгатай бетон цутгалт, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, дээврийн хамгаалалтын хашлага, гадна шатны бариул угсрах ажлуудыг гүйцэтгэсэн.	
	1.3.4 Метантенкийн холбох цамхагийн ажил (DC23)	Өрлөг, дотор засал, хаалга, цонх суулгах ажил болон гадна ханын дулаалга, будгийн ажлуудыг гүйцэтгэнэ.		Метантенкийн холбох цамхгийн барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх суурилуулах, 1-р давхрын төмөр бетон шал цутгах ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
	1.3.5 Метантенкийн ган бүтээцийн ажил (DC23)	4 ш метантенкийн дулаалга, өнгөт хавтангаар өнгөлөх ажлуудыг гүйцэтгэнэ.	100%	4ш метантенкийн гадна дулаалга, өнгөт ган хавтангаар бүрэх ажлыг хийж дууссан бөгөөд нийт 10,469.232 м2 дулаалга, бүрээсийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
	1.3.6 Метантенкийн тоног төхөөрөмж суурилуулалтын ажил (DC23)	4 ш метантенкийн холигч угсрах ажлыг гүйцэтгэнэ.		4ш метантенкийн тоног төхөөрөмж болох холигчийг угсарч дууссан бөгөөд 4ш өндөр нам даралтын хамгаалалтын төхөөрөмж болон аянга зайлуулагчийг суурилуулсан байна.	100%
	1.3.7 Био хий хүхэргүйжүүлэгч (DC25)	Дээвэр болон гадна ханын дулаалга, өрлөг, хаалга, цонх суулгах зэрэг дотор заслын ажлуудыг гүйцэтгэнэ.	100%	Био хий хүхэргүйжүүлэгчийн барилгын гадна ханын дүүргэлтийн өрлөг, төмөр бетон шал, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
	1.3.8 Био хий хадгалах сав (DC26)	Био хий хадгалах мембран савны угсралт болон суурийн буцаан булалтын ажлыг гүйцэтгэнэ.		Био хий хадгалах савны суурийн буцаан булалт, нягтруулалтын ажлыг гүйцэтгэсэн.	50%
	1.3.9 Био хий шатаах цамхаг (DC27)	Газар шороо, төмөр бетон үндсэн бүтээц, барилга угсралтын ажлыг 100% хийж гүйцэтгэнэ.		Био хий шатаах цамхгийн газар шороо, төмөр бетон суурийн ажлыг гүйцэтгэсэн.	50%
	1.3.10 Бойлер генераторын өрөө (DC28)	Бойлер генераторын өрөөний барилгын өрлөг, дотор засал, дээвэр болон гадна ханын дулаалга зэрэг ажлуудыг 100% гүйцэтгэнэ.		Бойлер генераторын барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
	1.3.11 Лаг усгүйжүүлэх өрөө ба лагийн насосын станц (DC29)	Өрлөгийн ажил, хаалга, цонх суурилуулах болон шаврын ажлууд, дээвэр болон гадна ханын дулаалгын ажил, шалны бетон цутгалтын ажлуудыг барилга угсралтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.		Лаг усгүйжүүлэх байрны гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, 1-р давхрын төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан. Лаг хадгалах сангийн байгууламжийн гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн дулаалгатай	90%



			бетон цутгалт, дотор хананд ус нэвчилт, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх, дээврийн хамгаалалтын хашлага, гадна шатны бариул угсрах ажлуудыг гүйцэтгэсэн.	
<b>1.4 Гаргалгаа сувгийн угсралтын ажил (DC52)</b>				
	1.4.1. Тэгш өнцөгт хэлбэрийн 2706м сувгийн ажил, ф2200мм-ын ган хоолойг гаргалгааны сувагтай холбох, дотор ус тусгаарлагчийн ажил хийх	2706м тэгш өнцөгт сувгийн барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.	Тэгш өнцөгт хэлбэрийн 3050м сувгийн төмөр бетон угсралтын ажил, ф2200мм-ын ган хоолойг гаргалгааны сувагтай холбох ажил, дотор, гадна ус тусгаарлагчийн ажил бүрэн дууссан.	100 %
	1.4.2.Одоо байгаа суваг, шинэ тэгш өнцөгт сувгийн огтлолцол-1, огтлолцол-2-ын угсралтын ажил	Одоо байгаа суваг, шинэ сувгийн хуваарилах камерын угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.	Одоо байгаа суваг, шинэ тэгш өнцөгт сувгийн огтлолцол-1, огтлолцол-2-ын төмөр бетон угсралтын ажил, гадна, дотор ус тусгаарлагчийн ажил, шифр хаалт угсралт бүрэн дууссан.	100 %
	1.4.3. Авто замын ус гаргуур 1, 2-ын угсралтын ажил	Гаргалгааны шугамын үндсэн тэгш өнцөгт сувгийн авто замын ус гаргуур 2-ын барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.	Авто замын ус гаргуур 1, Авто замын ус гаргуур 2-ын төмөр бетон угсралтын ажил бүрэн дууссан.	100 %
	1.4.4. Тэгш өнцөгт сувгийн хамгаалалтын хашлага, нөхөн сэргээлтийн ажил	Тэгш өнцөгт сувгийн хамгаалалтын хашлага хийх, нөхөн сэргээлтийн ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Тэгш өнцөгт сувгийн хамгаалалтын хашлага 50% гүйцэтгэсэн. нөхөн сэргээлтийн ажлуудыг 100% гүйцэтгэсэн.	70%
<b>1.5 Бохир ус цэвэрлэгээ болон лагийн байгууламжуудын битүүмжлэлийг шалгах усан туршилтын ажил</b>				
	1.5.1 Бохир ус болон лагийн сангийн байгууламжуудын битүүмжлэл шалгах усан туршилтын ажил	Бохир ус цэвэрлэгээний усан сан болон лаг хадгалах сан нийт 29 байгууламжийн битүүмжлэл шалгах усан туршилтын ажлыг гүйцэтгэнэ.	Бохир ус цэвэрлэгээний усан сангууд, лаг боловсруулах байгууламжуудын лаг хадгалах сангуудын битүүмжлэл шалгах усан туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Ус нэвчилт үүссэн байгууламжуудад төслийн зураг төсөл зохиогч байгууллагаас баталж ирүүлсэн технологийн аргачлалын дагуу засварын ажлыг гүйцэтгэсэн. Оношлогоо нарийвчлах болон дахин туршилтаар нэвчилтийн асуудлыг шалгах, асуудал үүссэн тохиолдолд засварлах, ажлууд хийгдэнэ.	70%
<b>1.6 Туслах барилга байгууламжуудын барилга угсралтын ажил</b>				
	1.6.1 Агааржуулах станцын барилга (DC12)	Систем тулаас буулгах, суурийн буцаан булалт хийх, гадна ханын дүүргэлтийн өрлөг, заслын ажил, дээвэр болон гадна фасадны дулаалгын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Агааржуулах станцын барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан.	100 %

1.6.2	Урьдчилсан цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөө (DC13)	Гадна ханын дүүргэлтийн өрлөг, заслын ажил, дээвэр болон гадна фасадны дулаалгын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Урьдчилсан цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөөний барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, цахилгааны суваг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан.	100 %
1.6.3	Гүн цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөө (DC14)	Өрлөг, дотор засал, гадна хана болон дээврийн дулаалгын ажлуудыг барилга угсралтын ажлын төлөвлөгөөний дагуу 100% гүйцэтгэнэ.	Гүн цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөөний барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, цахилгааны суваг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан.	100 %
1.6.4	Бохир усны насосны станц (DC17)	Суурийн буцаан булалт, нягтруулалтын ажлыг гүйцэтгэнэ.	Бохир усны нэгдсэн насосны станцын барилгын суурийн буцаан булалт, нягтруулалтын ажлыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.5	Аваарийн сан (DC18)	Газар шороо, төмөр бетон үндсэн бүтээцийн ажлыг 100% гүйцэтгэнэ.	Аваарийн сангийн барилгын газар шорооны ажил, суурийн доод хэсгийн шугам хоолой, төмөр бетон худгийн ажлуудыг гүйцэтгэсэн.	30%
1.6.6	Хаалт худаг (DC19)	Худгийн барилга угсралт болон тоног төхөөрөмж суурилуулах ажлуудыг 100% хийж гүйцэтгэнэ.	Хаалт худгийн ажлыг гүйцэтгэж дууссан.	100 %
1.6.7	Захиргааны байр (DC41)	Захиргааны барилгын өрлөг, дотор засал, гадна фасад, дотор шугам хоолой, цахилгааны кабелийн монтажны ажлуудыг бүрэн дуусгаж, Улсын комиссыг ажиллуулах бэлтгэл ажил хангасан байна.	Захиргааны байрны гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, дотор хана, таазны засал, шаланд плита наах, паркет хийх, цэвэр, бохир, галын ус, халаалтын босоо, хэвтээ шугам угсрах, өрөөнүүдэд радиатор суурилуулах, цахилгааны кабелийн дотор монтаж хийх, бүх давхруудад хаалга, цонх суурилуулах, цонхны тавцан суурилуулах, шатны хонгилын плита наах, хашлага, бариул угсрах, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ус тусгаарлах түрхлэг, дулаалга, бетон тэгшилгээ, хийх, ус тусгаарлах хар цаас наах, дээврийн хамгаалалтын хашлага угсрах ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
1.6.8	Засварын байр, агуулах болон гараж (DC42)	Гадна ханын дүүргэлтийн өрлөг, заслын ажил, дээвэр болон гадна фасадны дулаалгын ажлуудыг бүрэн гүйцэтгэнэ.	Засварын байр, агуулах, гражийн барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэж дууссан.	90%
1.6.9	Дэд станц 35/10кВт (DC44)	Тоног төхөөрөмжийн суурь, гадна ханын дүүргэлтийн өрлөг, заслын ажил, дээвэр болон гадна фасадны	35/10кВт-ын дэд станцын барилгын гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, цахилгааны сувагчлал, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх,	90%

		дулаалгын ажлуудыг бүрэн гүйцэтгэнэ.	аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэсэн.	
1.6.10	Дэд станц №1-4 (DC46-49)	Дэд станц №1, 3-ын төмөр бетон бүтээц, дотор засал, гадна хана болон дээврийн дулаалга, дотор тоног төхөөрөмж суурилуулах ажлуудыг барилга угсралтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.	10/0.4кВТ-ын дэд станцын 4 барилгуудын (DC46, DC47, DC48, DC49) гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, 1-р давхрын төмөр бетон шал, цахилгааны сувагчлал, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, хаалга, цонх, аваарын шат суурилуулах, дээврийн ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.11	Харуулын байр №1, 2 (DC50-51)	Газар шороо, төмөр бетон бүтээц, заслын ажлуудыг 100% хийж гүйцэтгэнэ.	Харуулын байрны 2 барилгын (DC50, DC51) газар шороо, төмөр бетон үндсэн бүтээц, дүүргэлтийн өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.12	Нэвтрэх суваг (DC53)	Газар шороо, төмөр бетон бүтээцийн ажлуудыг бүрэн гүйцэтгэнэ.	Дулаан, цэвэр ус, галын усны шугам хоолой байрлах 3663м урт төмөр бетон нэвтрэх сувгийн газар шороо, төмөр бетон үндсэн бүтээц, гадна ханын дулаалга, буцаан булалт, угсармал төмөр бетон таг ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.13	Дулаан хуваарилах төв (DC54)	Гадна ханын дүүргэлт, дотор засал, гадна хана болон дээврийн дулаалгын ажлуудыг бүрэн дуусгаж, Улсын комиссыг ажиллуулах бэлтгэл ажил хангана.	Дулаан хуваарилах төвийн барилгын гадна дүүргэлтийн өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.14	Баруун дулаан хуваарилах төв (DC56)	Газар шороо, төмөр бетон бүтээц, заслын ажлуудыг 100% дуусгаж, Улсын комиссыг ажиллуулах бэлтгэл ажил хангана.	Баруун дулаан хуваарилах төвийн барилгын газар шороо, төмөр бетон үндсэн бүтээц, дүүргэлтийн өрлөг, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	100 %
1.6.15	Үнэргүйжүүлэх системийн барилга А, В, С (DC55)	А болон В үнэргүйжүүлэхийн барилгын төмөр бетон бүтээц, гадна ханын дүүргэлт, дотор засал, гадна хана болон дээврийн дулаалгын ажлуудыг барилга угсралтын ажлын төлөвлөгөөний дагуу 100% гүйцэтгэнэ.	Үнэргүйжүүлэх системийн 3 барилгуудын (DC55А, В, С) төмөр бетон үндсэн бүтээц, гадна ханын дүүргэлт, дотор тусгаарлах ханын өрлөг, (А барилгын) төмөр бетон шал, тоног төхөөрөмжийн суурь, дотор хана, таазны засал, гадна ханын дулаалга, шавардлага, эмульс хийх, дээврийн ажлууд, хаалга, цонх, аваарын шат суурилуулах ажлуудыг гүйцэтгэсэн.	90%
<b>1.7 Төслийн гадна цахилгаан хангамжийн ажил</b>				
1.7.1	35кВ-ын хоёр хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажил	35кВ-ын ЦДАШ-ын ажлыг дуусган дотор ажиллагаанд залгаж, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангана.	35кВ-ын ЦДАШ-н анкер болон завсрын тулгууруудын ажил бүрэн дууссан. 10кВ-ын агаарын шугамтай зөрлөг дээр 2 тулгуурын хооронд утас татагдаагүй хүлээгдэж байна.	90%
1.7.2	35/10кВ-ын 2*10МВА чадалтай дэд станцын	35кВ-ын дэд станцын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг дуусган холболт хийж,	35/10кВ-ын хаалттай станцын Дэд станцын барилгын ажлын бүрэн дууссан. Реле хамгаалалтаас бусад тоноглолуудын татан авалт хийгдсэн. Хүчний трансформатор болон 10кВ,	70%

	барилга угсралтын ажил	улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангана.	0,4кВ-ын тоноглолуудын угсралтын ажил хийгдэж байна.	
	1.7.3 Төв цэвэрлэх байгууламжийн шинээр төлөвлөж буй авто замтай огтлолцох ЦДАШ-ыг шилжүүлэх ажил	110кВ-н 117а ЦДАШ-ын 27, 28 дугаар тулгуурыг хүчитгэх, 118-р ЦДАШ-ын 8 дугаар тулгуурыг сольж өндөрлөх ажлыг гүйцэтгэнэ. Өвлийн их ачааллаас өмнө холболтын ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангана.	Төв цэвэрлэх байгууламжийн шинээр төлөвлөж буй авто замтай огтлолцох ЦДАШ-ыг шилжүүлэх ажилд 110кВ-н 117а ЦДАШ-ын 27, 28 дугаар тулгуурыг хүчитгэх, 118-р ЦДАШ-ын 8 дугаар тулгуурыг сольж өндөрлөх ажил бүрэн дууссан улсын комисс ажиллахаар хүлээгдэж байна.	100 %
1.8 Холбоо мэдээллийн шилэн болон физик кабелийн сувагчлалын ажлыг бүрэн дуусгаж төв серверт холбох ажил				
	1.8.1 Гадна холбооны худаг сувагчлал, физик кабелийн угсралтын ажил	Төслийн талбай дундуур физик кабель татах, сувагчлал болон захиргааны барилга руу оруулж төв серверт холбох ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангана.	“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-иас D-U2023/654 тоот техникийн нөхцөл гаргуулж “Сителеком” ХХК-иар барилга угсралтын ажил гүйцэтгүүлсэн. Нийт сувагчлалын урт 1250м. Төслийн талбай дундуур татах сувагчлал болон захиргааны барилга руу оруулсан.	100 %
	1.8.2 Гадна холбооны шилэн кабель татах ажил	Шилэн кабелийн ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс ажиллуулах бэлтгэл хангана.	Шинэ цэвэрлэхийн автомат хяналт удирдлагыг УСУГ-ын төв диспетчерээс хяналт хийх боломжийг хангаж нийт 16км 24 корын шилэн кабель татах ажлыг хийж гүйцэтгэсэн. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-нд актаар баталгаажуулж хүлээлгэн өгөхөөр бэлдэж байна.	100 %
1.9 Байгууламжийн технологийн шугам хоолойн угсралтын ажил				
	1.9.1 Бохир усны ф1800мм, ф1400мм оролтын коллекторын ажил	Оролтын хос коллекторын барилга угсралтын ажлыг дуусган, Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангана.	Гадна ариутгах татуургын оролтын ф1500мм болон ф1800мм-ийн хос коллекторын барилга угсралтын ажилд нийт 18ш төмөр бетон худаг угсрагдаж дууссан. Үйлдвэрийн бохир усны ф1500мм-ийн төмөр бетон хоолой, Х7, Х6 дугаар худаг хоорон одоо байгаа цэвэрлэх байгууламжийн хуучин захын насосны станцын оролтын ф1200мм-ийн шугамтай давхцсан хэсэгт ф1000мм-ийн төмөр бетон хос хоолой сүвлэх ажлын хамт нийт 475у/м төмөр бетон хоолойн угсралтын ажил бүрэн дууссан. Ахуйн бохир усны ф1800мм-ийн төмөр бетон шугам хоолойн ажлаас 375у/м хийгдэхээс 314.3у/м суваг шуудуунд нээлттэй аргаар, Х11*, Х12 худгуудын хооронд 60.7у/м сүвлэх аргаар хийхээр төлөвлөснөөс 58у/м сүвлэх ажил хийгдэж нийт барилга угсралтын ажил 99.6% байна	100 %
	1.9.2 Байгууламжийн доторх бохир усны шугам хоолойн ажил	Байгууламж доторх бохир усны 9 ажил 1953у/м шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	Ф1000мм диаметртэй шугам хоолойноос 112у/м угсрагдахаас 80у/м угсрагдсан ба үлдэгдэл 32у/м шугам хоолой нь одоо байгаа цэвэрлэх байгууламжийн гаргалгааны сувагтай огтлолцож байгаа тул шинэ цэвэрлэх байгууламж бүрэн ашиглалтад орсны дараа хийгдэхээр төлөвлөсөн. Ф800мм-	90%

			ийн диаметртэй шугам хоолойноос 180у/м хийгдэхээс 180у/м, Ф600мм-ийн шугам хоолойноос 1308,5у/м хийгдэхээс 1308,5у/м, ф400мм-ийн шугам хоолойноос 503у/м хийгдэхээс 503у/м, ф300мм-ийн шугам хоолойноос 211у/м хийгдэхээс 211у/м тус тус хийгдсэн. Шинэ цэвэрлэх байгууламжийн хүрээнд дээрхи диаметрүүдтэй нийт 3585,5у/м шугам хоолойг угсрагдахаас 2023 онд 1271у/м мөн 2024 онд 2282,5у/м шугам хоолойн барилга угсралтын ажил хийгдэж атираат хоолойн нийт гүйцэтгэл 96,4%-тай байна	
1.9.3	Технологийн шугам хоолойн ажил	Технологийн шугам хоолойн угсралтын ажлын үлдэгдэл 90%-ийг дуусгаж системийн бин битүү байдлын туршилтыг хийнэ.	Технологийн шугам хоолойн барилга угсралтаас ф200-ийн ган хоолой 18,7у/м, ф300мм-ийн ган хоолой 373у/м, ф400мм-ийн ган хоолой 259у/м, ф500мм-ийн ган хоолой 16у/м, ф600мм-ийн ган хоолой 107у/м, ф700мм-ийн ган хоолой 77,8у/м, ф1000мм-ийн ган хоолой 446,2у/м, ф1200мм-ийн ган хоолой 135,5у/м, ф1400мм-ийн ган хоолой 890,4у/м, ф1600-ийн ган хоолой 92,8у/м, ф2000мм-ийн ган хоолой 72у/м, ф2200мм-ийн ган хоолой 219,34у/м шугам хоолойн барилга угсралтын ажил тус тус хийгдсэн. Технологийн шугам хоолойн барилга угсралтын ажил нийт 3411,04у/м хийгдэхээс 2023 онд 703,3у/м хийгдсэн ба 2024 онд үлдэгдэл 2707,74у/м шугам хоолойн барилга угсралт хийгдэж нийт гүйцэтгэл 100%-ий байна.	100 %
1.9.4	Агаарын шугам хоолойн ажил	Агаарын станцаас А, В биореактор хүртэл, мөн урд болон хойд биореакторын агаарын хоолойн угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.	DC12 буюу агаарын станцаас DC07A, В биореактор хүртэл ф1800мм зэвэрдэггүй ган хоолойн угсралтын ажилд нийт 128у/м угсрагдахаас DC12 агаарын станц дотор 30у/м шугам хоолойн угсралт болон холболтын ажил хийгдсэн. Агаарын станцаас биореактор хүртэл 98у/м шугамын тулгуурын ажил хийгдэж байна.	30%
1.9.5	Байгууламжийн цэвэр усан хангамж ажил	Цэвэр усан хангамжийн шугам сүлжээний ажлыг бүрэн дуусгаж, системийн бин битүү байдлын туршилтыг хийнэ.	Цэвэр усны усны ф200мм-ийн диаметртэй шугам хоолойн угсралт 1250у/м хийгдэж гүйцэтгэл нь 62,5%, Эргэлтийн усны ф200мм-ийн диаметртэй шугам хоолойд 1250у/м угсралт хийгдэж гүйцэтгэл нь 45,57%-тай байна.	50%
1.9.6	Лаг зайлуулах шугам сүлжээний ажил	Идэвхит лаг болон түүхий лагийн шугам хоолойн угсралтын ажлуудыг 100% гүйцэтгэнэ.	Суваг доторх технологийн шугам хоолойн угсралтын ажлуудаас химийн лагийн ф200мм диаметртэй 725,5у/м шугам угсрагдаж гүйцэтгэл нь 100%, түүхий лагийн ф400мм диаметртэй 149у/м, ф300мм диаметртэй 74,2у/м тус тус угсрагдаж гүйцэтгэл нь 100%, илүүдэл лагийн ф350мм, ф300мм диаметртэй 815,5у/м угсрагдаж гүйцэтгэл нь 100%, хөөс зайлуулах ф150мм диаметртэй 120у/м шугам угсрагдаж гүйцэтгэл нь 100%, үйлдвэрийн усны түүхий лагийн ф300мм	100 %

			диаметртэй 81,6у/м шугам угсрагдаж гүйцэтгэл нь 100%-тай байна.	
	1.9.7 Галын усны системийн угсралт, галын гидрант угсралт суурилуулалтын ажил	Галын усны системийн ажлыг бүрэн дуусгаж, шугамын туршилтыг хийн, галын гидрантуудыг угсарна.	Галын усны ф200мм диаметртэй 3200у/м шугам угсрах ажлаас 1080у/м шугам хийгдэж гүйцэтгэл нь 33,75%-тай байна.	30%
<b>1.10 Дулааны шугам сүлжээ</b>				
	1.10.1 Төвийн дулааны ерөнхий магистрал шугамын 2-р хэсгийн барилга угсралтын ажил.	Төвийн дулаан ерөнхий магистрал шугамын 2-р хэсгийн шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгаж, Улсын комисс ажиллуулах бэлтгэлийг хангана.	Шинэ цэвэрлэх байгууламжийн төслийн хүрээнд нэвтрэх суваг дотор 1-р хэлхээ болон 2-р хэлхээний шугам сүлжээний барилга угсралтын ажил нийт 8777.2у/м шугам сүлжээ угсрагдана. Үүнд: Өгөх шугам ф200мм-ээс 128у/м гүйцэтгэл нь 100%, ф150мм-ээс 1320у/м гүйцэтгэл нь 100%, ф100мм-ээс 36.3у/м гүйцэтгэл нь 100%, ф80мм-ээс 891у/м гүйцэтгэл нь 95.51%, буцах шугам ф300мм-ээс 24у/м гүйцэтгэл нь 100%, ф200мм-ээс 414у/м гүйцэтгэл нь 100%, ф150мм-ээс 409.4у/м гүйцэтгэл нь 100%, ф125мм-ээс 956у/м гүйцэтгэл нь 100%, ф100мм-ээс 860у/м гүйцэтгэл нь 79.3%, ф80мм-ээс 460у/м гүйцэтгэл нь 86.96%, ф70мм-ээс 648.5у/м гүйцэтгэл нь 88.28%, ф50мм-ээс 2630у/м 100% ба өгөх, буцах шугамын барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл нь 95.97%-тай байна.	90%
	1.10.2 Лаг боловсруулах хэсгийн гадна шугам сүлжээний ажил	Лаг боловсруулах хэсгийн гадна дулааны шугам хоолойн барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.		90%
	1.10.3 Үнэргүйжүүлэх хэсгийн гадна дулааны шугам сүлжээний ажил	Үнэргүйжүүлэх хэсгийн гадна дулааны шугам хоолойн барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.		90%
<b>1.11 Талбайн доторх зам талбай, гэрэлтүүлэг, гадна тохижилтын ажил</b>				
	1.11.1 Талбайн өндөржилт, газар шорооны ажлыг гүйцэтгэх	Төслийн барилга угсралтын талбайн 60%-д буцаан булалт хийж, нягтруулалтын ажлыг гүйцэтгэнэ.	Төслийн талбайн 60 хувьд шороон дүүргэлт, буцаан булалт, нягтруулалтын ажлыг гүйцэтгэсэн. Захиргааны барилгын хойд хэсгийн цэцгийн мандал, автомашины зогсоол болон бетонон талбай нийт 3500 м2 талбайд тохижилтын ажил хийсэн. Талбайн төв хаалга, нийт 1620 м урт төмөр бетон суурьтай, зэвэрдэггүй ган хоолойн баганатай хамгаалалтын торон хашааны угсралтын ажлыг гүйцэтгэж дууссан.	90%
	1.11.2 Орц гарцны гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэх	Орц гарцны авто болон явган замын дагуу гэрэлтүүлгийн ажлыг барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 100% гүйцэтгэнэ.	Талбайн ерөнхий гэрэлтүүлэг болон дотор авто, явган зам дагуу гэрэлтүүлгийн угсралтын ажил хийгдэж байна. Цутгамал төмөр бетон суурьтай 25м өндөр гэрэлтүүлгийн цамхгийг 11ш төлөвлөснөөс 4ш төмөр бетон суурийн ажил гүйцэтгэж, 2ш гэрлийн цамхгийг суурилуулсан. Зам дагуу 95ш гэрлийн шонгийн угсармал төмөр бетон суурь суурилуулж, 85ш гэрлийн шонг угсарсан. Гэрлийн шонг угсрах ажил үргэлжлэн хийгдэж байна. Орц гарцны гэрэлтүүлгийн ажил хийгдээгүй байна.	50%
<b>Зорилт 2-Тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлын хүрээнд</b>				
<b>2.1 Тоног төхөөрөмжийн татан авалт, угсралт болон туршилт тохируулгын ажил</b>				
	2.1.1 Тоног төхөөрөмжийн татан авалтыг зохион байгуулах,	Бохир ус цэвэрлэгээ, лаг боловсруулах болон бусад туслах байгууламжуудын үлдсэн тоног	Шинэ цэвэрлэх байгууламжийн төслийн хүрээнд нийт 241 нэр төрлийн тоног төхөөрөмж татан угсарч суурилуулахаас 159 нэр төрлийн тоног төхөөрөмжийн угсралт 100% хүрсэн, 92.3%-тай нэг,	70%

	угсралт суурилуулалтын ажил	төхөөрөмжүүдийн татан авалтын ажлыг зохион байгуулж, угсралт суурилуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.	90,6%-тай нэг, 87.6%-тай нэг, 50%-тай гурав, 49.3%-тай нэг, 25%-тай нэг ба тоног төхөөрөмжийн нийт угсралтын ажлын гүйцэтгэл 69.7%-тай байна.	
	2.1.2 Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын ажил	Тоног төхөөрөмжийн туршилтын ажлыг дуусган, бохир ус хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.	DC08 Хоёрдогч тунгаагуурын 8ш хамуур, DC03 агааржуулалттай элс баригчны оролт гаралтын шибер хаалт, DC17, угсралт туршилтын ажил дууссан. DC01, DC03, DC04, DC05, DC06, DC07, DC09, DC10, DC11, DC12, DC13, DC14, DC20, DC21, DC22, DC23, DC24, DC25, DC28, DC29 барилгуудын тоног төхөөрөмжийг угсарч үе шатны тохируулгуудыг хийж байна. Цахилгааны үндсэн тэжээл, технологийн шугамын холболт, усан туршилт зэрэг ажлуудтай уялдуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	30%
<b>Зорилт 3-Дотоод ажил</b>				
<b>3.1 Тайлан, төлөвлөгөө</b>				
	3.1.1 Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах	Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна.	Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.	100 %
	3.1.2 Төслийн 2024 оны Барилга угсралтын ажлын төлөвлөгөө батлуулах	Төслийн 2024 оны Барилга угсралтын ажлын төлөвлөгөөг батлуулна.	Төслийн 2024 оны Барилга угсралтын ажлын төлөвлөгөөг батлуулсан.	100 %
	3.1.3 Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлуулах	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлантай холбоотойгоор 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна.	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн байгаль орчны менежментийн 2023 оны тайланг авч, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Экологийн бүтээмж ХХК”-иар хийлгүүлж батлуулсан. Мөн 2024 оны 09 дүгээр сарын 24-нд төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар орж батлуулсан.	100 %
	3.1.4 Төслийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр гаргах	Төслийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр гаргана.	2024 оны төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг хасаг бүтэн билээр гарган ХББОСЯ ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100 %
	3.1.5 Төслийн тайланг БХБЯ, НЗДТГ, УСУГ-т улирал тутам хүргүүлэх	Төслийн тайланг БХБЯ, НЗДТГ, УСУГ-т улирал тутам хүргүүлнэ.	Төслийн тайланг БХБЯ, НЗДТГ, УСУГ-т улирал тутам хүргүүлсэн.	100 %
	3.1.6 Шилэн дансны тухай хуулийн дагуу	Шилэн дансны хэрэгжилтийг хангаж	Шилэн дансны хэрэгжилтийг хангаж хуулийн хугацаанд нь мэдээллийг бүрэн оруулсан.	90%

	төслийн нэгжийн мэдээллийг цаг тухай бүр оруулах	хугацаанд нь мэдээллийг оруулна.		
	3.1.7 Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн мэдээллийг удирдлагын мэдээллийн систем /Odamis/-д оруулах	Төслийн ажлын явцын тайлан мэдээ хэрэгжилтийн мэдээллийг тухай бүр системд оруулна.	Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн мэдээллийг удирдлагын мэдээллийн систем /Odamis/-д Төслийн ажлын явцын тайлан мэдээ хэрэгжилтийн мэдээллийг тухай бүрд бүрэн оруулсан.	100 %
<b>3.2 Санхүү, нягтлан бодох</b>				
	3.2.1 Үндэсний аудитын газраас баталгаажсан 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлдэж, СЯ, БХБЯ-нд хүргүүлэх	БХБЯ,СЯ-нд тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ.	Санхүүгийн 2023 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, Үндэсний аудитаар "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан.Холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулж хуулийн хугацаанд хүргүүлсэн	100 %
	3.2.2 Санхүүгийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж СЯ,БХБЯ-нд хүргүүлэх, СЯ-ны Өрийн удирдлагын газартай тооцоо нийлэх	БХБЯ,СЯ-нд тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ.	Санхүүгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж БХБЯ болон СЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлсэн	100 %
	3.2.3 Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт, Монголын талын хөрөнгийн санхүүжилтийг СЯ-ны Өрийн удирдлагын хэлтэстэй хагас жил, улиралаар тооцоо нийлж баталгаажуулах	БХБЯ,СЯ-нд тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ.	БХБЯ болон СЯ-ны өрийн удирдлагын хэлтэстэй хагас жилээр тооцоог нийлж, баталгаажуулсан	100 %
	3.2.4 Сар, улирал бүр НДШ тайлан, ХХОАТ-ын тайланг гаргаж холбогдох	ЧД-ийн татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэст тайланг хүргүүлнэ.	Сар улирал болгон татварын тайлан, НДШ-ийн тайланг хүргүүлж төлбөр тооцоог шилжүүлж ажилласан	100 %



	газруудад хүргүүлэх			
	3.2.5 Санхүүгийн өдөр тутмын гүйлгээг цаг хугацаанд хийж, шилэн дансанд мэдээллийг хугацаа алдалгүй байршуулж ажиллах	Санхүүгийн программ, Сангийн яамын портал сайт, шилэн дансы сайтад мэдээллийг оруулна.	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж ажилласан, сангийн яамны портал сайт ашиглаж өдөр тутмын гүйлгээг цаг хугацаанд нь шилжүүлж санхүүгийн программд мэдээллийг байршуулж ажилласан	90%
<b>3.3 Худалдан авах ажил</b>				
	3.3.1 Төв цэвэрлэх байгууламжийн шинээр төлөвлөж буй авто замтай огтлолцох ЦДАШ-ыг шилжүүлэх ажил	110кВ-н 117а ЦДАШ-ын 27, 28 дугаар тулгуурыг хүчитгэх, 118-р ЦДАШ-ын 8 дугаар тулгуурыг сольж өндөрлөх худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.	Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 29 ны өдрийн 38 дугаар тушаалаар төслийн Монголын талын хөрөнгө батлагдсаны дагуу БХБ-ын сайдын 2024 оны 56 дугаар тушаалаар Монголын талын төсөл, арга хэмжээний задаргаа батлагдсан. Төв цэвэрлэх байгууламжийн шинээр төлөвлөж буй автозамтай огтлолцох ЦДАШ-ыг шилжүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг нээлттэй, цахимаар харьцуулалтын аргаар зохион байгуулж 2024.04.10 нд үнэлгээний хороо байгуулагдаж, 2024.05.22 нд урилга нийтлэн, 2024.06.26 нд "Концептка питал солюшнз" ххк шалгарч гэрээ байгуулсан.	100%
	3.3.2 Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслэл	Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авах ажлыг зохион байгуулж, ИТА нарт олгоно.	ХББОСЯ-наас 2024 оны 09 дүгээр сарын 05 ны өдрийн 09/442 тоот албан бичгээр ТХН-ийн зохицуулагчид гэрээ байгуулах эрх олгогдсон. Төслийн нэгжийн ажилчдад Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар нээлттэй цахимаар зохион байгуулж 2024.06.14 нд Үнэлгээний хороо байгуулагдаж, 2024.07.22 нд Урилга нийтлэгдэн, 2024.08.15 нд "Хотулун бэхи" ххк шалгарч гэрээ байгуулсан.	100%
<b>3.4 Гадаадын ажиллах хүч</b>				
	3.4.1 Гадаадаас ажиллах хүч оруулж ирэх ажлыг зохион байгуулах, холбогдох зөвшөөрлүүдийг авах	Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 360 дугаар тогтоолоор 2024 онд Монгол улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоосон. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 477 дугаар тогтоолоор 2024 онд төслийн ажилд шаардлагатай 749 гадаадын мэргэжилтэн, ажилчдыг ажлын байрны төлбөрөөс	Тайлант хугацаанд нийт 601 гадаадын мэргэжилтэн, ажилчдыг Монгол улсад оруулж ирсэн. Үүнээс төслийн удирдлагын багт 67, барилга угсралтын талбайд 534 инженер техникийн болон бусад ажилчид ажиллаж ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн. 2025 онд төслийн ажилд шаардлагатай гадаадын ажиллах хүчний төлөвлөгөөг боловсруулж ХББОСЯ-аар батлуулсан ба тус онд шаардлагатай нийт 336 мэргэжилтэн, ажилчдыг Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 157/24 албан тоотоор ХББОСЯ-нд хүргүүлээд байна. Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны	100%

		чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Холбогдох байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг авч, ажиллах хүчний төлөвлөгөөний дагуу нийт 749 гадаадын мэргэжилтэн, ажилчдыг Монгол улсад оруулж ирэх ажлыг зохион байгуулна.	өдрийн 182 дугаар тогтоолоор Монгол улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ батлагдсан.	
<b>3.5 Сургалт</b>				
	3.5.1 УСУГ-ын инженер техникийн ажилчдыг чадавхжуулах дотоод сургалт	Шинэ цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, технологийн аюулгүй ажиллагаа, хэвийн горимд оруулах бэлтгэл ажлын хүрээнд УСУГ-ын инженер техникийн ажилчдыг үйлдвэрлэл болон технологийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.	Шинэ цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, технологийн аюулгүй ажиллагаа, хэвийн горимд оруулах бэлтгэл ажлын хүрээнд инженер техникийн ажилчдыг батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу дараах 5 сэдвийн хүрээнд /Онолын мэдлэг олгох сургалт, ХАБЭА-ын сургалт, Том завсартай сараалж ба оролтын насос станц болон нарийн завсартай сараалж ба агааржуулалтай элс баригчийн технологийн сургалт, Гүн цэвэрлэгээний өндөр хүчин чадалтай тунгаагуурын системийн технологийн сургалт, Үйлдвэрийн өндөр хүчин чадалтай анхдагч тунгаагуурын системийн технологийн сургалтыг/ 2024 оны 09 дүгээр сараас эхлэн 7 хоног бүрийн лхагва гаригт давтагдсан тоогоор 116 УСУГ-ын инженер техникийн ажилчдыг 21 цагийн сургалтад хамруулсан байна.	100 %
	3.5.2 УСУГ-ын инженер техникийн ажилчдыг чадавхжуулах гадаад сургалт	Автоматикийн систем, лаг боловсруулах болон био хий үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр УСУГ-ын инженер техникийн ажилчдыг чадавхжуулах 2 удаагийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.	Эхний сургалтыг 2024 оны 3 дугаар сарын 15-28-ны өдрүүдэд "Лаг боловсруулах болон био хий үйлдвэрлэлийн технологи"-ийн чиглэлээр зохион байгуулж УСУГ-ын инженер техникийн 9 ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулж чадамжийн сертификат олгов. 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ны өдрийн хооронд БНХАУ-ын Ханжоу хотод "Автоматикийн систем" сэдвийн хүрээнд УСУГ-ын 8 инженер техникийн ажилчдыг хамруулан зохион байгуулсан.	100 %
	3.5.3 Ажил олгогч, удирдах ажилтны сургалт	Тухайн жилийн шаардалагатай ХАБЭА-н сургалтын төлөвлөгөөг 8 цагаар батлуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхлэхээс өмнө болон угсралтын ажлын явцад 2 удаагийн төслийн талбайд ажиллаж байгаа бүх удирдах болон ИТА-дыг хамруулна.	2024 оны 03 дугаар сарын 19, 2024 оны 05 дугаар сарын 20-нд төслийн талбайд Ерөнхий гүйцэтгэгчээс 2024 оны ХАБЭА-н төлөвлөгөөний дагуу төслийн ХАБЭА-н хууль тогтоомж, дүрэм, журам стандартыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, МШӨ-нөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай суурь мэдлэг, чадварыг эзэмшүүлэх тус бүр 8 цагийн нийт 16 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд төслийн нэгж, зураг төслийн байгууллагууд, БХТ-ийн ИТА, ерөнхий гүйцэтгэгч болон туслан	100 %

			гүйцэтгэгчдийн нийт 32 инженерүүд, менежерүүд хамрагдав.	
3.5.4	Нийт ажилтны сургалт	Тухайн жилийн шаардалагатай ХАБЭА-н сургалтын төлөвлөгөөг 12 цагаар батлуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхлэхээс өмнө болон угсралтын ажлын явцад 2 удаагийн төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилтнуудыг хамруулна.	2024 оны 04 дугаар сарын 24, 2024 оны 05 дугаар сарын 20-нд нийт ажилтнуудын сургалтын сэдвийн хүрээнд аюулгүй ажиллах хандлага төлөвшүүлж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н мэдлэг олгох тус бүр 12 цагийн нийт 24 цагийн сургалтад ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчдийн Монгол давтагдсан тоогоор нийт 180 ажилтнууд хамрагдав. Мөн энэ хугацаанд төслийн талбайд ажиллаж буй БНХАУ-ын ажилтнуудад аюулгүй үйл ажиллагааны сургалтыг 35 удаа зохион байгуулсан бөгөөд үүнд 571 ажилтнууд хамрагдсан.	100 %
3.5.5	Бусад сургалт	Тухайн жилийн шаардалагатай ХАБЭА-н сургалтын төлөвлөгөөг нийт 27 цагаар батлуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхлэхээс өмнө болон угсралтын ажлын явцад 2 удаагийн төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилтнуудыг хамруулна.	2024 оны 05 дугаар сарын 07-нд СХД-ийн ОБХ-ээс Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний 2 цагийн болон барилгын талбайн галын аюулгүй байдлыг хангаж ажиллах, гал унтраах хэрэгсэл, тоноглолын бэлэн байдал, гал унтраах аврах хэсгийн нэгж бүрэлдэхүүн байгуулах, гал унтраах хэрэгслийг ажиллуулж сургах 2 цагийн нийт 4 цагийн сургалтын зохион байгуулсан ба сургалтанд төслийн гүйцэтгэгч компанийн нийт 46 ИТА болон ажилчид хамрагдав. 2024 оны ХАБЭА-н сарын аяны болон ХАБЭА-н төлөвлөгөөний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 20-нд, 2024 оны 08 дугаар сарын 17-нд төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй Монгол улсын ажилтнуудад Мэргэжлийн сургалт, зөвлөх үйлчилгээний “Хаан хулд” сургалтын төвөөс Өргөх, зөөх, тээвэрлэх механизм /ӨЗТМ/-тай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сэдвийн хүрээнд талбайн аюулыг илрүүлэх, хяналт тавих арга, аюулгүй ажиллагааг хангах, зохион байгуулах, барилгын угсралтын үеийн аюулгүй ажиллагаа болон тоног төхөөрөмж, ажлын байрны аюулгүй ажиллагааны сэдвийн хүрээнд тус бүр 7 цагийн, нийт 14 цагийн сургалтад энхий удаа 10, дараагийн удаа 8 оосорлогч-дохиочин, краны операторууд, өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сэдвийн хүрээнд өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, анхан шатны тусламжийн нийт 8 цагийн сургалтад ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчдийн 18 удирдах ажилтнууд хамрагдав. 2024 оны 05 дугаар сарын 20-нд төслийн талбайд цахилгааны аюулгүй байдлын чиглэлээр нийт 8 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд ерөнхий гүйцэтгэгч болон туслан	100 %

			гүйцэтгэгчдийн нийт 14 ажилтнууд хамрагдав.	
<b>3.6 Бичиг хэрэг</b>				
		2024 онд төсөл хэрэгжүүлэх нэгжид ирсэн албан бичгийг хүлээн авч, тус бүр "Бүртгэл хяналтын карт" хөтөлж, дэвтэрт бүртгэж, цахим архив үүсгэх, төслийн удирдлагаар цохолт хийлгэн, холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлж шийдвэрлүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.	2024 онд гадны байгууллагаас төсөл хэрэгжүүлэх нэгжид ирсэн нийт 216 албан бичгийг хүлээн авч, тус бүр "Бүртгэл хяналтын карт" хөтөлж, дэвтэрт бүртгэж, цахим архив үүсгэх, төслийн удирдлагаар цохолт хийлгэн, холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлж шийдвэрлүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.	
	3.6.1 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн архив, албан хэрэг хөтлөлт	явуулсан албан бичигт огноо, бүртгэлийн дугаар олгож, "Явуулсан баримт бичгийн бүртгэл"-ийн дэвтэрт бүртгэж, цахим архив үүсгэж, харилцагч байгууллагаас хариу албан бичиг ирүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.	2024 онд төслийн нэгжээс харилцагч байгууллагад явуулсан нийт 208 албан бичигт огноо, бүртгэлийн дугаар олгож, "Явуулсан баримт бичгийн бүртгэл"-ийн дэвтэрт бүртгэж, цахим архив үүсгэж, харилцагч байгууллагаас хариу албан бичиг ирүүлсэн эсэхэд хяналт тавьж ажилласан байна.	90%
		Жилийн эцэст 2024 оны хөтлөгдөж дууссан албан бичгийг цэгцэлж, товъёог үйлдэж, үдэж хавтаслан архивт шилжүүлэх ажлыг хийнэ.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны ирсэн болон явуулсан хөтлөгдөж дууссан албан бичгийг бүрэн цахим хэлбэрт оруулан хадгалахаас гадна дугаарын дагуу цэгцэлж, товъёог үйлдэж, үдэж хавтаслан ажлыг хийж эхлээд байгаа бөгөөд 2024 он бүрэн дууссаны дараа хийж дуусгахаар байна. Мөн 2024 оны 11 дүгээр сард "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-д бүртгүүлэн байгууллагын харилцах албан бичгийг цахимжуулах ажлыг хийж байна.	
		Удирдлагаас өгсөн ажил үүргийн дагуу тухай бүр ТУХ-ны хурал болон бусад ТХН-ийн холбогдолтой хурлын бэлэн байдлыг хангаж, хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулж ажилласан байна.	Удирдлагаас өгсөн ажил үүргийн дагуу 2024 онд нийт 5 удаагийн ТУХ-ны хурал болсон бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулах материалыг бэлтгэж, хурлын бэлэн байдлыг хангаж, хурлын тэмдэглэл хөтөлж албажуулах ажлыг хийсэн байна. Мөн төсөл хэрэгжүүлэх нэгж болон холбогдох байгууллагуудтай хийсэн хурлын тэмдэглэлийг он цагийн дарааллаар хадгалах, хавтаслах ажлыг хийж ажилласан.	
	3.6.2 Хөлсөөр ажиллах гэрээ сунгах, шинэчлэн байгуулах ажил	2024 оны ТУХ-ны хурлын тогтоолоор ТХН-ийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний нэмэлт, өөрчлөлтийг хийсэн байна.	Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний 4 дүгээр тушаалаар батлагдсан журам болон 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Төслийн удирдах хорооны хурлын холбогдох тогтоол, зөвлөмж шийдвэрийн хүрээнд 2024 оны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн	100 %

		Сангийн сайдын 2024 оны 01 сарын 23-ны А/12 "Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжил төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын нэмэлт заалтын хүрээнд ТХН-ийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэн байгуулна.	ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээнд "Гэрээний нэмэлт, өөрчлөлт" хийх буюу гэрээ сунгаж ажилласан. Мөн Сангийн сайдын 2024 оны 01 сарын 23-ны А/12 "Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжил төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулж төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалин хөлсөнд өөрчлөлт орсон, хөлсөөр ажиллах гэрээний загвар шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэн байгуулах, батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	
	3.6.3 Хөлсөөр ажиллах гэрээг үнэлж дүгнүүлэх ажил	2024 оны төсөл хэрэгжүүлэх нэгжийн нийт 17 ажилтнуудын "Хөлсөөр ажиллах гэрээ үнэлэх хуудас"-ыг нэгтгэн бэлтгэж, удирдлагаар үнэлж дүгнүүлэн ТУХ-ны хуралд танилцуулах ажлыг хийнэ.	2024 оны төсөл хэрэгжүүлэх нэгжийн нийт 17 ажилтнуудын "Хөлсөөр ажиллах гэрээ үнэлэх хуудас"-ыг нэгтгэн бэлтгэж, удирдлагаар үнэлүүлж, Төслийн удирдах хорооны хуралд танилцуулж батлуулсан байна.	100 %

"Үр дүнгүй" буюу 30%-ийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. Арга хэмжээ 1.6.5 Аваарийн сан (DC18)  
Зорилтот түвшин: Газар шороо, төмөр бетон үндсэн бүтээцийн ажлыг 100% гүйцэтгэнэ.
2. Арга хэмжээ 1.9.4 Агаарын шугам хоолойн ажил  
Зорилтот түвшин: Агаарын станцаас А, В биореактор хүртэл, мөн урд болон хойд биореакторын агаарын хоолойн угсралтын ажлыг 100% гүйцэтгэнэ.
3. Арга хэмжээ 1.9.7 Галын усны системийн угсралт, галын гидрант угсралт суурилуулалтын ажил  
Зорилтот түвшин: Галын усны системийн ажлыг бүрэн дуусгаж, шугамын туршилтыг хийн, галын гидрантуудыг угсарна.
4. Арга хэмжээ 2.1.2 Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын ажил  
Зорилтот түвшин: Тоног төхөөрөмжийн туршилтын ажлыг дуусган, бохир ус хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. Арга хэмжээ 1.3.8 Био хий хадгалах сав (DC26)  
Зорилтот түвшин: Био хий хадгалах мембран савны угсралт болон суурийн буцаан булалтын ажлыг гүйцэтгэнэ.
2. Арга хэмжээ 1.3.9 Био хий шатаах цамхаг (DC27)  
Зорилтот түвшин: Газар шороо, төмөр бетон үндсэн бүтээц, барилга угсралтын ажлыг 100% хийж гүйцэтгэнэ.
3. Арга хэмжээ 1.9.5 Байгууламжийн цэвэр усан хангамж ажил  
Зорилтот түвшин: Цэвэр усан хангамжийн шугам сүлжээний ажлыг бүрэн дуусгаж, системийн бин битүү байдлын туршилтыг хийнэ.
4. Арга хэмжээ 1.11.2 Орц гарцны гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэх  
Зорилтот түвшин: Орц гарцны авто болон явган замын дагуух гэрэлтүүлгийн ажлыг барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 100% гүйцэтгэнэ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн 2024 онд төслийн нийт хэрэгжилтийн түвшин 91 хувь, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний

хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Төслийн удирдах хорооны 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 2023/02 тоот тогтоолоор төслийн барилга угсралтын дуусах хугацааг 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасан байна.

Төслийн нийт санхүүжилт 262.7 сая ам.доллар ба 2024 оны байдлаар нийт 221 сая ам долларын санхүүжилт олгож санхүүжилтийн гүйцэтгэл 84 хувьтай байна.

**ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

**"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн нэгж /Т.Болорчулуун/-д зөвлөмж болгох нь:**

1. Төслийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан “Үр дүнгүй” буюу 30%-тай 4, “Эрчимжүүлэх шаардлагатай” 50%-тай 4 арга хэмжээг 2025 оны төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төслийн хэрэгжилтийн явцад үүссэн эрсдэлийг бууруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан, Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

3. Усан туршилтаар нэвчилт үүссэн барилга байгууламж болон туршилт хийгдээгүй байгаа усан орчинд ажиллах байгууламжид дотоодын болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар төмөр бетон бүтээцийн ашиглалт, бат бэх, аюулгүй байдал, ашиглалтын үеийн байдал насжилтийн талаар нарийвчилсан судалгаа, тооцоо хийлгэх, дүгнэлт гаргуулж цаашид хэрхэн засварлах, хүчитгэх талаар баталгаат аргачлалыг тодорхойлуулж хэвийн байдлыг хангуулах;

4. Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламж ашиглалтад орсны дараа түүний ашиглалтын хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллах инженер техникийн ажилтнуудыг төсөл хэрэгжих хугацаанд бэлтгэх, дагалдуулан сургах, давтан сургах сургалтуудыг 2025 оны төсөв, төлөвлөгөөндөө тусган үе шаттай зохион байгуулах;

5. Төслийн нэгжийн 2025 оны төлөвлөгөөг холбогдох байгууллагатай уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч батлуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахад хяналт тавих, ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахыг НААБЗГ /О.Мөнхбаяр/-т, санхүү, хөрөнгө оруулалтын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг СХОГ /Ц.Ариунсанаа/-т тус, тус даалгасугай.

#### **8.4. Хавсралт-4**

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТ /БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТ/-ЫН САЙД БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ  
ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР  
2024 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.01.05

#### **НЭГ. ЗОРИЛГО**

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчтай 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

#### **ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлсэн талаар 2024 оны гэрээний хэрэгжилтийг гаргаж ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, аймаг, бүс тус бүрээр үнэлгээг гаргалаа.

## **А.ХАНГАЙН БҮСИЙН АЙМГУУД:**

### **1. Архангай аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **79** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 60, 90 хувьтай 1, 70 хувьтай 8, 50 хувьтай 6, 30 хувьтай 3, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт **90,1** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	16	7	1	3	4	1	-	68.3
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	26	-	1	-	1	-	96.4
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	14	-	4	2	1	-	86,2
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	-	-	-	-	-	100
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	2	-	-	-	-	-	100
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>		<b>79</b>	<b>60</b>	<b>1</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>90,1</b>

**“Үр дүнгүй” 30 хувьтай 3 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /5./ Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрын дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах;

2. /23./ Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангах;

3. /60./ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.15-д ..... хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт нь аймгийн чиг үүрэгт хамаарах тул үерийн гамшгаас хамгаалах далан, сувгийг төлөвлөх, ашиглах, ашиглалтад байгаа үерийн далан суваг, борооны ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ, лаг хагшаасыг тогтсон хугацаанд цэвэрлэдэг байх, цаашид ашиглалт, үйлчилгээ хариуцах байгууллагыг тодорхой болгон, үерийн эрсдэлээс сэргийлэх.

### **ДҮГНЭЛТ:**

Сайд болон Архангай аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **90,1** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах;

## **2. Баянхонгор аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **99** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 57, 90 хувьтай 4, 70 хувьтай 12, 50 хувьтай 0, 30 хувьтай 1, 0 хувьтай 0, үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна. Хэрэгжилт **96** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	16	12	-	3	-	-	-	92
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	17	2	7	-	1	-	88,9
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	19	16	2	1	-	-	-	97,4
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	-	1	-	-	-	94
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	2	-	-	-	-	-	100
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>		<b>76</b>	<b>57</b>	<b>4</b>	<b>12</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>96</b>

“Үр дүнгүй” 30 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. /29/ Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан байна.

### **ДҮГНЭЛТ:**

Сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **96** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Баянхонгор аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах;

## **3. Булган аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **83** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 60, 90 хувьтай 7, 70 хувьтай 5, 50 хувьтай 5, 30 хувьтай 0, 0 хувьтай 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт **91,8** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	



1	Хот байгуулалтын чиглэлээр	16	12	1	2	-	-	1	79.4
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	21	1	2	4	-	-	90.4
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	14	5	1	1	-	-	92.9
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	4	4	-	-	-	-	-	100
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	2	-	-	-	-	-	100
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>		<b>78</b>	<b>60</b>	<b>7</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>91.8</b>

“Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. /22/ Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх.

2. /24/ Барилга, хот байгуулалтын сайдын “Барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллах.

3. /25/ Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх.

4. /37/ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 1988 оны 167 дугаар конвенцыг бодлого үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжилтийг хангах, тайланг хүргүүлэх.

5. /65/ Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл /инженерийн шугам сүлжээ/-ийн эд хөрөнгийн бүртгэл, судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэж тогтмол баяжилт хийж байх.

“Үр дүнгүй” 0 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. /12/ Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлд авах, зориулалтын дагуу ашиглах, хамгаалах, хяналт тавих чиглэлээр хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээг авч ажиллах

#### **ДҮГНЭЛТ:**

Сайд болон Булган аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **91,8** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Булган аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах;

#### **4. Орхон аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **80** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 63, 90 хувьтай 13, 70 хувьтай 3, 50 хувьтай 0, 30 хувьтай 0, 0 хувьтай 0, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт **95,8** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	18	11	5	2	-	-	-	95
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	27	25	2	-	-	-	-	95,7
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	16	5	-	-	-	-	97,6
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	3	1	-	-	-	-	97,5
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	1	-	1	-	-	-	85
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>63</b>	<b>13</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>95,8</b>

#### ДҮГНЭЛТ:

Сайд болон Орхон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **95,8** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2024 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

#### 5. Өвөрхангай аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **82** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 47, 90 хувьтай 22, 70 хувьтай 8, 50 хувьтай 2, 30 хувьтай 0, 0 хувьтай 0, үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна. Хэрэгжилт **92,7** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	19	6	6	4	2	-	-	80.6
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	18	5	4	-	-	-	90.4
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	11	10	-	-	-	-	95.2
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	1	-	-	-	-	98
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	1	-	1	-	-	-	85
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>		<b>82</b>	<b>47</b>	<b>22</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>92,7</b>

“Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. /6/ МУ-ын ҮХ, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог боловсруулах ажлын хүрээнд холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах, БХБЯ-тай хамтран ажиллах;

2. /12/ Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах.

#### **ДҮГНЭЛТ:**

Сайд болон Өвөрхангай аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **92,7** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

#### **6. Хөвсгөл аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **85** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 23, 90 хувьтай 16, 70 хувьтай 22, 50 хувьтай 6, 30 хувьтай 7, үнэлэх боломжгүй 7 арга хэмжээ байна. Хэрэгжилт **80,1** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгэе %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	17	3	1	6	-	4	-	66,4
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	9	6	7	2	2	-	80,4
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	5	6	6	3	-	-	80
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	1	1	1	1	-	-	77,5
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	3	-	1	-	1	-	80
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендэрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	-	1	1	-	-	-	80
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	2	1	-	-	-	-	96,7
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>23</b>	<b>16</b>	<b>22</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>-</b>	<b>80,1</b>

**“Үр дүнгүй” 30 хувьтай 6 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /1/ Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах, хуулийг дагалдан норм стандарт, дүрэм, журмыг боловсруулахад хамтран ажиллах;

2. /4/ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах;

3. /9/ Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах;

4. /17/ Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг БХБЯ-тай хамтран хэрэгжүүлэх;

5. /24/ Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

6. /36/ Үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа байгууллага аж ахуй нэгжүүдэд барилга угсралтын талбайг камержуулах үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтийг хангуулж ажиллах;

7. /74/ Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах.

#### ДҮГНЭЛТ:

Сайд болон Хөвсгөл аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **80,1** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

#### ХАНГАЙН БҮСИЙН АЙМГУУДАД ӨГӨХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын сайд болон Хангайн бүсийн аймгуудын /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний нийт 475 арга хэмжээнээс 100 хувьтай 310, 90 хувьтай 63, 70 хувьтай 58, 50 хувьтай 19, 30 хувьтай 10, 0 хувьтай 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт **96** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харуулбал:

№	Аймгуудын нэр	арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Архангай	<b>79</b>	60	1	8	6	3	0	<b>90,1</b>
2	Баянхонгор	<b>76</b>	57	4	12	0	1	0	<b>96</b>
3	Булган	<b>78</b>	60	7	5	5	0	1	<b>91,2</b>
4	Орхон	<b>80</b>	63	13	3	0	0	0	<b>95,8</b>
5	Өвөрхангай	<b>82</b>	47	22	8	2	0	0	<b>92,7</b>
6	Хөвсгөл	<b>80</b>	23	16	22	6	6	0	<b>80,1</b>
<b>Хангайн бүсийн аймгуудын дундаж дүн</b>		<b>475</b>	<b>310</b>	<b>63</b>	<b>58</b>	<b>19</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>91.0</b>

#### БАРУУН БҮСИЙН АЙМГУУД:

#### 7. Баян-өлгий аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **80** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 48, 90 хувьтай 14, 70 хувьтай 9, 50 хувьтай 2, 30 хувьтай 7 арга хэмжээ байна. Хэрэгжилт **86.95** хувьтай “**Тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлж байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	16	6	4	2	1	3	-	77.5
2	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	22	12	4	4	-	2	-	86.3
3	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	20	3	2	1	2	-	90

4	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
5	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендэрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	-	2	-	-	-	-	90
6	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	3	1	-	-	-	-	97.5
7	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	-	1	-	-	-	94
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>48</b>	<b>14</b>	<b>9</b>	<b>2</b>	<b>7</b>	<b>-</b>	<b>86.95</b>

**“Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 2 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /7/ Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууц санг бүрдүүлэх, түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх захиалагчид газар, дэд бүтцийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх;

2. /17/ Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах.

**Хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай арга хэмжээ 7 байна. Үүнд:**

1. /8/ Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах;

2. /9/ Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3. /10/ Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг БХТ-тэй хамтран боловсруулж батлуулан иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах;

4. /23/ Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. /42/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6. /56/ Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай “Засгийн газрын 2012 оны 209 дүгээр тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэх;

7. /60/ Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрд гэр хорооллын 150-иас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

**ДҮГНЭЛТ:**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Баян-Өлгий аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **86.95** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

**САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Баян-Өлгий аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 2, хэрэгжилт хангалтгүй 7, нийт 9 арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

**8. Увс аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 76 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 34, 90 хувьтай 10, 70 хувьтай 26, 50 хувьтай 3, 30 хувьтай 1, 0 хувьтай 2 арга хэмжээ тус тус байна. Хэрэгжилт **86.4** хувьтай **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	17	7	2	5	1	-	2	75.3
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	25	10	2	12	1	-	-	82.8
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	19	8	4	6	1	-	-	85.8
4	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
5	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	1	1	-	-	-	-	95
6	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	1	1	2	-	-	-	82.5
7	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	6	4	-	1	-	1	-	83.3
<b>Дүн</b>		<b>76</b>	<b>34</b>	<b>10</b>	<b>26</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>86.4</b>

**“Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувьтай 3 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /17/ Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа сумдад өндөржилт төлөвлөлтийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, сумын хөгжлийн сан болон бусад техник туслалцаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах;

2. /37/ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 1988 оны 167 дугаар конвенцыг бодлого, үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжилтийг хангах, тайланг хүргүүлэх;

3. /56/ Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах.

**Хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай арга хэмжээ 1 байна. Үүнд:**

1. /69/ Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах.

**“Үр дүнгүй” 0 хувьтай 2 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /4/ Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнг хагас бүтэн жилээр үнэлэн тус яаманд ирүүлэх;

2. /5/ Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл” арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах.

## **ДҮГНЭЛТ:**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2023 оны гэрээний хэрэгжилт **86.4** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

## **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Увс аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 3, хэрэгжилт хангалтгүй 1, үр дүнгүй биелэлттэй 2, нийт 6 арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

## **9. Ховд аймаг**

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын сайд аймгуудын Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний биелэлтийг Ховд аймаг ирүүлээгүй байна.

## **10. Завхан аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 80 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 57, 90 хувьтай 4, 70 хувьтай 8, 50 хувьтай 6, 30 хувьтай 0, 0 хувьтай 5 арга хэмжээнүүд байна. Хэрэгжилт 86,5 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хот байгуулалтын чиглэлээр	16	9	1	4	1	-	1	82.5
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	18	3	3	3	-	1	86.8
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	22	17	-	-	2	-	3	81.8
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100.0
5	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	-	1	-	-	-	94.0
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендэрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	2	-	-	-	-	-	100.0
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100.0
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>57</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>86.5</b>

### **Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай 6 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /7/ Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууц санг бүрдүүлэх, түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх захиалагчид газар, дэд бүтцийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх;

2. /23/ Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3. /29/ Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах;

4. /43/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, салбарт тэдний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 17 дугаар зүйл/

5. /54/ Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх

6. /61/ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.15-д ..... хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт нь аймгийн чиг үүрэгт хамаарах тул үерийн гамшгаас хамгаалах далан, сувгийг төлөвлөх, ашиглах, ашиглалтад байгаа үерийн далан суваг, борооны ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ, лаг хагшаасыг тогтсон хугацаанд цэвэрлэдэг байх, цаашид ашиглалт, үйлчилгээ хариуцах байгууллагыг тодорхой болгон, үерийн эрсдэлээс сэргийлэх.

### **“Үр дүнгүй” 0 хувьтай 5 арга хэмжээ байна. Үүнд:**

1. /5/ Монгол Улсын Үндсэн хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог

боловсруулах ажлын хүрээнд холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах, БХБЯ-тай хамтран ажиллах;

2. /25/ Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;

3. /55/ Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийх;

4. /63/ Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгогдохгүй байх нөхцлийг бүрдүүлэн, ажлыг зохион байгуулах;

5. /64/ Аймгийн хэмжээнд үерийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбийг тогтоох, барьж байгуулах шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийг төлөвлөж хэрэгжүүлэх, иргэдийг үерийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах.

#### ДҮГНЭЛТ:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Завхан аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **86.5** хувьтай “**Тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Завхан аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 6, үр дүнгүй биелэлттэй 5, нийт 11 арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах;

#### 11. Говь-Алтай аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **81** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 65, 90 хувьтай 8, 70 хувьтай 4, 50 хувьтай 4 арга хэмжээ байна. Хэрэгжилт **95.1** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0 %	
1	Хот байгуулалтын чиглэлээр	18	16	2	-	-	-	-	98.88
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	26	-	-	2	-	-	96.42
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	10	5	4	2	-	-	87.14
4	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
5	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жөндөрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	2	-	-	-	-	-	100
6	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
7	Салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	5	4	1	-	-	-	-	98
<b>Дүн</b>		<b>81</b>	<b>65</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>95.1</b>

#### Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. /25/ Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. /38/ Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, барилгын чанарын



менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах;

3. /23/ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хүрээнд сумдын усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулж, Хууль зүйн яамны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх;

4. /57/ “Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх.

#### **ДҮГНЭЛТ:**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Говь-Алтай аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **97.2** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Говь-Алтай аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

#### **БАРУУН БҮСИЙН АЙМГУУДАД ӨГӨХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Баруун бүсийн аймгуудын /Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай/ Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний /Ховд аймгаас бусад/ нийт 317 арга хэмжээнээс 100 хувьтай 204, 90 хувьтай 36, 70 хувьтай 47, 50 хувьтай 15, 30 хувьтай 8, 0 хувьтай 7 арга хэмжээ байна. Хэрэгжилт **89.26** хувьтай “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын сайд аймгуудын Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний биелэлтийг Ховд аймаг ирүүлээгүй байна.

Баруун бүсийн аймгуудын хувьд хэрэгжилт хангалтгүй дараах ажлуудад анхаарч, 2025 оны гэрээндээ тусган хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Тухайлбал:

1. Баруун бүсийн аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 28, үр дүнгүй биелэлттэй 38, нийт арга хэмжээний нэршлээр давхцаж буй 66 арга хэмжээний биелэлтийг хангах, 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах;

2. Аймгууд батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ бүрийн биелэлтийг гаргах, хугацаандаа ирүүлэх;

3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын сайд болон Ховд аймгийн Засаг даргын хооронд байгуулах 2025 оны гэрээг байгуулахад 2024 оны гэрээний биелэлт ирүүлээгүйд холбогдох хууль тогтоомж, гэрээний хүрээнд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагад уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Батзаяа/-т зөвлөсүгэй.

#### **Баруун бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харуулбал:**

д/д	Аймгууд	Арга хэмжээ	Үнэлгээний хувь						Дүн
			100%	90%	70%	50%	30%	0%	
1.	Баян-Өлгий	80	48	14	9	2	7	0	86.95
2.	Увс	76	34	10	26	3	1	2	86.4
3.	Ховд		Гэрээний биелэлт ирүүлээгүй						
4.	Завхан	80	57	4	8	6	0	5	86.5
5.	Говь-Алтай	81	65	8	4	4	0	0	95.1
Баруун аймгуудын дундаж		<b>317</b>	<b>204</b>	<b>36</b>	<b>47</b>	<b>15</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>86.1</b>

#### **В. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУД:**

##### **12. Говьсүмбэр аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу нийт 80 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнээс 61 арга хэмжээ 100 хувьтай, 5 арга

хэмжээ 90 хувьтай, 7 арга хэмжээ 70 хувьтай, 2 арга хэмжээ 50 хувьтай, 2 арга хэмжээ 30 хувьтай, 3 арга хэмжээ 0 хувьтай байгаа бөгөөд хэрэгжилт **90.0** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлж байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0 %	
1	Хот байгуулалтын чиглэлээр	17	14	1	1	-	-	1	91.8
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	27	24	-	2	-	1	-	95.2
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	22	14	3	3	2	-	-	90.0
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	3	1	-	-	-	-	97.5
5	Салбарын хяналтын чиглэлээр	5	3	-	-	-	-	2	60.0
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендэрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	1	-	1	-	-	-	85.0
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	2	-	-	-	1	-	76.7
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>61</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>90.0</b>

Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай арга хэмжээ 6 байна. Үүнд:

1. /53/ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. /55/ Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийх .

Хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай арга хэмжээ 2 байна. Үүнд:

1. /26/ Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;

2. /80/ Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаар хамтарсан “Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

Үр дүнгүй” 0 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. /5/ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах;

2. /74/ Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах;

3. /75/ Улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах.

## **ДҮГНЭЛТ:**

Барилга, хот байгуулалтын сайд болон Говьсүмбэр аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилт **90.0** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

## **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

Говьсүмбэр аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 2, үр дүнгүй биелэлттэй 5, нийт 7 арга хэмжээг 2025 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

### **13. Дархан-уул аймаг**

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу нийт 81 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнээс 57 арга хэмжээ 100 хувьтай, 4 арга хэмжээ 90 хувьтай, 8 арга хэмжээ 70 хувьтай, 6 арга хэмжээ 50 хувьтай, 2 арга хэмжээ 30 хувьтай, 4 арга хэмжээ 0 хувьтай байгаа бөгөөд хэрэгжилт **86.2** хувьтай **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлж байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Үнэлгээ %
			100%	90%	70%	50%	30%	0 %	
1	Хот байгуулалтын чиглэлээр	18	12	-	1	4	1	-	83.3
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	28	22	1	4	-	-	1	91.8
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	21	12	3	3	2	1	-	86.2
4	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр	4	4	-	-	-	-	-	100
5	Салбарын хяналтын чиглэлээр	5	3	-	-	-	-	2	60.0
6	Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендэрийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр	2	1	-	-	-	-	1	50.0
7	Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр	3	3	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>		<b>81</b>	<b>57</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>86.2</b>

Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай арга хэмжээ 6 байна. Үүнд:

3. **/5/** Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах;

4. **/7/** Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолын дагуу “Улс орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө”-өөр баригдсан түрээслэх, түрээслүүлээд өмчлүүлэх зориулалт бүхий орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах хүрээнд тухай бүр иргэдийн хүсэлтийг авч, холбогдох журмын дагуу нээлттэй, ил тод шийдвэрлэж ажиллах, улирал бүр тус яаманд тайлан, мэдээ ирүүлэх;

5. **/17/** Төвлөрсөн инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, авто зам, төмөр замын хяналтын зурвас газрыг хууль тогтоомжид заасны дагуу тогтоон баталгаажуулах, Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх;

6. **/18/** Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа сумдад өндөржилт төлөвлөлтийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, сумын хөгжлийн сан болон бусад техник туслалцаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах;

